

**Төрийн Албан Хаагчдад Зориулсан МХХТ-ийн
Суурь Мэдлэгийн Академи**

МОДУЛЬ 1

**МХХТ-ийн хэрэглээ болон бодит хөгжлийн
харилцан хамаарал**

Уша Рани Вияасулу Редди

Төрийн албан хаагчдад МХХТ-ийн суурь мэдлэг олгох академийн модулиуд

Модуль 1: МХТ-ийн хэрэглээ болон бодит хөгжлийн харилцан хамаарал

Энэ номыг “Creative Commons Attribution 3.0 License” тусгай зөвшөөрлийн хүрээнд хэвлэсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://creativecommons.org/licenses/by/3.0/> үзнэ үү.

Энэхүү номонд тусгагдсан санал бодол, тоо баримт ба тооцоолол нь зохиогчийн байр суурийг илэрхийлсэн бөгөөд эдгээрийг НҮБ-ын байр суурийг илэрхийлсэн буюу НҮБ-ээс зөвшөөрөгдсөн баримт бичиг гэж ойлгож болохгүй.

Үүнд багтсан танилцуулгууд болон тэдгээрийн зохион байгуулалт нь НҮБ-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын зүгээс ямар нэгэн улсын хууль ёсны статус, нутаг дэвсгэр, хот суурин болон газар нутаг, эрх баригчид, тэдгээрийн хил хязгаартай холбоотойгоор баримтлаж буй үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.

Компануудын нэр, арилжааны бүтээгдэхүүнүүдийн нэрийг дурдсан нь НҮБ-ийн үзэл бодлын хүрээнд тусгагдаагүй болохыг анхаарна уу.

НҮБ-ын Хөгжлийн Төлөөх Мэдээлэл, Харилцаа Холбооны Технологийн Ази,
Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

Хаяг: Bonbudong, 3rd floor Songdo Techno Park
7-50 Songdo-dong, Yeonsu-gu, Incheon City
Republic of Korea

Утас: +82 32 245 1700002
Факс: +82 32 245 7712
И-мэйл: info@unapcict.org
Веб сайтын хаяг: <http://www.unapcict.org>

Copyright©UN-APCICT 2009

ISBN: 978-89-955886-4-2 [94560]

Хэвлэлийн эхийг Scandinavian Publishing Co Ltd, Studio triangle компани бэлтгэж,
Бүгд Найрамдах Солонгос Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

21 дүгээр зууныг даяаршиж буй дэлхий дээр амьдарч байгаа хүн төрөлхтөний хараат бус, бие даах чадварыг улам бүр нэмэгдүүлсэн гэж тооцдог. Энэ нь шинэ технологийн үр өгөөжийг сая сая хүмүүст амсуулж, ард иргэдийн амьдралыг эрс сайжруулж, ядруурлыг бууруулж чадах мэдээлэл, мэдлэгийн хүртээмжийг өргөжүүлэх бололцоог нээсэн цаг хугацаа билээ. Гэхдээ хараат бус байдал нь дангаараа бус хүн бүрт нээлттэй байх тогтвортой хөгжлийн төлөөх үнэ цэнэ, зорилт, эв нэгдлийн хамт өсөн нэмэгдэх бололцоотой.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувьд илүү давуу хөгжилтэй бүс нутаг болон хөгжиж байна. ОУЦХБ-ын тооцоолсноор тус бүс нутгийн телефон шугамын тоо хоёр тэрбумаас давж, хөдөлгөөнт холбооны хэрэглэгчийн тоо 1.4 тэрбумд хүрсэн үзүүлэлт гарчээ. 2008 оны хагас жилийн байдлаар дэлхийн нийт хөдөлгөөнт холбооны хэрэглэгчдийн дөрөвний нэг хувийг Хятад болон Энэтхэг улс эзэлсэн тооцоо гарсан. Дэлхийн интернэт хэрэглэгчийн 40-ийг Ази, Номхон Далайн бүс хамрах бөгөөд интернэтийн өргөн зурвасын дэлхийн зах зээлийн 39 хувийг эзэлж байгаа нь хамгийн том зах зээл гэсэн үг юм.

Технологийн ололт, амжилтуудын үр дүнд тоон хуваагдал арилсан боловч уу гэж таамаглахад хараахан арилж амжаагүй байгаа гэсэн хариулт гарч ирж байгаа нь харамсалтай. WSIS буюу Мэдээлэлжсэн Нийгмийн Дэлхийн Дээд Уулзалт /МНДДУ/ 2003 онд Женев хотноо зохион байгуулагдснаас хойш таван жилийн дараах нөхцөл байдлыг авч үзэхэд тус бүс нутаг технологийн ололт амжилтаар тэргүүлж байсан хэдий ч хүн амын олонх нь ялангуяа ядуу иргэд харилцаа холбооны үндсэн үйлчилгээг авч чадаагүй хэвээр байна.

Тус бүсийн 25 орон буюу голцуу жижиг арлын хөгжиж байгаа орнууд болон далайд гарцгүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 10 хүрэхгүй, эдгээр хэрэглэгчид нь ихэвчлэн томоохон хотод амьдардаг хотын оршин суугчид байхад нөгөө талаас тус бүсийн хөгжингүй орнуудын 100 хүнд ноогдох интернэт хэрэглэгчийн тоо нь 80 гаруй байгаа тооцоо гарчээ. Өргөн зурвасын үйлчилгээний хэрэглээний ялгаа бүр их байгаа юм байна.

Тус бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангахад МХХТ-ийн чадавхийг ашиглаж, тоон хуваагдлыг арилгахын тулд хөгжиж байгаа орнуудын бодлого боловсруулагчид МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбар болон иргэдийн МХХТ-ийн чадварыг хөгжүүлэх түншлэлийг дэмжих, тэргүүлэх ач холбогдол бүхий ажил, арга хэмжээг тодорхойлж, бодлого хэрэгжүүлэх, хууль эрх зүй болон зохицуулалтын орчинг тодорхойлох, төсөв, санхүүг оновчтой хуваарилах шаардлагатай юм.

МНДДУ –ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд “...хүн бүр мэдээлэлжсэн нийгэм болон мэдлэгт тулгуурласан эдийн засгийг ойлгох, оролцох, үр өгөөжийг хүртэхийн тулд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмших боломжтой байх ёстой...” гэж тусгасан. Уг төлөвлөгөөнд МХХТ-ийн мэргэжлийн боловсон хүчин, шинжээчдийг олноор нь төрүүлэх зорилгоор олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэхийг уриалсан байдаг.

Энэхүү уриалгын хүрээнд МХХТ-ийн АНДБ-ийн Сургалтын Төвөөс хөгжлийн зорилтод МХХТ-ийг ашиглах сургалтын хөтөлбөр боловсруулсан. Тус хөтөлбөр нь өөр хоорондоо уялдаа холбоотой 8 модулиас бүрдсэн бөгөөд бодлого боловсруулагчдад МХХТ-ийн санал, санаачилгыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох мэдлэг, мэдээлэл өгөх зорилготой юм.

Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь НҮБ-ийн Азийн эдийн засаг, нийгмийн хорооны бүсийн 5 байгууллагын нэг билээ. Азийн эдийн засаг, нийгмийн комисс нь Ази, Номхон далайн бүсэд дүн шинжилгээ, норматив үйл ажиллагаа, чадавхийг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагаа болон мэдлэг хуваалцах замаар тогтвортой, тэгш хамарсан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой юм. НҮБ-ийн бусад байгууллагууд, олон улсын байгууллагууд, үндэсний хэмжээний түншүүд, оролцогч талуудтай хамтран Азийн эдийн засаг, нийгмийн комисс нь Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвөөр дамжуулан энэхүү сургалтын модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, төрийн байгууллагуудын дээд болон дунд түвшний ажилтнуудад зориулсан бүсийн болон үндэсний хэмжээний семинаруудаар түгээх үйл явцыг хөхүүлэн дэмжиж, энэхүү үйл явцаар дамжуулан бий болсон чадавхи болон олж авсан мэдлэг нь хөгжлийн зорилтуудад нийцэхүйц МХХТ-ийн үр шим болон бодит үйл ажиллагааг бий болгох зорилготой байдаг юм.

Ноелиин Хэйзер

НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Орлогч Дарга бөгөөд
АНДБ-ийн Эдийн Засаг, Нийгмийн Комиссын Гүйцэтгэх Нарийн Бичгийн Дарга

УДИРТГАЛ

Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академи хэмээх цуврал модулийг боловсруулах үйл ажиллагаа нь бидэнд ихээхэн урам зориг өгсөн, бидний нүдийг нээн өгсөн үйл ажиллагаа, томоохон аялал байлаа. Академи нь зөвхөн МХХТ-ийн чадавхийг бэхжүүлэх үйл явцад буй орхигдсон зүйлсэд бус мөн иргэдийн оролцоо, үйл явцыг өөриймшүүлэх замаар сургалтын хөтөлбөр боловсруулах шинэ арга замыг бий болгох зорилготой байсан билээ.

Академи нь Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн тэргүүлэх хөтөлбөр бөгөөд бүс нутаг дахь 20 гаруй улсад хийгдсэн хэрэгцээний үнэлгээний үр дүн, төрийн байгууллагуудын ажилтнууд, олон улсын хөгжлийн нийгэмлэгийн гишүүд, эрдэмтэд болон судлаачидтай хийсэн зөвлөлдөх уулзалтуудын үр дүн; өнөөгийн хэрэглэж буй сургалтын материалын давуу болон сул талуудад хийгдсэн гүнзгийрүүлсэн судалгаа; Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн бүсийн болон дэд-бүсийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинаруудад оролцогчдын зүгээс модулийн агуулгын хоорондын хамаарал болон үр ашгийн талаар гаргасан саналууд; МХХТ-ийн салбарын олон тооны экспертүүдийн хийсэн судалгаа зэрэг дээр суурилан боловсруулагдсан билээ. Бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан Академийн сургалт/семинарууд нь өөр өөр улсуудаас ирсэн оролцогчдын хооронд мэдлэг, туршлагаа хуваалцах үнэлж баршгүй боломжийг ханган өгсөн бол энэхүү үйл явцаар мөн Академийн төгсөгчид модулиудыг сайжруулах боломжийг ч мөн ханган өгсөн билээ.

Академиас гаргасан анхан шатны 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх нь бүсийн хэмжээнд өнөөгийн түншлэлийг бэхжүүлэх, МХХТ-ийн хөгжлийн асуудлаар бодлого боловсруулагч нарын чадавхийг бэхжүүлэх шинэ түншлэлийг бий болгох боломжийг бий болгож байна. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Үндэсний академиудад бүх бодлого гаргагч нарт хүрч ажиллах гол хандлагаа хэрэгжүүлэх зорилгоор 8 модулийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх хүсэл эрмэлзлэлтэй байгаа билээ. Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь төв болон орон нутгийн засаг захиргаатай нэгэн сүлжээнд ажиллаж буй бүс нутгийн болон үндэсний хэд хэдэн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж тэдгээр нь өөрсдийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлд нийцүүлэн Академийн модулиудыг ашиглах, нутагшуулах, орчуулах, түгээх чадавхийг нь бэхжүүлдэг юм. Цаашид ч өнөөгийн модулиудыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх болон шинээр боловсруулах төлөвлөгөөтэй байгаа юм.

Түүнчлэн Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв нь Академийн боловсруулан гаргаж буй агуулгыг нь бүс нутгийн хэмжээнд илүү өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үйл явцыг баталгаажуулахын тулд олон суваг бүхий хандлагыг ашиглаж байна. Академийн агуулгыг бүс нутгийн болон үндэсний академиар дамжуулан нүүр тулсан байдлаар түгээн дэлгэрүүлэхээс гадна Хөгжлийн төлөөх МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төвийн Виртуал академийг байгуулан онлайн зайн сургалтыг бий болгон оролцогч нар сургалтын материалыг өөрийн боломжоор судлах бололцоог мөн хангаад байна. Виртуал академи нь бүх модулиуд, тэдгээрийн дагалдах материалууд болох танилцуулгууд, кейсүүдийг агуулж хялбархан нэвтрэн, ашиглах боломжийг хангасны зэрэгцээ татан авах, дахин ашиглах, өөрийн улсад нутагшуулах, нөхцөл байдалд нийцүүлэх боломжийг мөн хангадаг ба мөн виртуал лекцүүд, суралцах аргачлалууд, агуулга хөгжүүлэх аргачлалууд болон гэрчилгээжүүлэлт зэргийг мөн ханган өгсөн.

Анхан шатны цуврал 8 модуль, тэдгээрийг бүс нутгийн болон үндэсний Академийн сургалт/семинаруудаар түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа нь олон тооны хувьд хүмүүс, байгууллагуудын хичээл зүтгэл, оролцоогүйгээр амжилтад хүрэхгүй байсан юм. Энэхүү боломжийг ашиглан миний бие Академийн төгсөгчид, сургалт/семинаруудад оролцож байсан яамд, сургалтын байгууллагууд, бүс нутгийн болон үндэсний байгууллагуудад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Эдгээр талууд нь модулиудын агуулгад ихээхэн үнэтэй хувь нэмрийг оруулаад зогсохгүй, хамгийн чухал нь өөрийн улс оронд энэхүү Академийн төлөөлөл болон, энэ талаар нөлөөлөл үзүүлэн өөр өөрийн оронд Академийн курсуудыг нутагшуулахад Ази, Номхон Далайн бүсийн хөгжлийн төлөөх мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургалтын төв болон үндэсний болон бүс нутгийн түншлэгч байгууллагуудын хооронд албан ёсны гэрээ байгуулах боломжийг нээн өгсөн билээ.

Түүнчлэн миний бие энэхүү гайхалтай, урам зориг өгсөн аялалд маань өөрийн хувь нэмрийг оруулсан олон тооны хүмүүсийн хүчин чармайлтад талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Тэдний тоонд Академийн төслийн зөвлөх Шахид Ахтар, Редактор Патрисиа Аринто, Хэвлэн нийтлэх менежер Кристин Апикул, бүх зохиогч нар болон Академийн ажилтнууд багтаж буй юм.

Улс орнууд нийгэм- эдийн засгийн хөгжил, Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх, түргэтгэхийн тулд МХХТ-ийн хүний нөөцийн хомсдлыг бууруулах, МХХТ-ийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад тотгорыг бууруулах, МХХТ-ийн хэрэглээг дэмжихэд нь Академи өөр тус дэмийг үзүүлж чадна гэдэгт би бат итгэлтэй байна.

Хьюн-Сук Рии

МХХТХ-ийн АНДБНСТ-ийн захирал
Хөгжлийн төлөөх МХХТ-ийн Ази, Номхон Далайн Бүсийн Сургалтын Төв

ЦУВРАЛ МОДУЛИЙН ТУХАЙ

Өнөөдрийн “Мэдээллийн эрин” буюу мэдээлэлд хүрэх арга замыг хялбарчилж чадсан харилцаа холбооны технологийн шинэчлэл нь бидний аж амьдрал, ажил төрөл болон амралтын арга хэлбэрийг өөрчлөөд байгаа билээ. “Тоон эдийн засаг” буюу “мэдлэгийн эдийн засаг”, “харилцан хамаарал бүхий эдийн засаг” эсхүл “шинэ эдийн засаг” зэргээр нэрлэгдэж буй энэхүү эдийн засаг, улс орны хөгжил нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс илүүтэйгээр шинэ бүтээлч санааг зохион бүтээхэд шилжин өөрчлөгдөж буй өөрчлөлтөөр тодорхойлогдох болсон. Энэ нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд МХХТ-ийн гүйцэтгэж буй үүрэг өсөн нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Үүний үр дүнд дэлхийн улс орнууд, тэдгээрийн засгийн газар нь хөгжлийн зорилтуудыг хангахын тулд МХХТ-ийг ашиглах чиглэлээр түлхүү анхаарах болсон. Тэдгээр засгийн газруудын хувьд МХХТ-ийн үйлдвэрлэл эсхүл эдийн засгийн салбарыг зөвхөн хөгжүүлэхэд бус түүнчлэн эдийн засаг, улс төр болон нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахад МХХТ-ийн хэрэглээ чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиглагдсан.

Гэхдээ МХХТ-ийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход засгийн газрууд зарим нэг хүндрэл бэрхшээлтэй тулгардгийн нэг нь бодлого боловсруулагч нар улс орны хөгжлийг хөдөлгөхөд чухал үүрэг гүйцэтгэж буй шинэ техник, технологийн талаар мэдлэг хомс байгаа явдал юм. Нэгэнт хэн нэгний ойлгохгүй байгаа асуудлыг нөгөө нэг нь зохицуулж чадахгүй учир олонх бодлого боловсруулагчид МХХТ-ийн бодлогыг тодорхойлж, боловсруулахаас жийрхэх явдал бишгүй тохиолдоно. Гэхдээ техник технологийн мэргэжлийн хүмүүс МХХТ-ийн бодлогыг тодорхойлох нь бас явцуу, учир нь тэдгээр мэргэжлийн хүмүүс өөрсдийн зохион бүтээсэн, хэрэглэгчдийн хэрэглэж буй технологийг бодлогын талаас тайлбарлаж, үр нөлөөг таниулж мэдэхгүй байх талтай.

Иймд дараах албан хаагчид, ажилтнууд, мэргэжилтнүүдэд зориулан Төрийн удирдагч нарт МХХТ-ийн мэдлэгийг олгох Академийн цуврал модулийг НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ийн АНДБ-ийн сургалтын төвөөс боловсруулан толилуулж байна. Үүнд:

1. МХХТ-ийн бодлого боловсруулах асуудал эрхэлсэн үндэсний болон орон нутгийн хэмжээний бодлого боловсруулагч нар
2. МХХТ-д суурилсан хэрэглээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх асуудал эрхэлсэн засгийн газрын албан тушаалтнууд,
3. Төслийн удирдлага, зохион байгуулалтанд МХХТ-ийн хэрэгслүүдийг ашиглах зорилгоор ажиллаж буй төрийн байгууллагуудын менежерүүд.

Цуврал модуль нь хөгжлийн зорилтуудыг хангахад МХХТ-ийг ашиглахтай холбогдуулан бодлогын болон технологийн аль аль талаас нь авч үзэх шаардлагатай асуудлуудыг таниулах зорилготой. Гол нь МХХТ-ийн техникийн авлага боловсруулах бус харин орчин үеийн тоон технологийн хөгжил дэвшилд гүйцэтгэх үүрэг, үүнтэй уялдуулан авч хэрэгжүүлэх бодлогын асуудлуудын талаар ойлголт өгөх явдал юм. Цуврал модулиар хүргэх сэдвүүдийг дэлхийн олон улс оронд явуулсан сургалтуудын эрэлт хэрэгцээнд хийсэн шинжилгээ, судалгааны үндсэн дээр тодорхойлж боловсруулсан.

Эдгээр цуврал модулийг бие дааж судалж болохын зэрэгцээ сургалтын курс семинар эсхүл хөтөлбөр хэлбэрээр ашиглаж болно. Цуврал бүр өөр өөрийн гэсэн онцлог сэдвүүдээс бүрдэх боловч харилцан уялдаатай асуудлуудыг хөндсөн бөгөөд модуль тус бүрт байгаа сэдвүүдийг нөгөө модулиудтай уялдуулан ярилцах, ойлгуулах аргаар ашиглаж болно. Цуврал модулийн урт хугацааны зорилго нь нэг багц сэдэв болж гэрчилгээ авах бололцоог уншигч, судлагч нарт олгоно.

Модуль тус бүрийн эхэнд тухайн модулийн зорилго, үр дүн буюу уншиж судалсны дараа нөхцөл байдлыг үнэлж дүгнэх асуултуудыг тусгасан болно. Мөн модуль тус бүр нь тухайн сэдвийг гүнзгийрүүлэн ойлгох боломж олгох судалгаа, жишээ, дасгалуудаас бүрдсэн бүлгүүдэд хуваагдана. Дасгалыг дангаар бие дааж болон багаар хамтран ажиллан гүйцэтгэж болно. Тухайн яригдаж буй сэдвийн талаарх нарийн өгөгдөл, мэдээллүүдийг зураг болон хүснэгтээр харуулсан. Нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахад зориулан лавлах эх сурвалжууд болон интернэтийн хаягуудыг өгсөн болно.

Цуврал модулиудад тусгасан судалгаа, жишээнүүд нь өөр хоорондоо зөрчилтэй байж болох учир ХТМХХТ-ийг хэрэглэхэд олон талын асуудлууд гарч болзошгүй. Энэ нь улс орнууд МХХТ-ийн нөөц бололцоог хөгжлийн зорилтуудыг хангах хэрэгсэл болгон судалж буй энэ үед энэхүү шинээр үүсэн гарч буй мэдлэгийн салбарын үр өгөөж, нөгөө талаас тулгарч болох хүндрэл бэрхшээл юм.

Онлайн зайн сургалтын үед Академийн цуврал модулийг хэвлэмэл хэлбэрээр ашиглах ба Виртуал академи (AVA – <http://www.unapcict.org/academy>) нь сургагч багшийн хичээлийг дүрс бичлэгээр болон Power Point хэлбэрээр үзүүлж зохион байгуулна.

Үүний зэрэгцээ, Сургалтын төв (APCICT) нь МХХТ-ийн дадлага эзэмшигчид болон бодлого боловсруулагч нарын сургалт, туршлагыг бэхжүүлэх зорилгоор онлайн сургалтын цахим хуудас болох “e-Collaborative Hub for ICTD (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)” нээн ажиллуулж байна. Тус цахим хуудас нь хөгжлийн зорилтын төлөө МХХТ-ийг ашиглахад чиглэсэн төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжаар хангахын зэрэгцээ хамтран ажиллах, мэдлэг туршлага, солилцох чиглэлээр харилцан холбогдох боломж олгоно.

МОДУЛЬ 1

МХХТ болон МХЗ-уудын хоорондын уялдаа холбоо нь зарим тохиолдолд тодорхой, харин зарим үедээ ээдрээтэй мэт харагдана. Гэхдээ бодит байдал дээр энэхүү уялдаа холбоо байдаг бөгөөд үүнийг заримдаа сайжруулах, тайлбарлах шаардлага урган гарч ирдэг. Энэхүү модуль нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь гол салбаруудын хөгжлийн үйл явцад МХХТ-ийг хэрэглэсэн кейс судалгаануудаар дамжуулан уншигчдад энэхүү уялдаа холбооны олон төрөл цар хүрээний талаар судлах боломжийг олгох юм. Модуль нь мөн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхийн тулд МХХТ-ийг ашиглахтай холбоотой гол асуудлууд болон шийдвэрийн гол цэгүүд буюу бодлогоос хэрэгжилт хүртэл тодотгон авч үзэх юм. Үүний зорилго нь МХХТ нь хэрхэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үйл явцад хэрэглэгдэх талаар гүнзгийрүүлсэн ойлголт өгөх, бодлого боловсруулагчид болон хөтөлбөрийн удирдлагуудыг олон төрлийн нийгмийн салбаруудад МХХТ-д суурилсан, МХХТ-ийн дэмжлэгтэй хөгжлийн үйл ажиллагааны бүтцийн талаар мэдлэг олгох явдал билээ.

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Тус модуль нь дараахь зорилгуудыг агуулсан болно. Үүнд:

1. Хөгжлийн төлөөх МХХТ-ийн кейсийн талаар судлах;
2. МХЗ-ууд болон МХХТ-ийн макро хамаарлыг тайлбарлах;
3. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудад хүрэхэд МХХТ-ийг хэрхэн ашиглаж болох талаар илүү гүнзгий ойлголттой болох; болон
4. МХХТ-д суурилсан, МХХТ-ийн дэмжлэгтэй хөгжлийн үйл ажиллагааны бүтцийн талаар мэдлэг олгох.

СУРГАЛТААС ГАРАХ ҮР ДҮН

Тус модулийг судалж, танилцсанаар дараах мэдлэг, дадлыг эзэмшинэ. Үүнд:

1. Хөгжлийн зорилтод хүрэхэд МХХТ-ийг ашиглах учир холбогдлыг ойлгох;
2. МХХТ-ийг хөгжлийн гол салбарууд, ялангуяа ядуурлыг бууруулах, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хүйс, засаглал болон гамшиг, эрсдлийн удирдлага зэрэг салбарууд дахь МХХТ-ийн хэрэглээний жишээний талаар хэлэлцэх;
3. МХХТ-ийг хөгжлийн зорилгоор үр дүнтэй ашиглахад тулгарч буй сорилтуудын талаар хэлэлцэх; болон
4. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд МХХТ-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн гол хүчин зүйлсийг хэлэлцэх.

АГУУЛГА

Өмнөх үг	3
Удиртгал	5
Цуврал модулийн тухай	7
Модуль 1	9
Модулийн зорилго	9
Сургалтаас гарах үр дүн	9
Кейс-Судалгаа	11
Нэмэлт мэдээлэл	11
Зураг	11
Хүснэгт	11
Товчилсон үгс	12
1. ТАНИЛЦУУЛГА	14
2. МХЗ БОЛОН МХХТ: ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ	17
2.1 МХЗ-уудын талаар товчхон	17
2.2 МХХТ: Юу болох, юуг хийж чадах	30
2.3 Тоон хуваагдлыг арилгах арга замууд	34
3. ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ	
МХХТ-ИЙН ХЭРЭГЛЭЭ	49
3.1 МХХТ болон ядуурлыг бууруулах	49
3.2 Боловсрол дахь МХХТ	58
3.3 МХХТ болон хүйсийн тэгш байдал	65
3.4 МХХТ болон эрүүл мэнд	72
3.5 МХХТ болон байгалийн нөөцийн удирдлага	77
3.6 МХХТ болон засаглал, Засгийн газар	82
3.7 МХХТ болон энх тайван	86
4. МХХТ-ИЙГ ХӨГЖЛИЙН САЛБАРТ АШИГЛАХ	
ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС	90
4.1 Хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлого	90
4.2 МХХТ-ийн үйл ажиллагааг төлөвлөх нь	93
Тойм	101
Хавсралт	102
Нэмэлт материалууд	102
нэр томъёоны тайлбар	105
Сургагч багш нарт зориулсан зөвлөмж	108
Зохиогчийн тухай	112

КЕЙС-СУДАЛГАА

1. МХХТ болон Энэтхэгийн үндэсний орон нутгийн ажил эрхлэлтийн баталгааны схем (NREGA)	53
2. e-Choupal, Энэтхэг	55
3. Ази, Номхон далайн бүсийн хөдөөгийн хөгжлийн мэдлэгийн сүлжээ (ENRAP)	57
4. Хамтын нөхөрлөлийн жижиг орнуудын виртуал их сургууль (ХНЖОВИС)	62
5. Хамтын People First (Нэгдүгээрт хүмүүс) сүлжээ, Соломоны арлууд	63
6. Судалгааны санаачилгуудад зориулсан эрүүл мэндийн InterNetwork сүлжээ	75
7. Судалгааны Тикивики GeoCMS- гео орон зайн контентын удирдлагын систем, Номхон далайн арлын орнууд	78
8. Зүүн-Өмнөд Азид цунамиг урьдчилан мэдээлэх систем	80

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Нэмэлт мэдээлэл 1. Мянганы хөгжлийн зорилго, зорилтууд	19
Нэмэлт мэдээлэл 2. МХХТ-ийг ашиглах тэргүүлэх аргачлалын зааварчилгаа	95

ЗУРАГ

Зураг 1. АНДБЭЗНХ-ны тэргүүлэх ач холбогдол бүхий орнууд	15
--	----

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Улсуудыг МХЗ-уудын биелэлтээр ангилсан нь	22
Хүснэгт 2. Өнөөгийн ашиглалтын байдлаар нь МХХТ-ийг ангилсан нь	31
Хүснэгт 3. Төрөл бүрийн МХХТ-ийн давуу болон сул талууд	32
Хүснэгт 4. Ази, Номхон далайн бүсийн сонгогдсон буурай хөгжилтэй орнуудын теле-нягтрал	35
Хүснэгт 5. Ази, Номхон далайн бүсэд Интернет нэвтэрсэн байдал болон хэрэглээ	38
Хүснэгт 6. МХХТ-ийг боловсролын салбарт ашиглахын боломж, үр шим	59

ТОВЧИЛСОН ҮГС

АГББТ	Азийн гамшгийн бэлэн байдлын төв (Asian Disaster Preparedness Centre)
ДОХ	Дархлалын олдмол хомсдол (Acquired Immunodeficiency Syndrome)
APCICT	Хөгжлийн төлөө МХХТ-мэдээлэл, харилцаа холбооны технологийн Ази, Номхон далайн бүсийн сургалтын төв (Asian and Pacific Training Centre for Information and Communication Technology for Development)
АНДБХМХ	Ази, Номхон Далайн бүсийн хөгжлийн мэдээллийн хөтөлбөр (Asia-Pacific Development Information Programme)
АСЕАН	Зүүн-Өмнөд Азийн орнуудын холбоо (Association of Southeast Asian Nations)
АОУХА	Австралийн олон улсын хөгжлийн агентлаг (Australian Agency for International Development)
AVA	Виртуаль академи (APCICT Virtual Academy)
CENWOR	Шри-Ланкын эмэгтэйчүүдийн судалгааны төв, (Centre for Women's Research, Sri Lanka)
CD	Компакт диск
СХН	Суралцах хамтын нөхөрлөл (Commonwealth of Learning)
ДАНИДА	Данийн олон улсын хөгжлийн агентлаг (Danish International Development Agency)
DVD	Дижитал видео диск - ДиВиДи
ХХМС	Ази, Номхон Далайн бүсийн хөдөөгийн хөгжлийн мэдлэгийн сүлжээ (Knowledge Networking for Rural Development in Asia/Pacific Region)
ЭЗНХ	Ази, Номхон Далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хороо (Economic and Social Commission for Asia and the Pacific)
FM	Долгионы давтамжийн модуляц
FTP	Файл дамжуулах протокол (File Transfer Protocol)
GeoCMS	Гео-орон зайн контент удирдлагын систем (Geospatial Content Management System)
ГЗМС	Газар зүйн мэдээллийн систем
ХБЗ	Хязгаарлагдмал бус засаглал (Governance Out of a Box)
HINARI	Судалгааны санаачлагуудын эрүүл мэндийн Интернэтворк сүлжээ (Health InterNetwork Access to Research Initiative)
ХДХВ	Хүний дархлалын халдварт вирус
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
ХТМХХТ	Хөгжлийн төлөө мэдээлэл, харилцаа холбооны технологи
ОУХСТ	Олон улсын хөгжлийн судалгааны төв, Канад (International Development Research Centre, Canada)
ХААХОУС	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (International Fund for Agricultural Development)
ЭССБ	Энэтхэгийн сансар судлалын судалгааны байгууллага (Indian Space Research Organization)
MT	Мэдээллийн технологи
КБХБ	Каракорам бүсийн хөгжлийн байгууллага (Karakoram Area Development Organization)
MDG-MX3	Мянганы хөгжлийн зорилтууд
АББ	Албан бус боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага

НСУХ	Нээлттэй сургуулийн үндэсний хүрээлэн (National Institute of Open Schooling, India)
NREGA	Үндэсний орон нутгийн ажил эрхлэлтийн баталгааны хууль, 2005 он, Энэтхэг (National Rural Employment Guarantee Act, 2005 India)
ХҮАЗА	Хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулах алба (Office for the Coordination of Humanitarian Affairs)
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Organisation for Economic Co-operation and Development)
PFnet	Нэгдүгээрт хүмүүс сүлжээ, Соломоны арлууд
CAPC	Амьсгалын замын хурц, цочмог үрэвсэл (Severe Acute Respiratory Syndrome)
SIDSNet	Арлын хөгжиж буй жижиг орнуудын сүлжээ (Small Island Developing States Network)
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр (Small and Medium Enterprise)
SMS	Богино мессежийн үйлчилгээ
TEIN2	Транс Евро-Азийн мэдээллийн сүлжээ 2 (Trans-Eurasian Information Network 2)
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
ЮНЕСКО	НҮБ-ын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага
АНУОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
VSAT	ВиСАТ (Very Small Aperture Terminal)
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ТЭМДЭГЛЭГЭЭНҮҮД



Кейс судалгаа



Зорилго



Асуултууд



Дасгал



Өөрийгөө шалгах нь

1. ТАНИЛЦУУЛГА

Ази, Номхон далайн бүс нь дэлхийн хүн амын дөрөвний нэг нь оршин суудаг өргөн уудам нутаг билээ. Дэлхийн бусад бүс нутагтай харьцуулбал Ази, Номхон далайн бүс нь хамгийн өргөн хэмжээнд, олон янз байдал цогцолсон нутаг бөгөөд хамгийн эртний соёл иргэншил, хамгийн отгон соёл иргэншилтэй зэрэгцэн оршиж, хүн ам хамгийн шигүү суурьшсан болон Номхон далайн хүн ам цөөтэй алслагдмал арлын орнууд ч энэ бүс нутагт нэгэн адил хамаарч байдаг. Олон үндэстэн, арьстан, шашин шүтлэг бүхий хүн ам оршин амьдарч, баялаг болон ядуурал мөн л энэ тивд зэрэгцэн оршиж байна. Дэлхийн хамгийн хурдацтай өсөж буй эдийн засаг, буурай хөгжилтэй орнууд болон шилжилтийн орнууд ч энэ тивд л мөр зэрэгцэн буй.

Тиймээс Ази, Номхон далайн бүсэд хандивлагчид, хөгжлийн байгууллагууд болон хөгжлийн ажилтнуудад тулгарч буй сорилтууд нь ихээхэн өргөн цар хүрээтэй байдаг. Бүх орнуудад таарах нэг ижил жор гэж байхгүй учраас нэг улсад үр дүнгээ өгч буй шийдэл нь тухайн бүс нутгийн өөр нэг улсад амжилтад хүрэхгүй байж болно.

Энэхүү шалтгааны улмаас тус бүс нутгийн орнуудыг зарим суурин үзүүлэлтүүдийн дагуу сегментлэн хувааснаар тэдний хөгжилд тулгараад буй сорилтуудыг шийдэх шинэлэг арга замыг эрэлхийлэх шаардлага үүсч байгаа билээ. Мянганы хөгжлийн зорилтуудын (МХЗ) Зорилго 13, 14 болон МХЗ 8 нь арлын, уулархаг, далайд гарцгүй болон буурай хөгжилтэй орнуудын онцлог хэрэгцээнд нийцүүлэн дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх, тусгай хариуцлага хүлээх үүргийг ноогдуулж буй юм. НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хороо нь өөрийн үйл ажиллагааг голлон чиглүүлэх орнуудыг Номхон далайн арлын хөгжиж буй орнууд, буурай хөгжилтэй орнууд болон шилжилтийн эдийн засагтай, далайд гарцгүй орнууд хэмээн тодорхойлсон байдаг.

Зураг 1. АНДБЭЗНХ-ны тэргүүлэх ач холбогдол бүхий орнууд



Хэдийгээр тухайн улсууд нь харилцан адилгүй, өөр өөр нөхцөл байдалтай хэдий ч үндсэндээ ижил төрлийн асуудлуудтай тулгарч байдаг. Дээрх ангиллуудад багтаж буй улсууд нь газар нутгийн хэмжээ жижиг, хүн амын тоо бага, зах зээл жижиг, хүний, техникийн болон байгалийн нөөц баялаг багатай байдаг. Арлын орнууд, алслагдсан уулархаг орнууд нь цунами, газар хөдлөлт зэрэг байгалийн өөрчлөлт, гамшигт өртөмтгий улсууд юм. Улс төрийн хувьд эдгээр улсууд нь ихээхэн эмзэг ба томоохон, өндөр хөгжилтэй улс орнуудаас технологи, тогтолцоо, бараа үйлчилгээ, материаллаг байдлын хувьд хялбархан хамааралтай болох магадлалтай орнууд юм. Үүний зэрэгцээ тэдгээр улсууд нь дэлхий нийтийн хөгжил, дэвшлээс хоцрогдох ёсгүй болохоо ч мөн сайтар ухамсарладаг билээ.

Тиймээс эдгээр тэргүүлэх ач холбогдол бүхий орнуудын хөгжлийн хэрэгцээнд нийцэх шинэлэг хандлага, шийдлийг олох хэрэгцээ урган гарч буй юм. Өнөөгийн мэдээлэлжсэн нийгмийн эрин зуунд орчин үеийн, тэргүүлэх МХХТ л тэрхүү шаардагдаж буй шинэлэг хандлага, хязгаарлагдмал бус шийдлийг бий болгох боломжийг ханган өгөх юм.

Энэхүү модуль нь тэргүүлэх ач холбогдол бүхий орнуудын хөгжлийн асуудлуудыг МХХТ-ийн хэрэглээний үүднээс, ялангуяа компьютер болон вебд суурилсан технологийн үүднээс судлан үзэх юм¹. Энэхүү модуль нь МХХТ-ийн хэрэглээ болон МХЗ-уудын биелэлтийн хоорондын холбоосыг бий болгох, хөгжлийн төлөөх мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ХТМХХТ) ухаалаг, бодит хэрэглээний талаар авч хэлэлцэх юм. Оршил болгон дурдахад МХХТ-ийг МХЗ-уудад хүрэхэд ашиглах шалгарсан нэг арга зам гэж үгүй тул улс болгон өөрийн хэрэгжүүлэх зорилго, зорилтууд, стратеги болон арга замуудыг тодорхойлох ёстой. Энэхүү модуль нь зорилго (МХЗ) болон стратегийн (МХХТ) хоорондын уялдаа холбоог энгийн байдлаар уншигчдад танилцуулан, эдгээр стратегийг үр дүнтэйгээр ашиглаж болох арга замуудыг санал болгох юм.

Энэхүү танилцуулга хэсгийн дараагийн бүлэгт МХЗ болон МХХТ-ийн талаарх тойм мэдээллийг дурдсан. Удаах бүлэгт хөгжлийн олон төрлийн салбарууд дахь МХХТ-ийн хэрэглээний талаар өгүүлсэн. Хөгжлийн салбар бүрийг тус бүрээр нь авч үзсэн ч гэсэн нэг салбар дахь МХХТ-ийн хэрэглээ: жишээ нь боловсролын салбар дахь хэрэглээ нь бусад салбарт өөрийн гэсэн үр дүнгээ хүртээдэг болохыг санах хэрэгтэй. Модулийн эцсийн бүлэгт төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгардаг өргөн хүрээний сорилтуудын талаар нарийвчлан дурдсан. Тухайн бүлэг нь төсөл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хүмүүст онцгой чухал юм.

Тус модуль нь тухайн хэлэлцэж буй асуудлаар суурь мэдлэг олгох зорилготой билээ. Тийм учраас зарим уншигчийн хувьд энэхүү модулийн мэдээлэл нь шинэ, харин заримынх нь хувьд анхан шатны мэт санагдаж болно. Түүнчлэн сургалтын зорилгоор цуврал модульд багтсан зарим мэдээлэл давхцан орсон тохиолдол мөн байгаа. Үүний учир нь энэхүү цогц салбарыг олон талаас нь, олон янз хэтийн төлөвийн хүрээнд судлан, энэхүү судалгааг илүү сорилттой, сонирхолтой болгох зорилгоос үүдэлтэй.

1. Радио, телевиз зэрэг хуучин технологийн хувьд тэдгээрийг тоон технологитой нэгдэн, интеграцад орсон хэлбэрээр авч үзэх болно.

2. МХЗ БОЛОН МХХТ: ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ

Энэхүү бүлгийн зорилго нь:

- бүс нутгийн хэмжээнд мхз-уудын биелэлтийн байдлыг судлах;
- мххт-ийн гол шинж чанаруудыг тодорхойлох; болон
- мххт-ийн стратегийн хэрэглээ нь хөгжлийн асуудлуудыг хэрхэн шийдэж болох талаар тоймлон судлах юм.

2.1 МХЗ-УУДЫН ТАЛААР ТОВЧХОН

Мянганы тунхаг болон МХЗ-уудыг НҮБ-ийн Ерөнхий ассемблейн 189 гишүүн орон 2000 онд батлан гаргасан нь дэлхий нийтийн хамтын ажиллагааны их урсгалыг үүсгэсэн юм. Хүний хөгжлийн асуудал олон арван жилийн туршид дэлхийн хамтын ажиллагааны индэр, дэлхий нийтийн хурлууд дээр олон дахин хөндөгдсөөр ирсэн ч МХЗ-уудыг батлан гаргасан нь бүх оролцогч талууд болох улс орнууд, Засгийн газрууд, донор болон хөгжлийн байгууллагууд, ТББ-ууд болон иргэний нийгмийн байгууллагууд анх удаагаа нэгдмэл ойлголтод хүрч, нэгдмэл үйл ажиллагаа явуулахгүйгээр тэгш, шударга хөгжлийн зорилго хэзээ ч биелэгдэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн үйл явдал болсон билээ.

МХЗ-уудын ач холбогдол

МХЗ-ууд (Нэмэлт мэдээлэл 1) нь дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрч, тэргүүлэх ач холбогдолтойгоор хэрэгжүүлж буй хамгийн өргөн хүрээний дэмжлэг хүлээж буй, ядуурлыг бууруулах онцлог стратеги юм. Донор болон техникийн туслалцаа үзүүлэгч байгууллагуудаас бүрдсэн олон улсын тогтолцооны хувьд тухайн зорилтууд нь тэдний үзүүлэх хөгжлийн туслалцааны нийтлэг бүтцийг тодорхойлдог. Улс орнуудын хувьд МХЗ-ууд нь олон улсын хүрээнд биелүүлэхээр үүрэг хүлээсэн, биелэлтийг нь тулган шалгах стандарт нь болж буй юм. Хэрэв зорилтууд биелсэн тохиолдолд одоо ядуурал, гачигдалтай нөхцөлд амьдарч буй нэг тэрбум хүн нэр хүнд, эрх чөлөө бүхий амьдралтай золгох боломжтой болох юм.

Нийт 8 зорилт нэг бүр нь дотроо зорилгуудтай, тэр бүгд ижил ач холбогдолтой, улс орнууд эдгээр зорилгод 2015 гэхэд хүрсэн байх ёстой билээ.

Нэмэлт мэдээлэл 1. Мянганы хөгжлийн зорилго, зорилттууд

Зорилго 1: Хэт ядуурал, өлсгөлөнг бууруулах

- Зорилт 1: Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой буюу өдөрт 1 ам доллараас бага орлого бүхий иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990-2015 онд 2 дахин бууруулах
- Зорилт 2: Өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийн тоог 1990-2015 онд хоёр дахин бууруулах

Зорилго 2: Бүх нийтээр бага боловсрол эзэмших

- Зорилт 3: 2015 он гэхэд бүх охид, хөвгүүдэд бага боловсрол олгох

Зорилго 3: Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

- Зорилт 4: Хүйсийн ялгааг 2005 он гэхэд бага болон дунд боловсролд, 2015 он гэхэд бүх шатны боловсролд арилгах

Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах

- Зорилт 5: 1990-2015 онд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах

Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

- Зорилт 6: 1990-2015 онд эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах

Зорилго 6: ХДХВ/ДОХ, хумхаа болон бусад өвчинтэй тэмцэх

- Зорилт 7: 2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх
- Зорилт 8: 2015 он гэхэд хумхаа болон бусад өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх

Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах

- Зорилт 9: Тогтвортой хөгжлийн зарчмуудыг улс орны бодлого, хөтөлбөрүүдэд тусгаж, байгалийн нөөцийн хомсдлыг арилгах
- Зорилт 10: 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэж чадахгүй байгаа хүмүүсийн хувь хэмжээг 2 дахин бууруулах
- Зорилт 11: 2020 он гэхэд орон байрны нөхцөл муу 100 сая хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах зорилтыг хангах

Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх

- Зорилт 12: Нээлттэй, дүрэм журамд тулгуурласан, урьдчилан тооцож болохуйц, үл ялгаварлан гадуурхах худалдааны болон санхүүгийн тогтолцоог цаашид хөгжүүлэх
- Зорилт 13: Буурай хөгжилтэй орнуудын онцгой хэрэгцээ шаардлагад анхаарах
- Зорилт 14: Далайд гарцгүй орнууд болон арлын хөгжиж буй жижиг орнуудын онцгой хэрэгцээ шаардлагад анхаарах (Арлын жижиг орнуудын тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөр болон Ерөнхий ассемблейн 22 дугаар тусгай хуралдааны үр дүнг ашиглан)
- Зорилт 15: Гадаад өрийг урт хугацаанд тогтвортой болгох үүднээс үндэсний болон олон улсын хэмжээнд арга хэмжээ авах замаар хөгжиж буй орнуудын өрийн асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх
- Зорилт 16: Хөгжиж буй орнуудтай хамтран залуучуудад зориулсан аятай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх
- Зорилт 17: Эм зүйн компаниудтай хамтран хөгжиж буй орнуудад гол нэрийн эмийг хямд үнээр хангах
- Зорилт 18: Хувийн хэвшилтэй хамтран шинэ технолги, ялангуяа мэдээлэл, харилцаа холбооны технологийн үр шимийг нэвтрүүлэх

Эх сурвалж: НҮБХХ, Regional Human Development Report – Promoting ICT for Human Development in Asia: Realising the Millennium Development Goals (New Delhi: UNDP, Elsevier, 2005), <http://www.apdip.net/elibrary#hdr>.

Түүнчлэн дэлхий нийтийн үйл ажиллагаа нь дэлхийн болон үндэсний хэмжээний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийг дэмжсэн бүс нутгийн хэмжээний үйл ажиллагаанаас бүрдэнэ. Дэлхийн хэмжээнд НҮБ-ын систем нь гол элементүүд болох хяналт-үнэлгээ, дүн шинжилгээ, кампанит ажил, үйл ажиллагаа зэргээр дамжуулан зорилтуудыг биелүүлэхийн тулд ажилладаг. Харин үндэсний хэмжээнд зорилтуудыг дэмжсэн бодлогын бүтэц, түншлэл, тухайн улсын хамааралтай судалгаа, үйл ажиллагааг бодлогын хэлэлцүүлэг, стратеги боловсруулах үйл явцаар дамжуулан ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг эсвэл үүнтэй ижил үндэсний төлөвлөгөө, стратегид тусган хэрэгжүүлэх ёстой.

МХЗ-уудын биелэлт дэхь ахиц дэвшил

2004 оноос хойш дэлхийн өнцөг булан бүрт мянганы хөгжлийн зорилтуудын биелэлтэд хэд хэдэн дунд шатны үнэлгээг дэлхийн хэмжээнд болон бүс нутгийн түвшинд хийжээ. 2007 оны байдлаар буюу зорилтуудад хүрэхээр төлөвлөсөн нийт хугацааны дунд үед гэхэд л ноцтой байдал үүсээд байлаа. 2007 оны МХЗ-уудын тайланд (The Millennium Development Goals Report 2007)² дурдсанаар дэлхийн хэмжээнд гарч буй ахиц дэвшил нь тэгш бус, бүс нутгуудад гарч буй цөөн тооны үзэгдэхүйц, өргөн тархсан ололтоос бусдаар дэлхийн ихэнх орнуудад 2010 гэхэд өмнөө тавьсан зорилгодоо хүрэхээргүй хэмжээнд буй талаар дурдсан байдаг.

Агентлаг хоорондын тайлан болох МХЗ: Ази, Номхон далайн бүс дэхь ахиц дэвшил 2007 (The Millennium Development Goals: Progress in Asia and the Pacific 2007³) хэмээх баримт бичигт дурдсанаар тухайн бүс нутаг нь Африкын Сахарын бүстэй харьцуулбал хавьгүй илүү амжилттай байгаа ч тус нутаг дахь дэлхийн хамгийн их хүн ам бүхий таван оронд (Бангладеш, Хятад, Энэтхэг, Индонези, Пакистан) нийт хүн амын гуравны хоёр нь хөдөө орон нутагт оршин сууж тэд анхан шатны ариун цэвэр дутмаг, хүүхдийн тэжээлийн дутагдал түгээмэл, ядуурал, хомсдолтой нөхцөлд амьдарч буй билээ. Ази, Номхон далайн бүс нь 2015 он гэхэд МХЗ-уудын ихэнх хэсгийг биелүүлэхэд нийтдээ хэвийн хэмжээнд байгаа болохыг Хүснэгт 1 дээр харууллаа. Ядуурал, өлсгөлөнг хоёр дахин бууруулах, бүх нийтээр бага боловсрол эзэмших, бүх шатанд хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлэх зэрэг зорилгуудын хувьд бүс нутгийн хэмжээнд хурдтай өөрчлөлт гарч, эдгээр зорилгуудыг биелүүлэх боломж бүрэн байгаа билээ. Гэхдээ нялхасын эндэгдэл өндөр, ХДХВ/ДОХ-ын халдвар нэмэгдсээр байна. Байгаль орчны бохирдол ч мөн бүс нутгийн хэмжээнд санаа зовних асуудал болоод байна.

Тайланд дурдсанаар МХЗ-уудын биелэлтэд гарч буй ахиц дэвшлийг дангаар нь авч үзэх нь хангалттай бус учир нь зорилгодоо хүрэх боломжтой орнууд ч гэсэн ядуурал, хүүхдийн эндэгдэл өндөртэй байгаа бол биелүүлэх боломж хязгаарлагдмал харагдаж буй орнууд ч үүнийг өөрчлөх боломжтой байгаа юм. Энэ шалтгааны улмаас нийт гарч буй ахиц дэвшлийг улс бүрээр нь авч үзэх нь чухал болоод буй билээ.

Ази, Номхон далайн бүс даяар түгээмэл ижил төстэй зүйлс байгаа ч АНДБЭЗНХ-ны тэргүүлэх ач холбогдол бүхий орнуудын ялгаатай хэрэгцээг тогтоох шаардлагатай буй юм (Хүснэгт 1-ийг үзнэ үү). Хүүхдийн болон эхийн эндэгдэл, сүрьеэ өвчний тархалт буурай хөгжилтэй орнуудад хамгийн өндөр байна. Төв Азийн улсууд нь эрүүл мэндтэй холбоотой зорилгуудын хувьд тааруу биелэлттэй байгаагийн зэрэгцээ хүүхдийн эндэгдлийг бууруулахад гаргаж буй ахиц нь удаашралтай байна. Цэвэр ус, үндсэн ариун цэврийн байгууламжуудын хангамжийн асуудлаар ч ахиц дэвшил удаашралтай байна. Мэдээллийн хомсдлоос хамааран Номхон далайн бүсийн хэмжээнд гарч буй ахиц дэвшлийг үнэлэхэд хүндрэл учирч буй бол тус бүсийн гол асуудлууд нь Төв Азийн орнуудад тулгарч буй асуудлуудтай ижил байна. Хятад, Энэтхэг улсууд зорилгуудыг биелүүлэхийн тулд ихээхэн амжилттай буй ч эдгээр улсуудад ихээхэн хэмжээний тэгш бус байдал ноёлж, олон тооны ядуу хүмүүст Зорилго 1-4, 6-т дурдсан үр дүн огт хүрээгүй байна.

2. UN, The Millennium Development Goals Report 2007 (New York: United Nations, 2007), <http://www.un.org/millenniumgoals/pdf/mdg2007.pdf>.

3. ADB, ESCAP and UNDP, The Millennium Development Goals: Progress in Asia and the Pacific 2007 (Bangkok: ADB, ESCAP and UNDP, 2007), <http://www.unescap.org/stat/mdg/MDG-Progress-Report2007.pdf>.

Хүснэгт 1. Улсуудыг МХЗ-уудын биелэлтээр ангилсан нь

Улсууд	Зорилт 1		Зорилт 2		Зорилт 3			Зорилт 4 & 5		Зорилт 6			Зорилт 7								
	Ядуурлыг бууруулах	Хүүхдийн тэжээлийн хомсдол	Бага сургуульд хамрагдалт	5 дугаар анги хүртэл суралцах	Бага сургууль дүүргэх	Бага боловсролын хүйсийн харьцаа	Дунд боловсролын хүйсийн харьцаа	Дээд боловсролын хүйсийн харьцаа	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Эхийн эндэгдэл	ХДХВ-ийн тархалт	Сурьээгийн тархалт	Сурьээгээс хамаарсан нас баралт	Ойн бүсийн хэмжээ	Туцгай хамгаалалттай газар нутаг	Нүүрхүчлийн давхар исэл ялгаруулалт	Озон задралч бодисын хэрэглээ	Хот суурин газрын усан хангамж	Хөдөө орон нутгийн усан хангамж	Хот суурин газрын ариун цэвэр	Хөдөө орон нутгийн ариун цэвэр
Афганистан		▲				■	▼	▼	■	■	▲	●	●	▼	▲	●	●	●	▲	●	▲
Америкийн Сомоо												●	●	▼		●					
Армен	●		●	●	●	●	●	●	●	●	▲	▼	▼	▼	●	●	●	●		●	
Азербайжан	●		▼		●	●	●	▲	■	■	▲	●	▼	▲	●	●	●	●	●		
Бангладеш	▼	■	▲	▼	▼	●	●	▼	▲	▲	▲	●	●	▼	●	▼	▼	▼	■	▼	▲
Бутан				▲					▲	■	▲	●	●	●	●	▼	●				
Бруней Даруссалам				▲	●	●	●	●	●	●	▲	▼	▼	▼	●	●	●				
Кампучи		▼	●	▼	▲	▲	▲	▲	▼	▼	●	●	●	▼	●	●	●				
Хятад	●	●				●	●	▲	●	●	▲	●	●	●	●	▼	●	▼	■	■	▲
Куукын арлууд			▼			●	●		●	●		●	●	●		▼	●				
БНАСАУ		▼							▼	▼	●	●	▼	▲	●	●	●	●			
Фижи			●	●	●	●	●	●	●	●	▲	●	●	●	●	▼	●			▼	▼
Францын Полинези												▼	●	▲	●		●	●	●	●	●
Гүрж	▼		▼		▼	●	●	●	●	■	▼	●	●	▲	●	●	●	●	▼	●	▼
Гуам												●	▼	▲		▼		●	●	●	●
Хонгконг			▼	●	●	▼	●	●			▲	●	●		▼						
Энэтхэг	▲	■	▲	▲	▲	▲	▲	■	■	■	▲	●	●	●	●	▼	▼	●	●	▲	▲
Индонези	●	▼	■	▼	●	●	●	▼	●	●	▲	●	●	▼	●	▼	●	▼	■	■	■
Иран	●		▲	▼	■	●	●	●	●	●	▼	●	●	▲	●	▼	●	●	▼		
Казахстан	●		▲		●	●	●	●	▼	▼	▲	▼	▼	▲	●	●	●	●	▼	▼	▼
Крибати				▲	●	●	●		■	■		●	●	▲	●	▼	●	■	▲	▲	■
Киргызстан	●		■		▼	●	●	●	■	■	▲	●	●	●	●	●	●	●	▼	▼	▼
Лаос	▼	■	▲	▲	■	▲	■	▲	▲	▲	▲	●	●	▼	●	▼	●				
Макао			▲	●	●	▼	●	▼				▼	▼		▼						
Малайз	●	●	▼	●	▼	●	●	●	●	●	▼	●	●	▼	●	▼	●	●	●	▼	
Мальдив		▲	▼		●	●	●	●	●	●		●	●	▲		▼	●	●	▼	●	
Маршаллын арлууд			▲		●	▼	●	●	▲	■		●	●		●		▼	●	▲	■	
Микронези									●	●		●	●	▲	●		▼	●	●	■	▼
Монгол	▼	▼	▼		●	●	●	●	▲	▲	▲	●	●	▼	●	●	●	▼	▼		
Мьянмар		■	▲	▲	▲	●	●	●	■	■	●	●	●	▼	●	▼	▼	▼	●	●	●

Эх сурвалж: ADB, ESCAP and UNDP, The Millennium Development Goals: Progress in Asia and the Pacific 2007, 33 (Bangkok: ADB, ESCAP and UNDP, 2007), <http://www.unescap.org/stat/mdg/MDG-Progress-Report2007.pdf>.

- - Хугацаанаас өмнө биелэх боломжтой
- ▲ - Биелэгдэх шатандаа буй
- - Удаашралтай
- ▼ - Дэвшил байхгүй/бууралттай

Улсууд

	Зорилт 1		Зорилт 2		Зорилт3			Зорилт 4 & 5		Зорилт 6			Зорилт 7								
	Ядуурлыг бууруулах	Хүүхдийн тэжээлийн хомсдол	Бага сургуульд хамрагдалт	5 дугаар анги хүртэл суралцах	Бага сургууль дүүргэх	Бага боловсролын хүйсийн харьцаа	Дунд боловсролын хүйсийн харьцаа	Дээд боловсролын хүйсийн харьцаа	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Эхийн эндэгдэл	ХДХВ-ийн тархалт	Сүрьеэгийн тархалт	Сүрьеэгээс хамаарсан нас баралт	Ойн бүсийн хэмжээ	Тусгай хамгаалалттай газар нутаг	Нүүрхчлийн давхар исэл ялгаруулалт	Озон задлагч бодисын хэрэглээ	Хот суурин газрын усан хангамж	Хөдөө орон нутгийн усан хангамж	Хот суурин газрын ариун цэвэр	Хөдөө орон нутгийн ариун цэвэр
Науру					▼	●	●		●	●		▼			●	●					
Непал	▲		▲	■	▲	▲	▲	■	▲	■	▲	●	●	▼	●	▼	●	●	●	▲	▲
Нью-Каледон																					
Ниуе					▼	●	▼					●	●	▼		▼	●	●	●	●	●
Хойд Марианны арлууд												●	▼	▼				●	●	●	●
Пакистан	●	■	▲			■	▲	▼	■	■	▲	●	●	▼	●	▼	▼	●	●	●	▲
Палау			●		●	▼	●	●	●	●		●	●	●	●	●	■	▼	●	▼	
Папуа Шинэ Гвиней				▲	▼	▼	▲		■	■	▼	●	●	▼	●	●	●	▼	▼	▼	▼
Филиппин	▲	▼	▲	▼	●	●	●	●	●	●	▲	●	●	▼	●	▼	●	▼	■	▲	■
БНСУ			●	●	●	●	●	●	●	●	▲	●	●	▼	●	▼	●	●			
ОХУ	●		▲			●	●	●	●	●	▼	●	●	▲	●	●	●	●	■	▼	▼
Самао			▲	▲	●	●	●	▼	●	●		●	●	●	●	▼	●	▼	▼	●	●
Сингапур									●	●	▲	●	●	▲	●	●	●	●	●	●	●
Соломоны арлууд			●			●	▲		■	●		●	●	▼	●	●	●		●		
Шри-Ланк	▲		●			●	●		●	●	▲	●	●	▼	●	▼	●	●	▲	●	●
Тажикстан	●		●		▼	●	▼	▼	■	■	▲	▼	▼	▲	●	●	●				
Тайланд	●					●	●	●	●	●	▲	●	●	▼	●	▼	●	●	●	●	●
Зүүн Тимор		▼							▲	▲		●	●	▼	▲	●					
Тонга			●		●	▼	●	●	●	●		●	▼	▲	●	▼	●	●	●	●	●
Турк	●	●	▼	▼	▼	▲	▼	▲	●	●		●	●	●	●	▼	●	●	●	●	●
Туркменстан	●								▼	▼		●	●	▲	●	▼	●				
Тувалу				▼	●	●			■	▲		●	●	▲	▲		●	▲	▲	●	▲
Узбекстан	●				●	●	●	▼	■	■	▼	▼	▼	●	●	●	●	▼	▼	●	▲
Вануату			▲		▲	●	▼	▼	●	●		●	●	▲	■	▼	▲	▼	▼		
Вьетнам	●	●	▼	▲	●	▼	●	■	●	●	▼	●	●	●	●	▼	●	●	●	●	▼
Ази, Номхон далайн бүс	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	■	▼	●	●	●	●	●	▼	▲	■	▲	▲
Буурай хөгжилтэй орнууд	■	■	▼	■	▲	▲	▲	■	■	■	●	●	●	▼	●	▼	●	▲	▲	▲	▲
Өмнөд Ази (Энэтхэг ороогүй)	▲	■	▲	▼	▼	▲	▲	▼	■	■	▲	●	●	▼	●	▼	●	▲	▲	▲	▲
Ази дахь ТУХН-ийн орнууд	●		▲		●	●	●	▲	■	■	▼	▼	▼	●	●	●	●	▼	■	■	■
Номхон далайн арлын орнууд			▲	▲	■	▼	▲	●	■	■	▼	●	●	▼	●	●	●	▼	■	▼	▼



АСУУЛТУУД

1. Танай орон биелүүлэх шаардлагатай буй гол МХЗ нь юу вэ?
2. МХЗ-уудаас алийг нь танай улс биелүүлэхэд дөхсөн байгаа вэ?
3. Аль зорилгыг нь танай улс биелүүлэх боломжгүй байх магадлалтай вэ? Яагаад?

Ази, Номхон далайн бүсийн улс болгоны МХЗ-уудад 2015 он гэхэд хүрч болох гүйцэтгэлийн байдал нь ихээхэн зөрүүтэй байгаа шалтгаан нь тухайн улсуудын өөрсдийнх нь нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай билээ. Ерөнхийдөө боловсрол, эрүүл мэндийн салбарт илүү хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болох нь харагдаж байна. Жишээ нь Өмнөд Азид боловсролд зарцуулж буй нийт зардлын хэмжээ маш доогуур байгаа бол Афганистан улсад л гэхэд төрийн зүгээс эрүүл мэндийн салбарт хийж буй хөрөнгө оруулалт бараг байдаггүй ажээ. Хандивлагч байгууллагууд өөрсдийн тусламжийг хуваарилахдаа тусламжийн үр дүнг харгалзан үзэх болсон тул олон орнуудад маш багахан хэмжээний тусламж ноогдох болжээ.

Нөгөө талаар нийгэмд гарч буй эерэг үр дүнгүүдийг Засгийн газруудын зүгээс хийж буй зардалтай шууд холбох нь хүндрэлтэй, учир нь энэхүү хамаарал өөр бусад олон тооны нийгмийн хүчин зүйлээс хамааралтай. Зарим орнууд нь боловсролын түвшний хувьд дээгүүр байрт ордог ч ядуурлын түвшнээр доогуур орох нь бий. Бусад орнууд нь эдийн засгийн өсөлт өндөртэй ч улс доторх тэгш бус байдал нь өндөр байх нь бий. Тиймээс нялхасын эндэгдэл, насанд хүрэгсэдийн бичиг үсгийн боловсрол, сургуульд хамрагдалтын харьцаа зэрэг хүний хөгжлийн нийтлэг үзүүлэлтүүдийг ашиглан МХЗ-уудын ахиц дэвшил, хөгжлийг авч үзэх тохиолдолд ихээхэн болгоомжтой хандах ёстой билээ.

Бүсийн хэмжээний тайлангуудаас тодорхой харагдаж буй нэг зүйл нь тус бүс нутгийн орнуудын Засгийн газрууд нь МХЗ-уудад хүрэхийн тулд ихээхэн зүйлийг хийж гүйцэтгэх шаардлагатай нь харагдаж байна. Нийгмийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сайн засаглалд хөрөнгө оруулж, дээрх зорилгуудад хүрэх хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай нь дамжиггүй.

НҮБ-ын Мянганы хөгжлийн төслийн эцсийн тайланд⁴ дурдсанаар МХЗ-ууд биелэгдэхгүй дөрвөн нийтлэг шалтгаан байгаагийн тоонд муу засаглал, авлига, бодлогын буруу сонголт болон хүний эрхийг үл хүндэтгэх явдал багтаж буй ажээ. Заримдаа ядуу байна гэдэг нь өөрөө асуудал болох ба зарим улсуудын, тэдний орон нутгийн засаг захиргаа нь шаардлагатай хөрөнгө оруулалтыг ч хийж чадахааргүй ядуу нөхцөлд буй ажээ. Ямартай ч дэлхийн удирдагчид “хүн төрөлхтөн, хүүхдүүдийг шоовдорлон, хүмүүнлэг бус байдалд түлхэн оруулдаг ядуурлаас чөлөөлөхийн тулд боломж, хүчин чармайлт бүрийг алдахгүй ашиглахаар” санал нэгдсэн билээ.⁵ Улс бүрийн үндэсний хууль тогтоомж нь бүх иргэдээ ядууралгүй, нэр хүндтэй амьдруулах талаар тусгасан байдаг. Хэдийгээр хийгдэж буй үйл явц нь удаан ч Засгийн газрууд эрин зууны хэмээгдэх энэхүү өөрчлөлтийн харьцангуй богино буюу 15 жилийн хугацаанд эрчимтэйгээр гүйцэтгэх (2000- 2015) зорилготойгоор ажиллаж байна.

Эдийн засгийн өсөлтийг хурдасгахын тулд өөрсдийн ядуурлыг бууруулах стратегид МХХТ-ийг хэрэглэх шаардлага энэ үед хүчтэй тавигдсаар байна. Сүүлийн 10 жилийн туршид компьютер, Интернетийг үр дүнтэй ашиглах явдал нь Азийн хэд хэдэн улсын хурдацтай хөгжлийн гол түлхүүр болж байна. МХХТ нь үйлчилгээг ард иргэдэд илүү сайнаар, тэгш хүртээмжтэйгээр хүргэж, олон салбарын хоорондын төлөвлөлт, зохицуулалтыг чиглүүлж, мэдээлэл хуваалцах боломжийг нэмэгдүүлж, олон нийтэд мэдээлэл түгээж,

4. UN Millennium Project, Investing in Development: A Practical Plan to Achieve the Millennium Development Goals (New York: UNDP, 2005), <http://www.unmillenniumproject.org/reports/fullreport.htm>.

5. United Nations, Report of the Secretary-General on the work of the Organization (New York: United Nations, 2006), 4, http://mdgs.un.org/unsd/mdg/Resources/Static/Products/SGReports/61_1/a_61_1_e.pdf.

хийж буй хүчин чармайлтад хяналт-шинжилгээг гүйцэтгэхэд үр дүнтэйгээр ашиглагдах болжээ. Хөгжиж буй орнуудын голлох нийгмийн салбарууд дахь хэрэгжилтийн асуудлууд нь тодорхой хүчин чармайлтыг шаардаж буй юм. Гэхдээ МХХТ-ийг нэгдмэл хандлага, зардал багатай шийдлүүдийг бий болгоход ашигласнаар нийт хэрэгжилтийн болон үйл ажиллагааны зардал нь буурах магадлалтай билээ.

Үүнийг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн бүс нутгийн орнууд МХХТ-ийг хөгжлийн төлөө ашиглах хүсэл эрмэлзэлтэй буйгаа зарлан тунхагласан юм. МХХТ-ийн интеграцийн зарим сонирхолтой, үр дүнтэй салбаруудын тоонд эм бэлдмэл түгээх, боловсрол олгох үйл ажиллагааг хангах, багш нарын сургалтыг сайжруулах, орон нутгийн нэвтрүүлэх төвийг дэмжих замаар малчид, фермерүүдтэй шууд холбох, урьдчилан мэдээлэх болон гамшгийн үр нөлөөг бууруулах системийн газар зүйн хувьд эмзэг газруудад хэрэгжүүлэх зэрэг салбар орж байна. Тиймээс МХЗ-уудыг биелүүлэх эсэх нь МХХТ-ийн хэрэглээтэй салшгүй холбоотой гэж хэлэхэд хэтрүүлсэн хэрэг болохгүй, тийм учраас л технологийг сайтар ойлгох нь ихээхэн чухал юм.

ДҮГНЭЛТ

- МХЗ-уудын биелэлтийн ахиц дэвшил улс болгоны хувьд тэгш бус байна. Ази, Номхон далайн бүс нь Африкын Сахарын бүстэй харьцуулбал зарим талаар ил тодорхой, өргөн олныг хамарсан давуу талууд байгаа хэдий ч тус бүсийн буурай хөгжилтэй орнууд нь нялхасын болон эхийн эндэгдэлийн хувьд өндөр хувьтай сүрьеэ болон ХДХВ-ын халдварын тохиолдол өсөлттэй, байгаль орчны тогтвортой байдлын хувьд бүр ухарсан байдалтай байгаа билээ. Номхон далайн бүсийн хувьд мэдээллийн хомсдол их, Хятад, Энэтхэг зэрэг оронд тэгш бус байдал ихээр газар аваад байгаа юм.
- Боловсрол, эрүүл мэнд зэрэг салбаруудад илүү их хэмжээгээр хөрөнгө оруулах шаардлага илүүтэй байгаа.
- Муу засаглал, бодлогын буруу сонголт, авлига, хүний эрхийг үл хүндэтгэх зэрэг нь хурдацтай өсөлтөд тээг болж буй гол шалтгаанууд болж байна.
- МХХТ нь хөгжлийн гол салбарууд болох ядуурлыг бууруулах, боловсрол, эрүүл мэнд, байгалийн нөөцийн удирдлага, гамшгийн удирдлага зэрэг салбаруудад зориулан нэгдмэл хандлага, зардал багатай шийдэл бий болгоход ашиглагдаж болно.

Одоо хамгийн гол шаардагдаж буй зүйл нь МХХТ-ийн “ноу хау” буюу мэдлэгийг үйл ажиллагаа болгох, өөрөөр хэлбэл МХХТ-ийн үндэс суурь, нөхцөл байдлыг сайтар ойлгож, энэхүү стратегийн аргачлал, сонголтыг хэрэглэх явцыг илүү оновчтой болгох шаардлагатай байгаа юм.

2.2 МХХТ: ЮУ БОЛОХ, ЮУГ ХИЙЖ ЧАДАХ

МХХТ-ийн тодорхойлолт нь хэрэглэж буй нөхцөл байдлаасаа хамааран олон янз байдаг. Энэхүү хэлэлцүүлэгт зориулан бид НҮБХХ-ийн гаргасан тодорхойлолтыг сонгон авсан юм:

МХХТ нь үндсэндээ мэдээлэлтэй харилцах аргачлал буюу мэдээллийг бий болгох, хадгалах, түгээх болон солилцох зорилгоор ашиглагддаг бүтээгдэхүүн, хэрэглээ болон үйлчилгээний цогц юм. Тэдгээрийн тоонд “хуучин” МХХТ буюу радио, телевиз, утас болон “шинэ” МХХТ буюу компьютер, хиймэл дагуул, Интернет зэрэг багтана. Эдгээр хоёр төрөлд багтах аргачлалууд нь хослон ажиллаж бидний “сүлжээт ертөнц”, харилцан холбоо бүхий утасны үйлчилгээний дэд бүтэц, стандартчлагдсан компьютерийн техник хангамж, Интернет, радио болон телевиз зэргийг бий болгон дэлхийн өнцөг булан бүрт хүрч байдаг юм.⁶

МХХТ-ийг ерөнхийд нь аналог болон тоон, синхрон болон асинхрон хэмээн хувааж

6. UNDP Evaluation Office, Information Communications Technology for Development, UNDP Essentials: Synthesis of Lessons Learned (New York: UNDP, 2001), 2.

болно. Аналог өгөгдлийг үргэлжилсэн дохиогоор хүлээн авдаг бол тоон мэдээлэл нь аналог дохиог зөвхөн нэг болон тэг хэмээх тоон утга ашиглан уншдаг. Хуучны өргөн нэвтрүүлгийн телевиз, радио болон дүрс бичлэгийн аппарат нь аналог бүтээгдэхүүн байсан юм. Гэхдээ эдгээр зүйлс хурдацтайгаар тоон хэлбэрт шилжиж буй тул тэднийг ДиВиДи (DVD) тоглуулагч зэрэг тоон тоног төхөөрөмжтэй хялбархан хослуулан хэрэглэх боломжтой юм. Компьютер нь зөвхөн тоон өгөгдлийг ашиглах ба өнөө үед ихэнх мэдээлэл тоон хэлбэрээр хадгалагдах болжээ. Хүснэгт 2 дээр өнөөгийн ертөнцөд ашиглаж буй олон төрлийн МХХТ-ийг тоймлон харуулсан.

Хүснэгт 2. Өнөөгийн ашиглалтын байдлаар нь МХХТ-ийг ангилсан нь

Синхрон МХХТ	Асинхрон МХХТ
“Үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч талууд нь хоёулаа хугацааны нэг агшинд байх шаардлагатай ба харин өөр өөр газарт байх боломжтой”	“Үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч талууд нь цаг хугацаа болон байрлалын хувьд өөр өөр байх тохиолдолд ашиглаж болох
Аудио график Компьютерын синхрон хурал Электрон самбар Радио Сансрын холбоо Теле хичээл Теле хурал Телевиз Өргөн нэвтрүүлэг Радио Кабель Телефон утас	Компьютержсэн сургалт Компьютерын асинхрон хурал (conferencing) Компьютерын файл дамжуулалт Захидал харилцааны материалууд Электрон мэдээллийн самбар И-мэйл Факс СиДи Ром (CD ROM) зэрэг бүтээгдэхүүнүүд Вебд суурилсан технологи (веб сайт гэх мэт) Теле- компьютержсэн сургалт Видео хуурцаг, диск

Давуу болон сул талууд

Хуучин болон шинэ тоон технологи нь хэрэглэгчид эдгээрийг ганчаарчлан ашиглах боломжийг хангахын зэрэгцээ, олон хэрэгцээ, үүрэг функц болон хэрэглэгчдийн бүлгүүдэд зэрэг үйлчлэх боломжийг хангадаг. Гэхдээ тухайн технологийн хүчин чадалд томоохон ялгаа, зөрүү байдаг. Хүснэгт 3 дээр дурдсан давуу болон сул талууд дээр үндэслэн өөрийн хэрэглээний талаар ухаалаг сонголтыг хийж болно.

Хүснэгт 3. Төрөл бүрийн МХХТ-ийн давуу болон сул талууд

МХХТ	Давуу талууд	Сул талууд
Хэвлэлийн технологи	<ul style="list-style-type: none"> • Нийтэд танигдсан • Дахин ашиглах боломжтой • Гүнзгийрүүлсэн мэдээлэл өгөх боломжтой • Олноор үйлдвэрлэхэд зардал хэмнэх боломжтой • Нэгдмэл контент, стандарттай 	<ul style="list-style-type: none"> • Бичиг үсэг үл мэдэх явдал сөрөг нөлөөтэй • Цаг хугацааны хувьд мэдрэмж муу • Шинэчлэхэд хүндрэлтэй • Идэвхгүй, харилцан идэвх буюу интерактив байдал байхгүй нэг чигийн
Өргөн нэвтрүүлгийн аналог технологи (радио, телевиз)	<ul style="list-style-type: none"> • Нийтэд танигдсан • Түгээх хурд сайн • Шууд бус байдлаар туршлага олгодог • Олноор үйлдвэрлэхэд зардал хэмнэх боломжтой • Нэгдмэл контент, стандарттай • Хэрэглэхэд хялбар 	<ul style="list-style-type: none"> • Хүртээмж хязгаарлагдмал • Цаг хугацааны хувьд мэдрэмж муу, синхрон • Шинэчлэхэд хүндрэлтэй • Идэвхгүй, харилцан идэвх буюу интерактив байдал байхгүй нэг чигийн • Асуудал болон байрлалаас үл хамаарах • Бүх бүлгийн хүмүүсийг нэг түвшиний контентоор хангадаг • Эхлэлийн, үйлдвэрлэлийн болон түгээлтийн зардал өндөр
Тоон (компьютер болон Интернетэд суурилсан) технологи	<ul style="list-style-type: none"> • Интерактив • Нэгжийн зардал бага • Олноор үйлдвэрлэхэд зардал хэмнэх боломжтой • Нэгдмэл контент, стандарттай • Хялбархан шинэчлэх боломжтой • Онцлог асуудал, байрлал бүхий • Хэрэглэхэд хялбар 	<ul style="list-style-type: none"> • Хүртээмж хязгаартай хэвээр байна • Боловсруулах, хөгжүүлэх зардал өндөр • Үйлчилгээ үзүүлэгчдийн шууд чадавхиас хамааралтай • Компьютерын мэдлэг заавал шаардагддаг • Дотоодын контент дутагдалтай

Өмнөх 10 жилийн туршид хуучин технологийг (аналог радио, телевиз гэх мэт) хөгжлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ихээхэн өргөн хүрээнд ашиглаж байжээ. Олон хүнд хүрдэг, хүртээмж хялбар зэрэг нь радио, телевизийг ашиглах гол хүчин зүйл байж, донор болон техникийн туслалцааны байгууллагууд ч эдгээр технологийг хэрэглэх явдалд ихээхэн дэмжлэг үзүүлж байжээ. Үүний жишээ тоо тоомшгүй их байдаг. Ази, Номхон далайн хэмжээний нэгэн амжилттай жишээний тоонд хиймэл дагуулын радио, телевизийг Өмнөд Номхон далайн их сургуулиас эрхлэн боловсролын зорилгоор ашигласан жишээ орно. Өөр нэгэн жишээний тоонд 1950-иад оны орон нутгийн радио форум, 1975-76 оны Энэтхэгийн SITE туршилт, Хятадын радио, телевизийн их сургууль болон Мексикийн Телесекундари (Telesecundaria) зэрэг үйл ажиллагаа мөн багтана.

Хэдийгээр батлан хэрэгжүүлж буй онцлог зорилго, стратеги нь орон нутгийн хэрэгцээ, нөхцөл байдалд нийцэн тогтоогдсон ч гэсэн эдгээр МХХТ-ийн дэмжлэг бүхий төслүүд нь бараг нэгэн ижил загвараар үйл ажиллагаа явуулж иржээ. Улсууд нь тухайн үеийн хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан орон зайн алслал, тааруу дэд бүтэц, сургууль коллежийн дутагдал болон бичиг үсэг үл мэдэх явдлыг даван туулахаар оролдож байсан ажээ. Эдгээрийг хэрэгжүүлсэн улс болгон үндэсний болон олон улсын технологийн сүлжээг бий болгон контентийг хүргэхэд хөрөнгө оруулалт хийжээ. Улс болгон контент хөгжүүлэх үйл ажиллагааг мэргэжилтнүүд, багш нар, продюсерууд, судлаачдыг нэгэн дор цуглуулан өөрийн улс бүрийн тэргүүлэх чиглэл, нөхцөл байдалд нийцэх боловсролын материалыг гаргаж байв.

Амжилттай хэрэгжихийн зэрэгцээ эдгээр хөтөлбөрүүд нь тодорхой хэмжээний сорилт, төрөл бүрийн асуудалтай тулгарч байжээ. Эдгээрийн тоонд хамгийн түгээмэл синхрон загварыг хэрхэн буруулах (ялангуяа телевизийн хуваарийн уян хатан бус байдлыг), теле дүрсээр үзүүлж буй дүрслэл болон хэрэгцээ шаардлагад нийцсэн, оюун ухааны хувьд

сорилт үүсгэсэн буюу унших, судлах зэргээр суралцах үйл явцын хоорондын тэнцлийг хэрхэн хангах, суралцагчдад сурсан зүйлсээ ашиглахыг хэрхэн сэдэлжүүлэх гээд олон асуудал байжээ. Түүнчлэн эдгээр хөтөлбөр нь төвлөрсөн төлөвлөлтийн асуудлыг орон нутгийн хамаарал, тэдний эрэлт хэрэгцээтэй уялдуулахтай холбоотой асуудлыг шийдэх шаардлагатай болсон. Бүхий л хөтөлбөрт хүртээмж, тэгш байдал болон харилцан үйл ажиллагаанаас хамаарах асуудлууд тулгарч байжээ. Улмаар тоон хувсгалын үр дүнд гарч ирсэн технологийн хөгжлийн шуурганд цохигдох болжээ. Технологийн зардал багассаар буй ч хуучин тоног төхөөрөмжийг шинэчлэх болон солих үйл явц нь байнгын толгой өвтгөсөн асуудал болох болжээ.

Өнөөдөр бүх томоохон хэмжээний МХХТ-ийн дэмжлэг бүхий боловсролын чиглэлийн үйл ажиллагаа тоон технологийг ашиглан суралцагч болон багш нарын харилцан хамтын ажиллагааг хамгийн боломжит бага зардлаар хангаж байгаа билээ. Хуучин аналог болон шинэ тоон технологийн харьцуулсан давуу болон сул талууд дээр (Хүснэгт 3) харуулснаар шинэ технологи нь мэдээллийн аргачлалын хувьд илүү өрсөлдөх давуу талтай байгаа юм. Үүний улмаас МХЗ-уудад хүрэхийн тулд эдгээрийг ашиглах явдлыг заавал судлан үзэх шаардлагатай билээ.

Хөгжлийн зорилгоор МХХТ-ийг хэрхэн ашиглаж буй талаар хийгдсэн олон тооны судалгаагаарамжилтболонбүтэлгүйтлийнолонжишээгбаримтжуулжээ.Судалгаануудаас үзвэл бодлого, төлөвлөлт, дизайн, технологи нэвтрүүлэлт болон хэрэглээний арга туршлагын олон талт байдлыг улс болгоны нөхцөл байдалд тулгуурлан тогтоосон байна. Гэхдээ эдгээр судалгаанаас үзвэл хуучин аналог болон шинэ тоон МХХТ-ийн хооронд ихээхэн ялгаатай байгааг батлан харуулсан байна. Хэвлэл, радио, телевиз зэрэг хуучин технологийн хувьд тэдгээрийн хэлбэр, продакшн, контентын зохицуулалт, түгээх арга зүй нь төвлөрсөн, нэг чигийн байдалтай байна. Шинэ тоон МХХТ нь илүү нээлттэй, хувь хүн болон нийгмийн бүлгүүд өөриймшүүлэх, удирдан явуулах боломжтой байгаа ба жишээ нь тухайн технологийг өөриймшүүлэх нь одоо алсын удирдлага, компьютерын маус эсвэл үүрэн холбооны утас бүхий хувь хүнд шилжээд буй юм. Хэн нэгэн хүн өөрийн хэрэгцээнд зориулан технологи ашиглах, өөрийн хувийн орон зайг бий болгох нь одоо энгийн асуудал болон хувирчээ. Энэ нь агуулга болон хэлбэрийн хувьд олон талт байдлыг хангаж, хэл, соёл, дизайн, контент болон хэрэглээний хувьд өөриймшүүлэх боломжийг хангах болжээ.

Тоон технологийг ашиглах явдлыг нэмэгдүүлж буй гол нэгэн чиглүүлэгч нь нэгдэн нийлэлт билээ. Нэгдэн нийлэлт гэдэг нь бүх мэдээллийн хэрэгсэл, текст, аудио, график, анимац, видео зэрэг нь харилцаа холбооны технологийн хүрээнд нэгдэн, нийтийн платформоор дамжин түгээгдэж, хэрэглэгч нь өөрийн хүссэн харилцагчийг сонгон, харилцан ажиллах явдлыг хэлнэ. Энэ нь мөн эдгээр бүх технологийн холболт болон сүлжээг нэг нэгнээс нь ялгахад хүндрэлтэй байдаг буюу харилцаа холбооны нэг суваг жишээ нь гар утас текст, аудио, видео, и-мэйл, мессеж, болон Интернэтийг нэг цэгээс нөгөө цэгт хүргэх (илгээгчээс хүлээн авагчид), нэг цэгээс олон цэгт хүргэх, олон цэгээс нэг хүлээн авагчид хүргэх үйл ажиллагааг мөн хэлнэ.

Нэгдэн нийлэлт нь контент хөгжүүлэгч нарт мэдлэгийн бүтээгдэхүүнийг үүсгэн, түгээх, үүнийг “нэг үйл явцыг ашиглан олон төрлийн үр дүнд хүрэх” байдлаар түгээж, мэдээлэл болон мэдлэгийг электрон хэлбэрээр өгөгдөл, график, аудио, видео байдлаар тусдаа болон хамтад нь түгээх боломжийг хангасан юм. Энэхүү технологийн нэгдэн нийлэлт нь продакшны үйл ажиллагааг хөнгөвчилж, түгээлтийг олон хэлбэрт оруулсанаараа хуучин аналог технологийн томоохон сул талыг нөхсөн юм.

ДҮГНЭЛТ

- Хуучин болон шинэ МХХТ-ийн аль аль нь хөгжлийн үйл ажиллагааны чухал аргачлалууд юм.
- Гэхдээ тоон технологийг ашиглах нь илүү хурдацтай нэмэгдэж байна.
- Шинэ тоон технологийг ашиглах нь өргөн тархсан ардчилсан үйл явц, эзэмшлийг технологийн нэгдэн нийлэлтийн хүрээнд бий болгож буй юм.

ДАСГАЛ



Нэг бүр нь 3-4 гишүүн бүхий жижиг бүлгээр ажиллан МХХТ-ын ямар хослол нь (хуучин болон шинэ МХХТ-ийг оруулж болно) доор дурдсан нийгмийн бүлгүүдэд үйлчилгээг хүргэх, нийгмийн оролцоог илүүтэйгээр хангахад үр дүнтэйгээр хэрэглэгдэж болох талаар хэлэлцүүлэг өрнүүл (Бүлэг бүр зөвхөн нэг нийгмийн бүлгийг сонгоно):

- а. Малчид, фермерүүд
 в. Алслагдсан тосгоны хүүхдүүд
 б. Хөдөөгийн эмэгтэйчүүд
 г. Сургууль завсардсан хүүхдүүд

Та бүхний бодож буйгаар тухайн сонгон авсан бүлгүүдэд хүргэх үйлчилгээг тодорхойлон (жишээ нь эрүүл мэнд, боловсрол, мэдлэгийн эх үүсвэрийн хүртээмж гэх мэт), МХХТ-ийг хэрхэн ашиглах тухайн үйлчилгээг сонгон авсан бүлэгт хүргэж болох талаар ярилцан, тухайн аргачлалыг сонгон авсан шалтгаанаа тайлбарлана уу.

2.3 ТООН ХУВААГДЛЫГ АРИЛГАХ АРГА ЗАМУУД

Дараа дараагийн хэсэгт орохоос өмнө Ази, Номхон далайн бүс нутгийн болоод улс орнуудын хэмжээний телефон шугамын нягтрал, МХХТ-ын нэвтрэлтийн талаарх статистик мэдээллийг судлан үзэх зайлшгүй чухал хэрэгцээтэй юм.

Хүснэгт 4. Ази, Номхон далайн бүсийн сонгогдсон буурай хөгжилтэй орнуудын теле-нягтрал

	Улсууд	Хүний хөгжлийн индекс 2007	Телефон утасны шугам (1000 хүн тутамд ноогдох) 2005	Үүрэн телефон ашиглагчид 2005	Интернэт хэрэглэгчид (1000 хүн тутамд ноогдох) 2005
Далайд гарцгүй буурай хөгжилтэй орнууд	Афганистан	Мэдээ байхгүй	Мэдээ байхгүй	Мэдээ байхгүй	Мэдээ байхгүй
	Бутан	133	51	59	39
	Лаос	130	13	108	4
	Непал	142	17	9	4
Далайд гарцтай буурай хөгжилтэй орнууд	Бангладеш	140	8	63	3
	Кампучи	131	3#	75	3*
	Мальдив	100	98	466	59*
	Мьянмар	132	9	4	2
	Соломоны арлууд	129	16	13	8
	Зүүн Тимор	145	11*	4	23
Буурай хөгжилтэй бус, далайд гарцгүй орнууд	Армен	83	192*	106	53
	Азербайжан	98	130	267	81
	Тажикстан	122	39#	41	1*
	Казахстан	73	167*	327	27*
	Киргизстан	116	85	105	54
	Монгол	114	61	218	105
	Туркменстан	109	80#	11*	8*
Узбекстан	113	67#	28	34*	
Бусад бүсүүд	Хөгжиж буй орнууд		132	229	86
	Буурай хөгжилтэй орнууд		9	48	12
	ЭЗХАХБ		441	785	445
	Дэлхийн хэмжээнд		180	341	136

* 2004 оны мэдээ, # 2003 оны мэдээ

Эх сурвалж: НҮБХХ, Human Development Report 2007/2008 - Fighting climate change: Human solidarity in a divided world (New York: UNDP, 2007), 273-276, http://hdr.undp.org/en/media/HDR_20072008_EN_Complete.pdf

Ази, Номхон далайн бүс нь харилцаа холбооны дэд бүтцийн хөгжлийн өргөн цар хүрээг харуулж буй бөгөөд теле-нягтралын хэмжээ нь (100 хүнд ноогдох телефон утасны шугамын тоо) нь Хонгконгт 53% байгаа бол Зүүн Өмнөд Азийн улсуудад (Жишээ нь Бангладеш, Камбож) 1%-иас доогуур үзүүлэлттэй байна.

АНДБЭЗНХ-ны үзэж байгаагаар:

Далайд гарцгүй буурай хөгжилтэй орнуудад (мэдээлэл дутмаг байсны улмаас Афганистаныг оруулаагүй) 100 хүнд ноогдох суурин утасны шугамын тоо 1998-2003 онуудад 15.03%-иар өссөн байна. Бутан улс Непалаас илүү, Лаос улстай харьцуулбал гурав дахин илүү тооны суурин утасны шугамтай байна. Дээр дурдсан далайд гарцгүй гурван улс нь бусад буурай хөгжилтэй орнуудын дундажтай харьцуулбал утасны шугамын тоог ихээр нэмэгдүүлж чадсан байна. Бангладеш болон Кампучи улсууд нь теле-нягтралын хэмжээгээр нэг хувиас доогуур байгаа нь тус бүсийн бусад оронтой харьцуулан үзвэл ихээхэн доогуур үзүүлэлт юм. Соломоны арлуудад 1998-2003 онуудад нөхцөл байдал муудаж 7%-иар буурсан ажээ. Тус улс дахь дундаж өсөлт нь 4.6, теле-нягтралын дундаж нь 3.27% байна. Энэ нь далайд гарцгүй гурван орны дунджаар 2.08-иар илүү байгаа нь Непал болон Лаос улсуудын бага нэвтрэлтээс үүдэлтэй юм. Мальдив улс нь нэвтрэлтийн хэмжээгээр 10.2 байгаа нь хавьгүй эерэг үзүүлэлт бөгөөд 1998-2003 онуудад 7.2%-иар нэмэгдсэн байна.

Буурай хөгжилтэй бус далайд гарцгүй орнуудын теле-нягтрал нь буурай хөгжилтэй орнуудаас хавьгүй өндөр буюу 2003 оны байдлаар 8.79 байна. Армен, Азербайжан болон Казахстан улс 13.0% орчим буюу харьцангуй өндөр теле-нягтралтай бол Тажикстан нь хамгийн бага 3.7% байгаа нь буурай хөгжилтэй орон болох Малдив, Самоа зэрэг орноос ч доогуур үзүүлэлт юм. Кыргызстан болон Туркменстан улсуудын үзүүлэлт бууралттай байгаа тул 1998-2003 онуудад дунджаар дөнгөж 1.8% өссөн байна. Энэхүү үзүүлэлт нь тухайн хугацаанд 5.2%-иар өссөн дэлхийн дунджаас бага байгаа юм.

Гар утасны нэвтрэлтийн талаарх тоон мэдээлэл илүү найдвар төрүүлэхүйц хэмжээнд байна. Энэ нь тус бүс нутагт үүрэн телефоны зах зээлийн хамгийн өндөр өсөлт бүхий Хятад, Энэтхэг улсууд байгаа, Төв Азийн ихэнх улсад нэвтрэлтийн хэмжээ өндөр буй, Бангладеш улсад шинэ санаачилгууд гарч буй зэрэгтэй холбоотой юм. Теле-нягтралын маш доогуур үзүүлэлт бүхий Афганистан улсад үүрэн телефоны нэвтрэлтийн хэмжээ 15% байна (2007 оны 5 дугаар сарын байдлаар).⁷

Интернэтийн хэрэглээний хувьд (Хүснэгт 5-ыг үзнэ үү) дэлхийн хүн амын гуравны хоёр нь оршин суудаг Ази тив нь нийт Интернэтийн хэрэглээний гуравны нэг хувийг эзэлж байна.⁸ Энэхүү хэрэглээний ихэнх нь Ази тивийн өндөр хөгжилтэй орнууд болон Япон, Өмнөд Солонгос, Малайз, Сингапур улсуудад төвлөрч буй юм. Далайн орнуудын Интернэт хэрэглээ доогуур буюу дэлхийн хэмжээний хэрэглээний хоёр хувийг эзэлж буй үүний 96%-ийг нь Австрали, Шинэ Зеланд хэрэглэж байна. АНДБЭЗНХ-ын тэргүүлэх ач холбогдол бүхий орнуудын аль нь ч Интернэтийн нэвтрэлтийн хувьд хоёр оронтой тоонд хүрээгүй байна. Энэхүү статистик мэдээнээс үзвэл юуны өмнө тухайн бүсд дэд бүтцийг бий болгон, хямд зардлаар холбогдох боломжийг ханган өгөх шаардлагатай ба ингэхийн тулд МХХТ-ийн санаачлагуудыг түгээн дэлгэрүүлж, улс орны хэмжээний үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх ёстой билээ.

7. ESCAP, "Information, Communication and Space Technology for Meeting Development Challenges," United Nations Economic and Social Council, Seventh Session, Bangkok, Thailand, 10-11 May 2005, 7, http://www.unescap.org/LDCCU/SB7_Item%205.doc.

8. Wikipedia, "List of mobile network operators of the Asia Pacific region," Wikimedia Foundation, Inc., http://en.wikipedia.org/wiki/List_of_mobile_network_operators_of_the_Asia_Pacific_region.

Хүснэгт 5. Ази, Номхон далайн бүсэд Интернэт нэвтэрсэн байдал болон хэрэглээ

Улс	Хүн ам (2007 оны байдлаар)	Интернэт хэрэглэгчид (2000 оны байдлаар)	Интернэт хэрэглэгчид (Хамгийн сүүлийн үеийн мэдээлэл)	Нэвтрэлт	Ази дахь хэрэглэгчдийн хувь хэмжээ	Хэрэглэгчдийн өсөлт (2000-2007)
Өмнөд Ази						
Бангладеш	137,493,990	100,000	450,000	0.3%	0.1%	350.0%
Бутан	812,814	500	30,000	3.7%	0.0%	5,900.0%
Энэтхэг	1,129,667,528	5,000,000	60,000,000	5.3%	13.1%	1,100.0%
Мальдив	303,732	6,000	20,100	6.6%	0.0%	235.0%
Мянмар	54,821,470	1,000	300,000	0.5%	0.1%	29,000.0%
Непал	25,874,519	50,000	249,400	1.0%	0.1%	398.0%
Пакистан	167,806,831	133,900	12,000,000	7.2%	2.6%	8861.9%
Шри-Ланка	19,796,874	121,500	428,000	2.2%	0.1%	
Зүүн-Өмнөд Ази						
Бруней	403,500	30,000	165,600	41.0%	0.0%	452.0%
Кампучи	15,507,538	6,000	44,000	0.3%	0.0%	633.3%
Индонези	224,481,720	2,000,000	20,000,000	8.9%	4.4%	900%
Лаос	5,826,271	6,000	25,000	0.4%	0.0%	316.7%
Малайз	28,294,120	3,700,000	14,904,000	52.7%	3.2%	302.8%
Филиппин	87,236,532	2,000,000	14,000,000	16.0%	3.0%	600.0%
Сингапур	3,654,103	1,200,000	2,421,800	12.6%	1.8%	268.1%
Зүүн Тимор	958,662	-	1,000	0.1%	0.0%	0.0%
Вьетнам	85,031,436	200,000	17,220,812	20.3%	3.7%	8,510.4%
Төв Ази						
Афганистан	27,089,593	1,000	535,000	2.0%	0.1%	53,400.0%
Армен	2,950,260	1,000	535,000	2.0%	0.0%	476.0%
Азербайжан	8,448,260	12,000	829,100	9.8%	0.2%	6,809.2%
Гүрж	4,389,004	20,000	332,000	7.6%	0.1%	1,560.0%
Казахстан	14,653,998	70,000	1,247,000	8.5%	0.3%	1,689.4%
Киргызстан	5,436,608	51,600	298,100	5.5%	0.1%	477.7%
Монгол	2,601,641	30,000	268,300	10.3%	0.1%	794.3%
Тажикстан	6,886,825	2,000	19,500	0.3%	0.0%	875.0%
Туркменстан	6,886,825	2,000	64,800	0.9%	0.0%	3,140.%
Узбекстан	26,607,252	7,500	1,745,000	6.6%	0.4%	23,166.7%
Зүүн Ази						
Хятад	1,317,431,495	22,500,000	162,000,000	12.3%	35.3%	620.0%
Хонгконг*	7,150,254	2,283,000	4,878,713	68.2%	1.1%	113.7%
Япон	128,646,345	47,080,000	87,540,000	68%	19.1%	85.9%
БНАСАУ	23,510,379	-	-	-	-	0.0%
БНСУ	51,300,000	19,040,000	34,120,000	66.5%	3.2%	131.6%
Макао*	500,631	60,000	201,000	40.1%	0.0%	235.0%
Тайван	23,001,442	6,260,000	14,500,000	63.0%	3.2%	131.6%

(Үргэлжлэл...)

Улс	Хүн ам (2007 оны байдлаар)	Интернэт хэрэглэгчид (2000 оны байдлаар)	Интернэт хэрэглэгчид (Хамгийн сүүлийн үеийн мэдээлэл)	Нэвтрэлт	Ази дахь хэрэглэгчдийн хувь хэмжээ	Хэрэглэгчдийн өсөлт (2000-2007)
Номхон далайн бүс						
Америкийн Самоа	57,663	1.6 %	-	-	-	0.0 %
Антарктик	1,446	0.0 %	-	-	-	0.0 %
Австрали	20,434,176	60.9 %	15,504,532	75.9 %	80.9 %	134.9 %
Австралийн гаднах нутаг дэвсгэр	3,750	5.6 %	-	-	-	0.0 %
Кристмасын арлууд	1,493	0.0 %	464	31.1 %	0.0 %	0.0 %
Кокосын арлууд	618	0.0 %	-	-	-	0.0 %
Коокын арал	21,750	0.1 %	3,600	16.6 %	0.0 %	0.0 %
Фижи	0918,675	02.7 %	80,000	8.7 %	0.4 %	966.7 %
Францын Полинез	278,963	0.8 %	65,000	23.3 %	0.3 %	712.5 %
Гуам	169,879	0.5 %	79,000	46.5 %	0.4 %	1,480.0 %
Крибати	93,565	0.3 %	2,000	2.1 %	0.0 %	100.0 %
Машаллын арлууд	55,449	0.2 %	2,200	4.0 %	0.0 %	340.0 %
Микронези	110,064	0.3 %	16,000	14.5 %	0.1 %	700.0 %
Науру	11,424	0.0 %	300	2.6 %	0.0 %	0.0 %
Нью Каледон	243,233	0.7 %	80,000	32.9 %	0.4 %	233.3 %
Шинэ Зеланд	4,274,588	12.4 %	3,200,000	74.9 %	16.8 %	285.5 %
Ниуе	1,722	0.0 %	450	26.1 %	0.0 %	0.0 %
Норфолкын арлууд	1,673	0.0 %	700	41.8 %	0.0 %	0.0 %
Хойд Марианна	84,228	0.2 %	10,000	11.9 %	0.1 %	0.0 %
Палау	21,897	0.1 %	-	-	-	0.0 %
Папуа Шинэ Гвиней	6,157,888	17.9 %	170,000	2.8 %	0.9 %	25.9 %
Питкарны арлууд	46	0.0 %	-	-	-	0.0 %
Самоа	184,633	0.5 %	8,000	4.3 %	0.0 %	1,500.0%
Жижиг арлууд(4)	4,397	0.0 %	-	-	-	0.0 %

*Хятадын статистик ороогүй

Эх сурвалж: Repurposed from Internet World Stats, "Asia Marketing Research, Internet Usage, Population Statistics and Information," Miniwatts Marketing Group, <http://www.internetworldstats.com/asia.htm>.

Харилцаа холбоо, МХХТ-ийн хөгжил бүс нутгуудад тэгш бус байгаагаас хамааран тоон хуваагдал хэмээн өнөө үед нэрлэх болсон асуудал үүсээд буй билээ.

Тоон хуваагдал хэмээн нэрлэж буй зүйл нь хэд хэдэн ялгаа, заагийг илэрхийлж байна. Технологийн хуваагдал байгаа бөгөөд дэд бүтцийн хувьд ихээхэн том хуваагдал үүссэн байна. Мөн контентийн хуваагдал байсаар байна. Вебд суурилсан маш их мэдээлэл нь хүмүүсийн бодит хэрэгцээнд хамааралгүй мэдээлэл байгаа юм. Дэлхийн хэмжээнд буй вебсайтуудын бараг 70 хувь нь Англи хэл дээр байгаа нь орон нутгийн дуу хоолой болон үзэл бодлыг бууруулж байна. Хүйсийн хуваагдал буюу охид эмэгтэйчүүд хөвгүүд, эрэгтэйчүүдийг бодвол мэдээллийн технологийн хүртээмж хавьгүй доогуур нөхцөлд байна. Энэ нь баян болон ядуу орнуудад ч ижил байгаа юм.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны Мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үгнээс, 2003 оны 12 дугаар сарын 10, Швейцар улсын Женев хот. <http://www.itu.int/wsis/geneva/coverage/statements/opening/annan.html>

Тоон хуваагдал хэмээх үг нь нийгэм, хувь хүмүүст буй мэдлэгт суурилсан эдийн засагт оролцоход үүсч буй ялгааг тодорхойлдог. Хамгийн гол нь энэ нь хүйс, орлого, хөгжил болон боловсролын тэгш бус байдлаар илэрдэг. Экономист (The Economist) сэтгүүлд дурдсанчлан “Ядуу орнуудад баячуудаасаа цөөн тооны хүмүүс компьютертэй байж, Интернэтэд орж чадахгүй байгаа нь тэдгээр хүмүүс хэт ядуу, бичиг үсэг мэдэхгүй эсвэл хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг тэргүүлэх хэрэгцээгээ хангах шаардлагатай улмаас шалтгаалж байна”⁹ хэмээжээ. Үүний зэрэгцээ тоон хуваагдал нь нийгмийн тэгш бус байдлыг үүсгэх нэгэн шалтгаан болдог. Чен болон Веллман нарын үзсэнээр “Тоон хуваагдлын сөрөг талд буй хувь хүмүүс, нийгмийн бүлгүүд болон улс орон нь мэдлэгт суурилсан эдийн засгаас хол хөндий байдаг. Өөрөөр хэлбэл компьютер, Интернэт ашиглах талаар өмнө нь үүссэн байсан тэгш бус байдал нь Интернэт зэрэг технологи ажил олох, мэдээлэл хайх, иргэний оролцоог хангах гол зүйл болон хувирахад илүү эрчимтэйгээр нэмэгдэж иржээ¹⁰.” Тиймээс тоон хуваагдлын асуудлыг шийдвэрлэх нь мэдээллийн технологийг зүгээр нэг нэвтрүүлээд орхих бус харин МХХТ-ийг МХЗ-уудад хүрэхийн тулд олон салбарт буй ялгаа, орхигдлыг нөхөхөд ашиглах оролдлого хэмээн үзэж болно.

Тоон хуваагдал нь өөрөө шийдэгдэхгүй: үүнийг технологийн өөрчлөлтөд найдан орхиж болохгүй. Ядуурлыг бууруулах стратегид суурилсан хөгжлийн бодлогыг харгалзах МХХТ-ийн бодлоготойгоор боловсруулан гаргаж, үүний үндсэн дээр дэд бүтэц, институцууд, аргачлалыг боловсруулан гаргах замаар хуваагдлыг багасган, бүх нийтийн хүртээмжийг хангах урьдчилсан нөхцөл болгох ёстой. МХХТ-ийн дэд бүтцэд дангаар нь хөрөнгө оруулж, хөгжлийн бусад чухалчлах салбаруудыг үл тоомсорлон орхих стратеги нь сөрөг үр нөлөөтэй байж болно. Олон орнууд эдийн засгийн хөгжилд тулгараад буй илүү суурин гэж болох асуудал жишээ нь суурь дэд бүтцээ сайжруулах, зах зээлээ нээх, харилцаа холбооны монополийг эвдэх, үр дүнтэй эрх зүйн болон зохицуулалтын системийг бий болгох, бүх нийтэд боловсрол олгох асуудалд хандсан үйл ажиллагааг явуулах шаардлагатай болдог. Эдгээр асуудлуудыг үл тоомсорлон орхиж, компьютержүүлэх болон Интернэтийн хүртээмжийг бий болгоход илүү анхаарал хандуулсан олон орон эцэстээ нөөц эх үүсвэрийг үр дүнгүй зарцуулсан, МХХТ-ийг ашиглах чадавхи хөгжөөгүй хэвээр үлдсэн байдаг. Өөрөөр хэлбэл тоон хуваагдлыг арилгах үйл ажиллагаа нь бүх нийтийн хүртээмжийг хангахад чиглэхийн зэрэгцээ МХХТ-ийн хэрэглээг олон нийтийн түвшинд бий болгоход мөн анхаарах шаардлагатай билээ.



ДАСГАЛ

Танай орон дахь тоон хуваагдлыг үүсгэж байгаа таван хүчин зүйлийг өөрийн бодлоор тодорхойлно уу. Хүчин зүйл болгонд тухайн шалтгааныг арилгах стратегийн жагсаалтыг гарга.

Бүх нийтийн хүртээмжийг бий болгох нь

МХХТ-ийн хөгжлийн хурдцыг аваад үзвэл ядуу орнуудын Засгийн газрууд өөрсдийн санхүү болон улс төрийн хязгаарлагдмал нөөц эх үүсвэрийг нийгмийн болон хүний капиталыг хөгжүүлэх, суурь дэд бүтцийг барьж байгуулах, хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд зарцуулдаг. Хувийн хэвшлийн оролцоог хангах нь дэд бүтцийн хөгжлийн хурдцыг нэмэгдүүлээд зогсохгүй төрийн нуруун дээрх ачаанаас хөнгөвчилсөнөөр хөрөнгө оруулалт хамгийн ихээр шаардлагатай байгаа салбаруудад Засгийн газар хөрөнгө хүчээ төвлөрүүлэх боломжийг хангаж байдаг. Өөрөөр хэлбэл Засгийн газрын үүрэг роль нь МХХТ хөгжих үндэс суурийг л бий болгох явдал хамгийн чухал билээ.

9. “Technology and development,” The Economist (10 March 2005), http://www.economist.com/displaystory.cfm?story_id=3742817.

10. Wenhong Chen and Barry Wellman, Charting and Bridging Digital Divides: Comparing Socio-economic, Gender, Life Stage, and Rural-Urban Internet Access and Use in Eight Countries (The AMD Global Consumer Advisory Board, 2003), 25, http://www.amd.com/us-en/assets/content_type/DownloadableAssets/FINAL_REPORT_CHARTING_DIGI_DIVIDES.pdf.

Албан болон албан бус боловсролд хөрөнгө оруулах нь өөр нэгэн чухалчлах асуудал билээ. Олон улсын туршлагаас харвал боловсрол болоод үүнтэй хамааралгүй бусад МХЗ-уудад хүрэхэд боловсрол ихээхэн чухал байдаг юм. Бага болон дунд боловсролын хүртээмж нь хүний нөөцийг хөгжүүлэх ба энэ нь цаашлаад инновац болон томоохон хэмжээний өсөлтийг хангах юм. Тоон хуваагдлыг нөхөх үйл явцын хувьд боловсрол нь хамгийн чухал бөгөөд учир нь боловсрол л МХХТ-ийг бий болгох, хөгжүүлэх, ашиглах эх үүсвэрийг бий болгож байдаг. Тиймээс боловсрол нь МХХТ-ийн суурь хэрэглээнээс ч илүүтэй чухал салбар болж буй билээ.

Гуравдахь чухалчлах зүйл нь харилцаа холбооны салбарт бодит дэд бүтцийг бий болгох явдал билээ. Энэ тал дээр Засгийн газрын хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай бөгөөд учир нь хамгийн ядуу иргэдийг ч энэхүү сүлжээнд холбох нь хувийн хэвшлийн хувьд зах зээлийн эрэлтийг ихэсгэх үүднээс тийм ч ашигтай сонголт бус ба өндөр өртөг бүхий дэд бүтцийг барьж байгуулах сонирхол төрөхгүй байдаг. Хөдөөгийн дэд бүтцэд хөрөнгө оруулахад хувийн хэвшил хөрөнгө оруулахаар болсон ч гэсэн Засгийн газар нь зохицуулах үүргийг гартаа аван стандарт бий болгох, үйл ажиллагаа явуулах орчныг сайжруулах болон зохицуулалтыг хөнөгөвчилсөнөөр өсөлтийг дэмжиж ч болно.

Олон нийтийн түвшинд Засгийн газрууд нь орон нутгийн иргэдийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, өргөтгөх бүх нийтийн үйлчилгээний байгууламжуудыг бий болгох арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай. Үүнд баримтлах хоёр паралел арга зам байдаг. Үйлчилгээ үзүүлэгчийн үүднээс хөгжлийн мэдлэгийг хадгалах, шинэчлэх шаардлагатай динамик портал заавал шаардлагатай. Хэрэглэгчийн хувьд олон нийтийн теле-төвүүд эсвэл үйлчилгээний газрыг байгуулах нь дээр дурдсан портал дээр дурдсан мэдлэгийг хүртэх боломжийг хялбарчлах юм.

Теле-төвүүдийг ашиглах нь

Олон нийтийн радио, телевиз зэрэг өмнөх үеийн аргачлалуудын адилаар теле-төв нь тосгоны хувьд нийтлэг хэрэглэх эх үүсвэр байж болох ба энэхүү байгууламжийн үр шимийг тухайн тосгоны хүн болгон хүртэх боломжтой болох юм. Теле-төвүүд нь олон нийтэд МХХТ-д суурилсан үйлчилгээ, хэрэглээг ханган өгдөг стратегийн байрлал бүхий байгууламжууд билээ. Хэмжээ болон үзүүлж буй үйлчилгээний цар хүрээнээс хамаараад эдгээр төвүүдийг байнгын ажилтан-менежер эсвэл цөөн тооны сайн дурын ажиллагсад, цагийн ажилтнууд ч ажиллуулж болно.

Теле-төв нь олон төрөл, хэлбэртэй байдаг. Зарим улсад теле-төв нь утас, факс, баримт бичиг олшруулах, хэвлэх, шивэх болон жижиг бизнесийн ня-бо бүртгэл зэрэг энгийн үйлчилгээг үзүүлдэг. Эдгээр энгийн теле-төвүүд нь арилжааны хувьд амжилттай ажиллах, улмаар олон төрлийн үйлчилгээг ханган нийлүүлдэг теле-төв болон хөгжих ихээхэн боломж, бололцоотой байдаг юм.

Зарим теле-төв нь иргэд Интернэтийн үйлчилгээ авч болох кибер кафе байдалтай байдаг. Эдгээр нь олон төрөл үйлчилгээт теле-төв болон хөгжих ихээхэн боломжтой, олон нийтэд хэрэгтэй үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ, ашигтай ажиллах ч боломжтой.

Зарим орнуудад теле-төв нь “мэдээллийн цэг” хэлбэртэй буюу иргэд тодорхой мэдээллийг (жишээ нь хөдөө аж ахуйн холбогдолтой мэдээлэл гэх мэт) төлбөртэй авдаг газар хэлбэртэй байдаг. Энэтхэгийн Цахим Чоупал (e-Choupal) нь хувийн хэвшлээс хийж буй ийм төрлийн хүчин чармайлтын нэг жишээ билээ. Эдгээр төвүүдийн зарим нь Интернэтийн үйлчилгээ үзүүлэхээс гадна компьютерийн сургалт ч явуулдаг.

Бусад теле-төв нь төрийн үйлчилгээ үзүүлэх жишээ нь Засгийн газраас гаргасан ядуурлын холбогдолтой баримт бичгүүд, татвар болон төлбөр төлөх төвүүдийн хэлбэрээр ажилладаг. Эдгээр цахим засгийн (e-government) төвүүд нь тосгоны иргэдийн хувьд ихээхэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүчин чармайлтыг хэмнэх боломжийг хангахын зэрэгцээ теле-төвийг ажиллуулж буй байгууллагын хувьд ч тодорхой хэмжээний ашигтай байдаг ажээ¹¹. Ийм төрлийн үйл ажиллагааны жишээнд Монгол улсын дөрвөн бүсд байгуулагдсан Интернэт мэдээллийн төв орно.

11. Usha Vyasulu Reddi, Training Commons Modules Introductory Booklet, (Ottawa: IDRC, 2008) <http://www.telecenter.org>



Монгол улс дахь Интернет мэдээллийн төв

Энэ төсөл нь Эрдэнэт, Ховд, Дорнод, Өмнөговь аймгууд буюу Монгол улсын дөрвөн өөр бүсэд хэрэгжжээ. Олон нийтийн Интернетийн төв хэмээх нэр бүхий эдгээр теле-төв нэг бүр зургаан компьютер, модем болон бусад тоног төхөөрөмжтэйгээр байгуулагдан зургаан портоор диал-ап хэлбэрээр холбогдон Интернет, имейл болон факсын үйлчилгээ, веб хостинг болон веб хийх, орон нутгийн телефон утасны үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлж байна. Эрдэнэт, Дорнод дахь теле-төвүүд нь Интернетэд Ви-CAT (VSAT) холболтоор 64 килобайтын хурдаар холбогдож байв.

Төслийн санхүүжүүлэгч нарын шаардсаны дагуу Олон нийтийн Интернетийн төв нь сургуулиуд, орон нутгийн төрийн байгууллагууд болон ТББ-уудыг үнэгүй Интернетээр хангаж байна. Дунд сургуулиуд, орон нутгийн төрийн байгууллагуудыг радио модемоор холбожээ. Аж ахуйн нэгжүүд Интернетийг төлбөртэй хэрэглэдэг байна.

Орон нутгийн номын сан нь Олон нийтийн Интернетийн төвийн Удирдлагын хорооны нэг гишүүн нь юм. Олон нийтийн Интернетийн төв нь орон нутгийн төрийн байгууллагатай нягт хамтран ажилладаг бөгөөд эдгээр байгууллагууд нь Олон нийтийн Интернетийн төвийг ажиллах байраар хангадаг байна.

Эрчим хүч, холболт, хэл болон компьютерийн нэвтрэлт зэрэг асуудлууд төвийн үйл ажиллагаанд тулгардаг гол асуудлууд байдаг ажээ. Гэсэн ч тулгарсан асуудлуудыг шийдсэнээр найдвартай, удирдлага сайтай теле-төвүүдийг үүсгэн бий болгож чаджээ. Энэхүү жишээ нь Интернетийг хөгжлийн зорилгоор ашиглах боломжийг харуулж буй юм. Хэдийгээр өнөөгийн байдлаар сургалт, харилцаа холбооны зорилгоор голдуу ашиглаж буй ч Олон нийтийн Интернетийн төвийг олон нийтэд суурилсан хөгжлийн зорилгод ашиглаж буй зарим нотолгоо энд гарч буй билээ.

Эх сурвалж: Adapted from Harris, Roger, "Telecentres in Rural Asia: Towards a Success Model" (Paper presented at the International Conference on Information Technology, Communications and Development, 29-30 November 2001, in Kathmandu, Nepal), <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/apcity/unpan006304.pdf>.



АСУУЛТ

Монгол дахь Олон нийтийн Интернетийн төвтэй адил теле-төв танай оронд тохирох уу? Яагаад?

Теле-төвүүдийн үйл ажиллагаанд анхаарах зүйлс: Доорх анхаарах зүйлс нь их энгийн мэт боловч тэднийг бүтээлчээр хэрэгжүүлсэн тохиолдолд теле-төвүүд амжилттай ажиллах боломжтой болдог. Теле-төвүүдийн амжилт болон азгүйтлийн олон тооны жишээ байдаг. Бүтэлгүй болсон олон тооны загварын ихэнх нь хөгжиж буй орнуудад хамаардаг. Тэдгээр орнууд нь ноу-хау дутмаг, үүнийг хэрхэн бодит байдал дээр хэрэгжүүлэхийг мэдэхгүйгээс амжилтад хүрдэггүй ажээ:

- Санхүүжилт болон тогтвортой байдал – шаардлагатай нөөц эх үүсвэрийг босгох, маркетинг болон бизнесийн төлөвлөлт хийх, үнэ тогтоох зэрэг дээр мэдлэг, ур чадвар дутагдах явдал ихээр гардаг.
- Өөриймшүүлэх болон үйл ажиллагааг явуулах загвар – теле-төвүүдийг байгуулах болон үйл ажиллагааг ашигтайгаар удирдан явуулахад мэдлэг, ур чадвар дутагдах тохиолдол их байдаг.

- Хүний нөөц - теле-төвүүдийн удирдлага, ажиллагсад нь ихэнхдээ бага цалинтай байдаг тул сайн дурынхан дээр суурилан үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнээс үүдэн ажиллагсадыг урамшуулах, идэвхжүүлэх болон тогтвортой ажиллуулахад хүндрэл учирдаг байна.
- Сургалт болон чадавхийг бэхжүүлэх - төвийн менежерүүд, ажиллагсад нь ихэнхдээ ахисан түвшний үйл ажиллагаанд сургагдаагүй байдаг. Тэд төвийн үйл ажиллагааг эрхлэн явуулахын зэрэгцээ бизнес болон маркетинг, олон нийтийг идэвхжүүлэх, мэдээлэл болон харилцаа холбооны чиглэлээр суралцах шаардлагатай тулгардаг¹².

Нөгөө талаар амжилттай хэрэгжсэн жишээнүүдээс аваад үзвэл амжилт, алдааны ялгаа заагийг сайтар ойлгон, теле-төв болон орон нутгийн мэдээллийн порталыг бий болгох нь тоон хуваагдлыг арилгах боломжит сонголт байдаг. Жижиг хэмжээний орон нутагт суурилсан теле-төвүүд нь том, жижиг болон алслагдсан орнуудад ч амжилттай хэрэгжсэн байна. Жишээ нь Австрали болон Канадад алслагдсан суурин газруудыг теле-төв буюу үүнтэй ижил хэмжээний мухлаг маягийг төвөөр дамжуулан төрийн үйлчилгээтэй холбожээ. Хол тархан суурьшсан, цөөн тооны хүн ам бүхий жижиг арлын, эсвэл далайд гарцгүй, уулархаг орнуудын хувьд теле-төвүүд нь МХХТ-ийн дэмжлэг бүхий хөгжлийн тохиромжтой стратеги байж болно.



ДАСГАЛ

Танай улсад теле-төв байгуулж болох тохиромжтой газрыг тодорхойл. Ямар төрлийн теле-төвийг байгуулах, ямар тоног төхөөрөмжөөр хангах, ямар үйлчилгээг үзүүлэх, санхүүгийн хувьд тогтвортой болгохын тулд ямар загварыг сонгох зэргийг тодорхойл.

Жижиг арлын, далайд гарцгүй, уулархаг орнуудад холболт үүсгэх нь

Жижиг арлын, далайд гарцгүй, уулархаг орнууд нь үндсэндээ нийтлэг шинж чанартай байдаг. Юуны өмнө эдгээр орнууд нь хүн ам цөөтэй, жижиг эдийн засагтай, жижиг зах зээлтэй, хүний болон техникийн нөөц хязгаарлагдмал байдаг. Зарим тохиолдолд тэдгээр орнууд нь байгалийн нөөц баялагийн хувьд ч хязгаарлагдмал байдаг. Хоёрдугаарт тэдэнд орон зайн хамаарлын асуудлууд их байдаг ба арлын жижиг орнууд нь далайгаар тусгаарлагдмал, уулархаг орнуудын зам даваа байнга хаагдах зэрэг бэрхшээл тулгардаг. Энэ ангилалд хамрах бүх орнууд нь ихэнхдээ хомс үйлчилгээг хүлээн авдаг, алслагдсан хүн амтай. Бүгдэд нь тээвэр болон харилцаа холбооны асуудал тулгардаг бөгөөд цахилгаан холбооны систем нь сул хөгжсөн байдаг. Гуравдугаарт энэ төрөлд хамаарах бүх улс нь нэг талаасаа байгалийн нөхцөлөөс хамааралтай, нөгөө талаар мөн дэлхий даяар явагдаж буй даяаршил, либералчлал болон хувьчлалаас хамааралтай байна. Эдгээр орнуудын зарим нь эдийн засаг, улс төрийн хувьд хүчирхэг хөрш орнуудаар хүрээлэгдсэн байхаас гадна цөөн хэд нь олон жилийн туршид хүрсэн хөгжлийн үр дүнгүүдийг нэг мөсөн арилгаж чадах үндэстний мөргөлдөөнөөс ангид байдаг ажээ.

Арлын орнууд нь далайн усны түвшин нэмэгдэх, давсжилт нэмэгдэхээс үүдэн амьжиргаа муудах, усны бохирдол, далайд газрын тос алдагдах, цөмийн бохирдол зэрэг байгалийн нөлөө, хумхаа зэрэг гаднаас орж ирэх эрүүл мэндэд хор нөлөөт өвчнүүд, хиймэл дагуул болон кабель доголдох зэрэг техникийн нөлөөнөөс ихээхэн хамааралтай байдаг. Далайд гарцгүй, уулархаг орнууд нь мөн л өөрийн гэсэн асуудлуудтай байдагийн тоонд хөдөө аж ахуйн үржил шим муу байх, хэт алслалт, газар хөдлөлт, хөрсний гулгалт болон бусад гамшиг багтана.

12. Raul Roman & Royal D. Colle, Themes and Issues in Telecentre Sustainability, Development Informatics, Paper no. 10 (Manchester: Institute for Development Policy and Management, University of Manchester, 2002), http://www.sed.manchester.ac.uk/idpm/research/publications/wp/di/di_wp10.htm.

Газар зүйн байрлалаас үүдэн тулгарч буй асуудлуудыг шийдэх нэгдмэл нэг шийдэл гэж байхгүй, уламжлалт аргууд ч үр дүнгээ өгөхгүй байж болно. Энэ тохиолдолд үл хязгаарлагдмал шийдэл буюу тодорхой нэг хязгаарлагдмал хүрээнээс гадуур сэтгэсэн шийдэл болон бүс нутгийн түншлэл шаардлагатай болно. Жижиг арлын хөгжиж буй орнуудын сүлжээ (SIDSNet) нь хамтын ажиллагаа болон боломж, сонирхол, технологи зэргийн нэгдэн нийлэлтийн зарчмыг ашигласан сүлжээ юм.



Хөгжиж буй арлын жижиг орнуудын сүлжээ (SIDSNet)

SIDSNet нь 1997 онд Барбадосын үйл ажиллагааны хөтөлбөрийн дараагийн үе шат хэлбэрээр байгуулагдсан. Үүний гол зорилго нь жижиг арлын хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг сайжруулан МХХТ-ийн тусламжтайгаар дэмжих явдал байлаа.

SIDSNet нь арлын орнуудад нийтлэг тулгарч буй хэд хэдэн асуудлууд болох (1) алслагдмал байдал, тусгаарлагдмал байдал болон газар зүйн тархалт; (2) тааруу холболт болон мэдээллийн удирдлага; (3) хүний болон технологийн хязгаарлагдмал чадавхи; болон (4) арлын орнуудын эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад олон улсын хэмжээний анхаарлыг татах, тусламж дэмжлэгийг хүртэх шаардлагыг үүсгэх зэрэг асуудлуудыг шийдэх зорилготой байлаа. Үүнийг хэрэгжүүлэхдээ МХХТ-ийг ашиглан алслагдсан орон нутгуудыг холбон, техникийн экспертиз, боловсрол, мэдлэгийг хуваалцан, инновац, үндэсний чадавхи, нөөцийн зохистой ашиглалтыг хангах замаар халамжийн үйлчилгээг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлийн үйл ажиллагааг явуулсан байна.

SIDSNet-ийн весайтаар дамжуулан нэгдэн орсон орнууд нь харилцаа холбоо тогтоон эрүүл мэнд, байгаль хамгаалал, боловсрол, цэвэр ус болон ариун цэвэр, аялал жуулчлал, хүний нөөцийн хөгжил зэрэг хөгжлийн тэргүүлэх салбарууд дахь өөрсдийн мэдлэг, шилдэг туршлагаа хуваалцах боломжтой болжээ. Тус сүлжээ нь мөн арлын орнуудын техникийн туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан мэдлэг хуваалцах виртуал солилцоо буюу экспертүүдийн онлайн бүртгэлийг ажиллуулсан байна. 2005 онд болсон Мавританы олон улсын уулзалтаар батлагдсаны дагуу SIDSNet нь мөн Арлын орнуудын их сургуулиудын консорциумын гол портал хэлбэрээр ажилласан байна.

SIDSnet нь Интернетийн мэдлэг, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хүчирхэг нөлөөлөгч болсон юм. Чадавхийг бэхжүүлэх салбарт энэхүү сүлжээ нь технологи дамжуулах салбарт Өмнөдөөс Өмнөд болон Арлын орнуудаас Арлын орнуудад хэмээх зарчмаар ажиллажээ. Хамтын ажиллагаа, мэдээлэл хуваалцах салбарт SIDSNet нь харилцан холболтыг сайжруулах, хэрэглэгчдэд имейлийн системийг нээн өгч, мэргэжилтнүүдтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой чатыг бий болгосон байна. SIDSNet нь мөн зохион байгуулагдах үйл ажиллагааны календарыг ажиллуулсанаар төрийн байгууллагууд өөрийн хязгаарлагдмал нөөц эх үүсвэрийг стратегитэйгээр зарцуулах боломжийг ханган өгсөн байна. SIDSNet нь арлын орнуудын хэвлэлийн материал, эрдэм шинжилгээ, судалгаа, НҮБ-ын шийдвэр болон тогтоолууд, хөгжлийн үзүүлэлтүүд, үндэсний болон бүс нутгийн статистик зэрэг материалын мэдээллийн санг үүсгэснээр судалгаа, мэдээллийн удирдлагыг сайжруулсан ажээ. Эцэст нь SIDSNet арлын орнуудын хөгжлийн голлох сорилтуудын талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлсэнээр арлын орнуудыг олон улсын бодлогын хүрээнд багтаан санхүүгийн урсгал, техникийн туслалцааг татаж чадсан байна.

Эх сурвалж: Adapted from SIDSNet, "About SIDSNet," Division for Sustainable Development of the United Nations, <http://www.sidsnet.org/5.html>.



АСУУЛТ

SIDSNet мэтийн ийм санаачилга Төв Азийн далайд гарцгүй орнуудад тохиромжтой байх уу? Ийм төрлийн түншлэлийн гол элемент нь юу байх вэ?

Зарим төрлийн МХХТ-ийн дэмжлэг бүхий санаачалгад төрийн бодлогын дэмжлэг шаардлагатай байдаг бол зарим тохиолдолд олон нийтэд суурилсан үйл ажиллагаанаас ихээхэн үр дүнд хүрэх боломж бас байдаг. Непалын Нанги тосгоны төсөл энэ талаар илүү тодорхой харуулна.



Мод ба кибер: Непалын Нанги тосгоны төсөл

Нанги нь Непал улсын баруун хэсэгт Гималайн нурууны Аннапурна, Дхаулагири оргилын зэргэлдээ далайн түвшнээс дээш 7300 метрийн өндөрт оршдог 800 оршин суугчтай тосгон юм. Тус тосгон руу очихын тулд хамгийн ойр байгаа томоохон хот болох Бенигээс 6-9 цаг алхаж, олон уул даваа, ой шугуйг гатлан хүрдэг байна. Тус тосгонд ямар нэгэн үйлдвэр байхгүй оршин суугчид нь зөвхөн модон анжис, хүрз, алх, сүх хадуур, бахь зэрэг гар багаж ашиглан жижиг фермерийн аж ахуй эрхлэдэг ажээ. Тус тосгонд ямар нэгэн машин тоног төхөөрөмж, автомат багаж байхгүй.

Ойролцоогоор 10 жилийн өмнө тус тосгоны сургуулийн багш Махабир Пуны санаачлагаар Интернетийн давуу талуудыг өргөн ашиглах үйл ажиллагаа эхэлжээ. Эхлээд тосгоны жижиг модон байшинд компьютер байрлуулан, бага оврын усан цахилгаан станц байгуулж, Wi-Fi холболтоор ойролцоох дөрвөн тосгон, 22 милийн зайтай томоохон хот болох Покара хотын Интернетийн сүлжээнд холбогдсон байна. Покарагийн Интернет үйлчилгээ эрхлэгчтэй холбогдох 12 цэгийг нээн, үйлдвэрлэгч нараас хямд үнээр нийлүүлсэн тоног төхөөрөмжийг суурилуулсан байна.

Өнгөрсөн 11 жилийн хугацаанд Пун болон тосгоны оршин суугчид номын сантай дунд сургууль, ой үржүүлгийн газар, Покара хоттой видео теле-анагаах ухааны холбоо бүхий эрүүл мэндийн төв, мужааны газар, цаас үйлдвэрлэх газар, оёдлын цех, аялагчдад зориулсан амралтын газар (имейл ашиглах боломжтой), загасны болон сарлагийн ферм зэргийг барьж байгуулсан байна. Тосгоны компьютерийн лаборатори нь олон газраас хандивласан тоног төхөөрөмжтэй болжээ.

Гадаад ертөнцтэй холбогдох боломжтой болсон нь Нанги тосгон орчин үеийн теле-анагаах ухааны системтэй, бусад тосгоны харилцах холбоотой, сайжирсан хөдөө аж ахуйтай, хүүхдүүдэд компьютерийн хэрэглээг заах боломжтой болгожээ.

Ихэнхдээ хөгжиж буй орнуудад сүлжээ байгуулах нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, дэд бүтцийг шаарддаг, үүнийг Засгийн газар болон донор байгууллагууд л гаргаж чадна гэж үзэх тохиолдол элбэг байдаг. Нанги тосгоны энэхүү төсөл нь зардал багатай, хямд өртөгтэй санаачлага нь томоохон өөрчлөлтийг авчирч болно гэдгийг батлан харуулсан юм. Нанги зэрэг бичил төслүүд нь орон нутагт тулгараад буй асуудлуудыг шийдэх, тохирох шийдлийг олон нийтийн оролцоотойгоор гарган ирэх, олон нийтийн өөрчлөлтийг түргэсгэгч болон бүтээгч болгосон билээ.

Эх сурвалж: Adapted from Ruth, Stephen and Jiwan Giri, "Defying the Odds: A Success Story from the Mountains of Nepal," Information Technology in Developing Countries, Vol. 17, No. 3, November 2007: 7-10, <http://www.iimahd.ernet.in/egov/ifip/nov2007/nov2007.htm>.



АСУУЛТ

Нанги тосгоны төсөлтэй ижил санаачлагыг танай оронд хуулбарлан хэрэгжүүлж болох уу? Үүнийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд юу шаардлагатай бэ? Тухайн төслийг хуулбарлан хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлсүүдийг харгалзан үзэх ёстой вэ?

ДҮГНЭЛТ

- Тоон хуваагдал нь иргэд, нийгмийн дотор байгаа мэдээлэлжсэн нийгмийн нөөц эх үүсвэрүүдийн хүртээмжийн ялгаа юм.
- Тоон хуваагдал нь нийгэм, хувь хүмүүст буй эдийн засаг, нийгмийн тэгш бус байдал, ялангуяа хүйс, орлого, хөгжил болон боловсролын тэгш бус байдлаар илэрдэг.
- Тоон хуваагдлыг арилгах нь зөвхөн МТ бус илүү өргөн хүрээг хамарсан асуудал билээ.
- Бодит дэд бүтцийг байгуулах, бүх нийтийн үйлчилгээний байгууламжууд буюу төлөвүүдийг орон нутгийн олон нийтийн түвшинд бий болгох замаар бүх нийтийн хүртээмжийг бий болгох шаардлагатай.
- Мэдээллийн динамик сан байдлаар порталуудыг байгуулах, эх үүсвэрээ хуваалцахын тулд үндэсний хэмжээний болон бүс нутгийн түншлэлийг хөгжүүлэх шаардлагатай.

Модулийн энэхүү бүлэгт МХХТ болон МХЗ-уудын харилцан хамаарлыг өргөн хүрээнд харуулах, МХЗ-уудад хүрэх стратегид МХХТ нь чухал аргачлал мөн гэдгийг батлахаар зорьсон юм. Дараагийн бүлэг нь МХХТ-ийг МХЗ-уудтай хамаарах өөр өөр салбарт хэрхэн хэрэглэх талаар тусгайлан судлах болно.



ӨӨРИЙГӨӨ ШАЛГАХ НЬ

Доорх даалгаваруудыг өгөгдсөн дарааллын дагуу гүйцэтгэнэ үү.

1. Боломжит эх үүсвэрүүдээс өөрийн улсын МХЗ-уудын макро статистикийг цуглуул.
2. Боломжит эх үүсвэрээс өөрийн орны МХХТ-ийн нэвтрэлтийн талаарх статистик мэдээлэл цуглуул.
3. МХХТ-ийг хөгжлийн хурдцыг түргэсхэд ашигласан тохиолдолд ямар давуу тал, сул тал, боломж, аюул байгаа болохыг статистик мэдээллээ ашиглан тогтоо. МХХТ нь хөгжлийг түргэсгэхэд ашиглагдаж болох уу? Үндэсний хэмжээний бодлогын хүрээнд ямар зүйл хийж болох талаар дүн шинжилгээ хий.
4. Танай улс/бүс нутагт МХХТ-ийн дэмжлэгтэй хөгжлийн бодлогыг хэн/ ямар агентлаг эсвэл байгууллага хоорондын бүлэг боловсруулан гаргах ёстойг тогтоо.
5. Бодлогыг хэрэгжүүлж эхлэхийн тулд юу хийх шаардлагатай вэ? Хийх ажил болон шаардагдах хугацааг тогтоо.

3. ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ МХХТ-ИЙН ХЭРЭГЛЭЭ

Энэхүү бүлгийн зорилго нь:

- Олон салбар дахь ялангуяа МХЗ-уудтай шууд хамааралтай салбаруудын МХХТ-ийн хэрэглээг тогтоох; болон
- Хөгжлийн тэргүүлэх салбаруудад МХХТ-ийг ашигласан кейс судалгаануудаас шилдэг аргачлалын зарчмуудыг тодорхойлох юм.

МХХТ нь өөрийн онцлогийн хувьд олон салбарыг хамарсан байх ба үүний хэрэглээ нь салбар бүрт хамаардаг. Жишээ нь ядуурлыг бууруулахад МХХТ-ийг хэрэглэх нь иргэдэд орлого олох боломжуудыг ханган өгөх чиглэлтэй байхаас гадна эмэгтэйчүүдийг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оруулсанаар хөгжлийн хос салбарт нөлөөлж байдаг. Гэхдээ хэлэлцүүлэг өрнүүлэх үүднээс энэхүү бүлэгт МХХТ-ийн олон төрөл хэрэглээг хөгжлийн зорилтуудтай хамруулан авч үзэх юм. Тухайн зорилгуудыг нь хөгжлийн салбараар нь хуваасан болно.

МХХТ-ийг хэрэгжүүлэх хоёр хандлага байдаг болохыг дурдах шаардлагатай. Үүний нэг нь шууд хандлага бөгөөд үр дүнг хүртэгч нарт чиглэн МХХТ-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэгч нартай холбодог. Нөгөө хандлага нь шууд бус буюу дэмжих хандлага бөгөөд энэхүү хандлагын хүрээнд бодлого, дэд бүтэц, дэмжих систем, контент зэрэгт дэмжлэг үзүүлсэнээр эцсийн үр дүнг хүртэгчдэд үр дүнг авчиргах байдлаар хэрэгждэг. Дээрх хоёр хандлага нь хөгжлийн зорилгод хүрэхэд аль аль нь ихээхэн чухал ч хандлага бүр нь бодлого болон хэрэгжилтийн шатанд өөр өөр загвартай байдаг. Эдгээр хандлагуудын талаар бид энэхүү бүлэгт авч үзэх бөгөөд ингэхдээ МХЗ-уудын салбар нэг бүрт хамруулан авч үзэх юм.

3.1 МХХТ БОЛОН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ



ЗОРИЛГО 1: ХЭТ ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

Зорилт 1: Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой буюу өдөрт 1 ам доллараас бага орлого бүхий иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990-2015 онд 2 дахин бууруулах

Зорилт 2: Өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийн тоог 1990-2015 онд хоёр дахин бууруулах

МХХТ нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, улмаар ядуурлыг бууруулахад ихээхэн чухал үүргийг гүйцэтгэдэг. Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд нь МХХТ-ийн нэвтрэлт өндөртэй байдаг. Бизнес эрхлэгчид болон аж үйлдвэрийн салбар энэхүү мэдээллийн зуунаас маш их үр ашгийг хүртэж буй нь нотолгоотой. МХХТ-ийн дэд бүтэц, хүний нөөцийн хөгжил нь Энэтхэг, Хятад зэрэг хурдтай хөгжиж буй оронд ч нөлөөлөн, тэдгээр орныг мэдээлэлжсэн нийгмийн хүчирхэг эдийн засагтай улс болоход нь өөрийн хувь нэмрийг оруулж байна.

МХХТ-ийн үр нөлөө нь жижиг дунд үйлдвэрүүд дээр илүүтэй харагддаг. МХХТ-ийг ашиглан жижиг бизнес эрхлэгчид дотоодын харилцаа холбоо (байгууллагын доторх харилцаа холбоо) болон харилцагч нартай харилцах гадаад харилцаа холбоогоо сайжруулах замаар зардлаа бууруулах, шинэ зах зээл эрэлхийлэх, дэлхий нийтээр шинэ хэрэглэгчдийг бий болгох, эрэлт нэмэгдүүлэх, агуулахын болон бараа материалын удирдлагыг сайжруулах, үргүй хаягдлыг бууруулах зэргээр өөрсдийн ашгийг нэмэгдүүлж байна.

Ийм төрлийн эдийн засгийн өсөлтийг хангахад төрийн зүгээс дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай ч Засгийн газрын зүгээс МХХТ-ийг ашиглан бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ЖДҮ-үүдэд өгч болох хамгийн сайн урамшуулал нь тэдэнд тулгарч буй саад тотгорыг арилгах, үйл ажиллагаа явуулах орчныг сайжруулах (бүртгэлийг хөнгөвчлөх болон эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох), бизнесийн ур чадварын болон санхүүжилтийн сургалт явуулах болон ЖДҮ-үүдийг томоохон компаниудтай холбох, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг байж болно.

МХХТ-ийн дэмжлэг бүхий аж үйлдвэрийн салбар, хувийн хэвшил ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан жишээ олон байдаг. Гэхдээ ийм төрлийн хөгжлөөс ядуучууд нь ядуу бүс иргэдээс хавьгүй бага үр шимийг хүртдэг¹³. Тиймээс Засгийн газрууд нь эдийн засгийн өсөлтийг ханган ядуурлыг бууруулах үйл ажиллагааг явуулахдаа ядуу иргэдэд үр дүнг нь хүртээх үйл ажиллагааг явуулах шаардлагатай нь ойлгомжтой.

Ядуурлын нүүр царай олон янз байдаг. Үүний жишээнд орлогын ядуурал, газар эзэмших эрх хязгаартай байх, зээл болон үйлчилгээ дутмаг байх, байнгын өлсгөлөнд автах, суурь боловсрол олох боломж хаалттай байх, эрүүл мэндийн үйлчилгээ ялангуяа хүүхэд болон эхийн эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байх, ДОХ/ХДХВ, хумхаа болон сүрьеэ хурдтай тархах, нас баралт их байж, дундаж наслалт буурах, тогтвортой амьжиргаа хангалтгүй байх, залууст ажил олдохгүй байх, байгалийн гамшиг болон мөргөлдөөнд эмзэг болох зэрэг олон сөрөг нөлөөг үзүүлнэ. Эдгээр бүх сөрөг нөлөөг бууруулахын тулд МХХТ-ийн шууд болон шууд бус хандлагыг ашиглан ядууст зориулсан үйлчилгээг хүргэх, байгалийн нөөцийн зураглал гаргах зэрэг дэмжих үйлчилгээг хүргэх нь ядуурлыг бууруулах чухал стратегиуд юм.

Thread Net Хунза нь Пакистаны алслагдсан бүс нутаг дахь орон нутгийн худалдаачид, нэхмэлчдийг дэлхийн зах зээлтэй холбох, улмаар тэдний бүтээмж, орлого болон амьдралын чанарыг сайжруулах зорилго бүхий гадны санхүүжилт бүхий орон нутгийн санаачлага юм.

13. OECD, Good Practice Paper on ICTs for Economic Growth and Poverty Reduction (Paris: OECD, 2005), <http://www.oecd.org/dataoecd/2/46/35284979.pdf>.



Хунзагын Thread Net, Пакистан

KADO буюу Каракорам орон нутгийн хөгжлийн байгууллага нь Пакистаны Хунза тосгоны орон зайн хувьд алслагдсан, эдийн засгийн хувьд сул тал бүхий иргэдийн нийгэм эдийн засгийн байдал болон амьжиргааг сайжруулах зорилго бүхий ашгийн бус орон нутгийн хөгжлийн байгууллага юм. KADO нь эмэгтэйчүүд, гар урлалчид, жижиг үйлдвэрлэгчид болон бусад эмзэг бүлгийнхэнд хандсан доорх үйл ажиллагааг явуулдаг байна:

- Эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхний үйлдвэрлэж буй уламжлалт гар урлалын бүтээгдэхүүнийг дэмжих, идэвхжүүлэх;
- Орон нутгийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулахад МТ-ийг ашиглах;
- Уламжлалт баяр, соёл, урлагийг дэмжих;
- Тусгай хэрэгцээ бүхий хүмүүст нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх;
- Орон нутгийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх; болон
- Хунза орчмын байгаль орчны асуудлуудад хандсан үйл ажиллагааг явуулах.

KADO нь саяхан хоёр тосгонд хөдөөгийн эмэгтэйчүүдэд програм хангамжийн хэрэглээний сургалт явуулдаг төвд дэмжлэг үзүүлжээ. Эдгээр төвүүд нь орон нутгийн олон нийттэй хамтран зардлаа нөхөх зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байна. KADO нь мөн гар урлалын бүтээгдэхүүний цахим худалдааг Олон улсын хөгжлийн судалгааны төвийн Пан Азийн сүлжээтэй хамтран хэрэгжүүлж орон нутгийн эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийсэн бүтээгдэхүүнийг сурталчилсан байна. ОУХСТ-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хөгжлийн төлөөх МХХТ-ийн төслийн хүрээнд KADO нь мөн Интернетийн үйлчилгээг үзүүлж эхэлжээ. Энэхүү алслагдсан бүс нутагт МХХТ-ийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нэгтгэн хэрэгжүүлсэнээр тогтвортой амьжиргааг хангах, хэт ядуурлыг бууруулах болно хэмээн KADO итгэж байна.

Эх сурвалж: Adapted from Karakoram Area Development Organization, <http://www.kadohunza.org/index.html>; and Thread Net Hunza, <http://www.threadnethunza.com.pk/index.html>.



АСУУЛТ

Thread Net нь орон нутгийн асуудлыг шийдэх шинэ шийдлийг гарган иржээ. Гэхдээ энэхүү үйл ажиллагаа нь тогтвортой байдал болон түгээн дэлгэрэх байдал зэрэг олон асуудалтай тулгарсан байна. Энэхүү төслийг хуулбарлан хэрэгжүүлж, тогтвортой хэрэгжүүлэх боломжтой гэж та үзэж байна уу?


Ядуурлын олон талт байдалд хандсан үйл ажиллагаа явуулахтай адил ач холбогдолтой өөр нэгэн асуудал нь ядуурлын асуудлаар үйл ажиллагаа явуулж буй томоохон олон нийтийн хөтөлбөрийг дэмжих МХХТ-ийн үр дүнтэй систем бий болгох явдал байдаг. Үүний нэг жишээ болон Малайзын SINAR систем буюу хот суурин газрын ядууст зориулсан мэдээллийн сан нь Засгийн газрууд болон донор байгууллагуудад үр дүнтэй систем болохоо батлан харуулсан билээ. Энэтхэгийн Андхра Парадеш мужийн Засгийн газар МХХТ-ийг ашигласан өөр нэгэн жишээ нь хөдөө орон нутгийн ядуу иргэдийг хамгийн багадаа жилийн 100 хоногт ажилтай байлгахын тулд Энэтхэгийн үндэсний орон нутгийн ажил эрхлэлтийн хуулийг гаргах үйл ажиллагаа явуулжээ.



МХХТ болон Энэтхэгийн үндэсний орон нутгийн ажил эрхлэлтийн баталгааны схем (NREGA)

Энэтхэгийн Андхра Прадеш мужид МХХТ-ийг 2005 онд батлагдсан Энэтхэгийн үндэсний орон нутгийн ажил эрхлэлтийн баталгааны схем (NREGA) буюу орон нутгийн ядуу иргэдэд жилд 100 өдрийн цалинтай ажил олгохыг хуувчлан заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэглэж байна.

NREGA нь хөдөө орон нутгийн ядуу иргэдэд дэд бүтцийн төслүүд дээр ажил эрхлэх боломжийг баталгаажуулдаг. Тус хөтөлбөр нь 13-тойргийн нийт 13,000 тосгоныг хамардаг байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой асуудлууд тулгардаг бөгөөд үүний тоонд инженерүүд нийт ажлын багцааг гаргах үйл явц саатах, ажлын цар хүрээг хэтрүүлэн тооцох, тооцоо хийхэд ил тод



байдал хангалтгүй байх, тооцоог олон нийтэд хүртээмжтэй болгохгүй байх, тооцоог орон нутгийн хэл дээр хийхгүй байх зэрэг асуудлууд тулгардаг байна. Дээр дурдсан болон бусад асуудлуудыг шийдэхийн тулд Андхра Прадеш мужийн захиргаа нийт 659 тосгонд дундын компьютер суурилуулж, тусгайлан зохиосон програм хангамжийг ашиглан ажлын картууд, тооцооны тайлан, ажил эхлэх тушаал, хэмжих хуудас, төлбөрийн даалгавар, цалингийн цэс зэргийг байрлуулжээ. Хөтөлбөрт зориулан бий болгосон веб порталаас хэн ч хөтөлбөрийн талаар бүрэн мэдээлэл авч болдог байна.

Үүнээс гараад байгаа үр дүн нь гэвэл 4 сая гаруй ядуу иргэдэд ажил эрэхэд нь зориулсан ажлын карт өгч, 500,000 гаруй ядуус ажил эрхлэх боломжийг хангасан байна. Эдгээр ажилтай болсон хүмүүст хадгаламжийн данс нээн өгсөнөөр тэдний төлбөрийг дансанд нь шууд шилжүүлэн авлигийг зогсоосон байна.

Хэдийгээр ихээхэн эсэргүүцэлтэй тулгаран байж хийсэн ч энэхүү систем нь зөвхөн бодлого боловсруулагчдад ч бус мөн төслийн ажилтнуудад ихээхэн үнэ цэнэтэй мэдээллийг өгч буйн зэрэгцээ ядуу иргэд Энэтхэгийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн эерэг үр нөлөөг мэдрэх болжээ. Багахан туслалцаа шаардагдах хэдий ч ямар ч ядуу хүн хөтөлбөртэй холбоотой мэдээллийг авч, өөрсдийн санал бодлыг илгээх боломж нь төрийн зүгээс нийгмийн хариуцлагаа ухамсарлах явцыг мөн сайжруулж байна.

Энэхүү санаачилгын үр дүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөний тоонд зохистой хууль тогтоомж бүхий бодлогын орчин нь мужийн захиргаанд ядуурлын эсрэг үйл ажиллагаа явуулах бололцоог хангаж өгсөн, мужийн захиргаа болон МТ-ийн салбарын түншлэл бий болсон, хөтөлбөрийн удирдлага болон хяналт-үнэлгээний сайн тогтолцоо бүрдсэнтэй холбон тайлбарлаж болно.

Эх сурвалж: Adapted from National Rural Employment Guarantee Scheme - Andhra Pradesh, Department of Rural Development, Government of Andhra Pradesh, http://nrega.ap.gov.in/Nregs/Home_eng.jsp.



АСУУЛТ

NREGA төсөлд ямар саад, хязгаарлалтууд тулгарсан гэж та бодож байна вэ? Эдгээрийг хэрхэн шийдэж болно хэмээн та үзэж байна вэ?

Ази тивийн хэмжээнд¹⁴ МХХТ-ийг ашиглан хөдөө орон нутгийн иргэдийг дэлхийн зах зээлтэй холбосон, ядуурлыг бууруулах хөтөлбөрт зайлшгүй шаардлагатай мэдээллийг (програм хангамж ашиглан ядуурлын зураглал хийх гэх мэт) бий болгосон олон жишээ байдаг. Эдгээр үйл ажиллагаан дээр МХХТ-ийг үр дүнтэй ашиглах нь жижиг фермерүүдэд орлогоо нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулах, хөдөө аж ахуйн ноу хауг олох, зах зээлээ хөгжүүлэхэд тусалдаг болохыг бүрэн нотолсон байна. Жишээ нь Вьетнамын Бат Транг, Хой Ан тосгонууд өөрсдийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний вебсайтыг хийжээ¹⁵. Энэтхэг улсад e-Choupal портал¹⁶ болон Тосгоны мэдлэгийн төвүүд¹⁷ тосгоны ядуу иргэдийг гадны зах зээлтэй амжилттай холбосон байна. Дээрх хоёр санаачилга нь ядуу иргэдийн хэрэгцээнд тусгайлан анхаарал хандуулсан санаачилгууд юм.

14. See UNDP, "ICT and Poverty and Hunger: Asian Experiences," World Summit on the Information Society, 11 December 2003 in Geneva, Switzerland, <http://www.apdip.net/projects/rhdr/news/08012004/poverty.pdf>.

15. See UNDP, Regional Human Development Report – Promoting ICT for Human Development in Asia: Realising the Millennium Development Goals (New Delhi: UNDP, Elsevier, 2005), 112, <http://www.apdip.net/eLibrary/#rhdr>.

16. See e-Choupal, http://www.itcportal.com/sets/echoupal_frameset.html.

17. See MS Swaminathan Research Foundation, <http://www.mssrf.org>



е-Choupal, Энэтхэг

е-Choupal буюу цахим-Чоупал хөтөлбөрийг үндэстэн дамнасан компани болох АйТиСи (ITC) компани анхлан эхлүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд Энэтхэгийн хөдөө аж ахуйд түгээмэл буй олон салсан жижиг фермүүд, сул хөгжсөн дэд бүтэц, олон тооны дундын зуучлагч зэрэг асуудлуудыг шийдэх зорилготой байжээ. Төсөл нь фермерүүдийн ажиллуулдаг тосгоны Интернетийн төвийг (санчалак хэмээн нэрлэдэг) байгуулан, үүнийг ашиглан орон нутгийн хэл дээр цаг агаар, зах зээлийн үнэ ханш, фермерийн үйл ажиллагааны мэдээлэл, зөвлөгөө, эрсдлийн удирдлага зэргийг ханган өгөх болжээ. Төвүүд нь орон нутгийн фермерүүдэд орц худалан авах, өөрийн бүтээгдэхүүнээ ферм дээрээс худалдах боломжийг олгосноор тэдний зардлыг ихээр бууруулсан байна. Хэд хэдэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд онцгой түншлэлийг зах зээлийн тэргүүлэгч нартай (ITC компаниас бусад) бий болгосноор дэлхийн хэмжээний чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болжээ.

Фермерүүд нь сайжруулсан бүтээгдэхүүн, өндөр үнэ зэргээс илүү ашиг олох болсон бол ITC компани нь ямар нэгэн өртөг нэмэхгүй нийлүүлэлтийн өртгийн сүлжээг багасган зардал бууруулах замаар (гэхдээ фермерүүдэд илүү боломжит үнэ санал болгож буй) худалдан авалтын хямд зардлаас үр ашгийг нь хүртэж байна.

2000 онд анхлан үүссэн е-Choupal нь одоо Энэтхэгийн хөдөө нутгийн Интернетэд суурилсан бүх үйл ажиллагааны дундаас хамгийн том нь болжээ. е-Choupal нь өнөөдөр үйлчилгээгээ олон төрлийн тариалан эрхлэдэг (шар буурцаг, кофе, улаан буудай, будаа, овьёос) 38 500 тосгоны 3.5 сая илүү фермерүүдэд нийт 9 мужид (Мадхиа Прадеш, Хариана, Уттараканд, Карнатака, Андрха Прадеш, Уттар Прадеш, Махараштра, Ражастан, Керала) байрлах 6,500 төвөөр дамжуулан хүргэж байна.

Эдгээр е-Choupals төвүүдийг байгуулах, удирдан ажиллуулахад тулгарч байсан асуудлуудын тоонд эрчим хүчний хангамж, цахилгаан холбооны холболт зэрэг дэд бүтцийн хомсдол голдуу байжээ. Түүнчлэн Энэтхэгийн алслагдсан, хөдөө нутаг дахь анх удаагаа Интернет ашиглаж буй фермерүүдийн үр чадварыг дээшлүүлэх нь мөн тулгарсан сорилтуудын нэг байжээ.

Эх сурвалж: Adapted from OneChoupal, "About e-Choupal," ITC Limited, <http://www.echoupal.com>; and "e-Choupal: Empowering Indian farmers," ITC Limited, <http://www.itcportal.com/rural-development/echoupal.htm>.



АСУУЛТ

Е-Choupal хөтөлбөрийн амжилтын ямар гол элементүүд байна гэж та үзэж байна вэ? Үүнтэй ижил төрлийн төсөл танай оронд амжилттай хэрэгжих боломжтой юу? Яагаад?

Фермерүүдэд шууд туслалцаа дэмжлэг үзүүлэхийн адил ач холбогдолтой өөр бусад үйл ажиллагаа нь хөдөө аж ахуйн системийг бий болгох, судалгаа болон нэвтрүүлэх төвийн чадавхийг бэхжүүлэх, МХЗ-уудыг биелүүлэхээр ажиллаж буй төрийн болон хөдөө аж ахуйн салбарын мэдлэг үр чадварыг нэмэгдүүлэх зэрэг мөн багтана. Ази, Номхон далайн бүсийн хөдөөгийн хөгжлийн төлөөх мэдлэгийн сүлжээ (ENRAP) нь ийм төрлийн нэг цэгийн портал бөгөөд хөдөө аж ахуйн институцууд нь хөдөө аж ахуйн судалгаа, нэвтрүүлэх төвийн хүрээнд хувь хүний болон байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилготой ажилладаг.



Ази, Номхон далайн бүсийн хөдөөгийн хөгжлийн мэдлэгийн сүлжээ (ENRAP)

ENRAP нь Олон улсын хөдөө аж ахуйг хөгжүүлэх сан болон Олон улсын хөгжлийн судалгааны төвийн хамтран хэрэгжүүлж буй дэлхий нийтийн мэдээллийн эх үүсвэрийг Ази, Номхон далайн бүсд хэрэгжүүлж буй төслүүдэд түгээх зорилго бүхий хөтөлбөр юм. 2010 онд хэрэгжилтийнхээ гурав дахь шатанд буй ENRAP төсөл нь хамаарах төслүүдийн зорилгууд, үр дүн, хэрэгжилтийн талаарх мэдээллийн хуваалцах, хүртээмжтэй болгох үр чадварыг хөгжүүлэх чиглэлийн үйл ажиллагааг явуулдаг. Мэдлэг солилцох системийн боломжит хэрэглэгчдийн тоонд төслийн ажилтнууд, хөдөө орон нутгийн иргэдтэй шууд ажиллаж буй бусад талууд багтах ба үндсэндээ тэд орон нутгийн түвшинд мэдээлэл бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрхлэдэг. Төсөл нь мэдлэг солилцох, суралцах соёлыг төслийн бүх оролцогч талуудын дунд бий болгох арга замыг эрэлхийлдэг.

ENRAP нь хөдөө орон нутгийн харилцаа холбоо, мэдлэгийн сүлжээг дэмжих стратеги, арга зүй, технологийг судлан, цаашдын үйл ажиллагаанд зориулсан санал зөвлөмжүүдийг боловсруулан гаргадаг. Энэ хөтөлбөр нь мэдлэгийн сүлжээ, Интернетийн хэрэглээг орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр мөн судалгааны ажил гүйцэтгэдэг. Орон нутгийн түвшинд оролцоог хангах арга зүй, практик шийдлүүдэд онцгойлон төвлөрдөг байна. Орон нутгийн цахим сонин, хөдөө аж ахуйн зах зээлийн мэдээлэл, нийтийн цахим номын сан зэрэг нь энэхүү хөтөлбөрийн үйл ажиллагааны жишээнд багтана.

ENRAP нь Ази, Номхон далайн бүсийн сонгогдсон бүлэг төслүүдийг хамран ажилладаг. ENRAP-аас шууд туслалцаа дэмжлэг хүртэхгүй буй бусад орнууд нь үнэгүй сургалтын материал, баримт бичгүүд, мэдээллийн санг ENRAP-ын вебсайтаас (<http://www.enrap.org>) авч болох ба мөн тэдэнд мөн вебээр дамжуулан техникийн туслалцаа үзүүлэх, ажлын орон зай гарган боломжтой. Цаашид Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд хэрэгжиж буй Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн бүх төсөл ENRAP-ын үйл ажиллагаанд хамрагдан, мэдлэг солилцох системийн нэг хэсэг болох юм.

Эх сурвалж: Adapted from IDRC, IFAD, "Knowledge Networking for Rural Development in Asia/Pacific Region," <http://www.enrap.org/index.php?module=htmlpages&func=display&pid=5>.



АСУУЛТ

Дэлхийн болон олон улсын бусад ямар байгууллагууд ХАА-н үндэсний системийг хөгжүүлэхэд туслах үйл ажиллагаа явуулдаг вэ? Танай орны ашиг сонирхолд нийцсэн байдлаар энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын талаар мэдэх үү?

ДҮГНЭЛТ

- МХХТ-ийн салбарт хийх хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бүтээмжийн хооронд шууд хамаарал байгаа талаар олон тооны нотолгоо байдаг.
- ЖДҮ-үүд МХХТ-ийг ашиглах нь харилцаа холбооны болон бусад зардлыг бууруулах, хөрөнгийн удирдлагыг сайжруулах, дэлхийн зах зээлтэй холбогдох замаар бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулан ашиг орлогоо нэмэгдүүлдэг болохыг харуулж байна.
- Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулах баталгаа биш ч гэсэн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг олон жил тогтвортой явуулахад ихээхэн чухал байдаг.
- Ядуурлыг бууруулахад чиглэсэн МХХТ-ийн чиглэлийн шууд үйл ажиллагаа нь ядуу иргэдийг зах зээл болон мэдээлэлтэй холбож өгдөг.
- Ийм төрлийн үйл ажиллагаа нь Засгийн газрын хөтөлбөр, ТББ-ын үйл ажиллагаа, хувийн хэвшлийн компанийн нийгмийн хариуцлагын төсөл хэлбэрээр байж болно.



ДАСГАЛ

Танай оронд хэрэгжиж буй хөгжлийн зарим төслүүдийг ялангуяа (1) ЖДҮ, (2) ядуу иргэдэд (жишээ нь хот суурин газрын ядуус) хандан үйл ажиллагаа явуулж буй төслүүдийн талаар судал. Эдгээр төслүүд дэхь МХХТ-ийн үүрэг ролийг тодорхойл.

3.2 БОЛОВСРОЛ ДАХЬ МХХТ



ЗОРИЛГО 2: БҮХ НИЙТЭЭР БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

Зорилт 3: 2015 он гэхэд бүх охид, хөвгүүдэд бага боловсрол олгох

Боловсрол олох эрх нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд боловсрол нь ядуурал болон нийгэм дэхь бусад тэгш бус байдлыг бууруулахад чухал үүрэгтэй учраас ч бус өөр олон шалтгааны улмаас боловсролыг чухалчлан үздэг. Гэхдээ нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь дэлхийн хүүхдийн дийлэнх хувь нь энэхүү эрхээ эдлэх боломжийг олгохгүй байна. Хөгжиж буй орнуудын хувьд гол сорилт нь хязгаарлагдмал эх үүсвэрээ ашиглан бүх хүнд хэрхэн чанартай боловсрол олгох асуудал бөгөөд учир нь анги танхим, сурах бичиг, багш нар хүрэлцээгүйгээс болоод боловсролын салбар нь ихээхэн асуудалтай байдаг.

МХХТ нь энэхүү сорилтуудыг даван туулахад ихээхэн чухал үүргийг гүйцэтгэнэ. Ялангуяа МХХТ нь сургууль, боловсролын байгууламжуудын хүртээмжийг бий болгож, багшлах болон суралцах чанарыг сайжруулж, захиргааны болон хичээлийн үйл ажиллагааг илүүтэй сайжруулах боломжтой (Хүснэгт 6-г үзнэ үү).

Хүснэгт 6. МХХТ-ийг боловсролын салбарт ашиглахын боломж, үр шим

Боломжууд	Үр дүнгүүд
Өндөр чанарын сургалтын материалын хүртээмж, байрлалаас үл хамааран сайжрах	Сургалтын материалыг хаана ч боловсруулж, хаанаас ч авч болно
Суралцагчид хоорондоо холбогдох	Хамтарсан сургалт явуулах
Интерактив сургалт бий болох	Харилцан сүлжээт МХХТ нь суралцагчдын хооронд болон багш суралцагчдын хоорондын интерактив байдлыг үүсгэнэ
Орон зайн хязгаарлалтыг арилгах	Зай болон тусгаар байдал нь суралцах үйл ажиллагааны чанар болон зардлыг тогтоох хүчин зүйл биш болно
Сургалтын удирдлага сайжрах	Элсэлт, үнэлгээ болон гэрчилгээжүүлэлтийг бага зардлаар зохион байгуулж, удирдлагын зардлыг бууруулна

Ядуурал, хөгжлийн бэрхшээл, газар зүйн байрлал, хүйс, мөргөлдөөн, ажил эрхлэлт, соёлын хязгаарлалт зэргээс хамааран сургуульд суралцах боломжгүй хэн бүхэнд МХХТ нь боловсрол олгох боломжтой. Жишээ нь Хятад болон Мексик улсуудад радио, телевизийг ашиглан алслагдсан газруудад буй хүүхэд, залуучуудад хичээл зааж байна. Эрэгтэйчүүд давамгайлсан нийгэмд технологи ашигласнаар эмэгтэйчүүд, охидод боловсрол олгох зардал багатай аргачлал болж байна. Бангладеш, Энэтхэг, Пакистан, Шри-Ланк улсуудад нээлттэй сургуулиуд дээр МХХТ-ийн олон боломжуудыг туршиж буйн тоон уламжлалт хэвлэмэл материал, аудио-визуал материал, цахим суралцах зэрэг байдлаар үйлчилгээ бүрэн хүрэхгүй буй салбарт бага болон дунд боловсролын хүртээмжийг бий болгож буй туршлага байгаа юм.



Нээлттэй сургуулийн үндэсний хүрээлэн, Энэтхэг

Энэтхэгийн Нээлттэй сургуулийн үндэсний хүрээлэн (НСҮХ) нь 1,5 сая гаруй залууст суурь боловсрол олгох, холбох сургалтууд явуулах болон дунд боловсролын үйлчилгээгээр хангах зэрэг үйл ажиллагааг явуулдаг. Анхдугаар үеийн суралцагчид (гэр бүлийнхээ хэмжээнд анх удаа сурч буй хүн гэх мэт), хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн эмзэг бүлгийнхний онцлог хэрэгцээн дээр тусгайлан төвлөрдөг ажээ.

Хичээл нь хэвлэмэл, аудио-визуал болон онлайн хэлбэрээр хийгддэг. НСҮХ нь Энэтхэг болон гадаад орнууд дахь байгууллагууд, бүсийн төвүүд, магадлан итгэмжлэгдсэн хүрээлэнгүүдтэй сүлжээнд нэгдэн ажилладаг ажээ. Улсын хэмжээний нээлттэй сургуулиудыг хянан шалгах, боловсрол олгох энэхүү систем нь дэлхийн хэмжээний хамгийн том систем билээ. Энэхүү систем нь Энэтхэг улсад “бүх нийтэд боловсрол олгох” зорилгодоо хүрэхэд нь туслалцаа үзүүлж байгаа юм.

Эх сурвалж: Adapted from National Institute of Open Schooling, <http://www.nios.ac.in>.



ДАСГАЛ

Вебсайтыг ашиглан танай оронд болон бусад газарт хэрэгжиж буй нээлттэй сургуулийн жишээг хайж судал. Тэдгээр санаачилгуудад ямар ижил төстэй зүйл байна вэ? Тэдэнд мөн ямар ялгаа байна вэ? Тэдгээр нь боловсролын чанарын асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ?

SchoolNets нь сургуулиудад боловсролын чанарыг сайжруулахад тусгайлан анхаарсан МХХТ-ийн дэмжлэг бүхий хандлагын нэг төлөөлөл билээ. SchoolNets нь МХХТ-ийг ашиглан хамтран ажиллаж багшлах болон суралцах үйл явцыг сайжруулдаг бүлэг сургуулийн сүлжээ юм. SchoolNets нь мөн Африк тивд ч үүсээд буй бөгөөд тус тивд сургууль хоорондын хамтын ажиллагаа нь үр дүнтэй, шаардлагатай байгаа бол Зүүн Өмнөд Азид энэхүү системийг олон улсын байгууллагууд идэвхтэй дэмжин ажиллаж байна. Номхон далайн бүсэд SchoolNets мөн үүсэн байгуулагдаад байна.



Номхон далайн өмнөд хэсгийн SchoolNet болон олон нийтийн мэдээллийн загвар

Самоагийн SchoolNet болон Олон нийтийн хүртээмжийн төсөл нь тус улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй хөтөлбөр бөгөөд АХБ-ны санхүүжилтээр хэрэгжин МХХТ-ийг сургуулиуд болон олон нийтийн дунд нэвтрүүлэхээр туршилтын байдлаар хэрэгжиж байна.

Энэ төсөл нь сургуулиуд дээр Сургалтын төв байгуулж буй бөгөөд тус төв нь компьютер, хувилан олшруулагч, камер, DVD, хэвлэгч, Интернет, факс, проектор зэрэг тоног төхөөрөмжүүдтэй ажээ. Багш, сурагч нар энэхүү төвийг хичээлийн цагаар ашигладаг болон хичээлийн дараа тус төвийн орон нутгийн бизнес эрхлэгчид, олон нийт ашигладаг байна. Энэхүү систем нь тус төвийн санхүүжилтыг хангадаг нэг хэлбэр ажээ. Сургуулийн ажилтнууд болон олон нийтийн хамтын ажиллагаа ч төслийн үеэр ихээхэн бэхжсэн байна.

Вайтеле Ута бага сургууль нь Самоа улс болон Номхон далайн өмнөд хэсэг дэхь SchoolNet-ин сүлжээнд холбогдсон анхны сургууль болсон байна. Дараагаар нь Ваймауга коллеж, Лета/Лотофага коллежууд энэхүү сүлжээнд нэгдсэн байна. Улмаар үүн дээр нэмэгдэн Амао коллеж, Матааевэйв коллежууд мөн нэгдэн оржээ.

Интернетийн холболтын хэлбэр нь гибрид загвар буюу вайрлесс өргөн зурвасын сүлжээний зэрэгцээ дата төвтэй диал-ап холболтоор мөн холбогдож байна. Самоа улсын Засгийн газраас МХХТ-ийн хуулийг цаг тухайд нь батлан гаргаснаар харилцаа холбооны салбарыг зохицуулах, МХХТ-ийг сайжруулахын тулд шинээр 3G системийн үйлчилгээ эрхлэн тусгай зөвшөөрөл олгох зэрэг боломжууд нээгдсэн байна. Утасгүй вайрлесс холболт өргөжиж буй нь ихээхэн чухал ач холбогдолтой бөгөөд учир нь энэ нь суурилуулахад харьцангуй бага зардалтай, хялбар өргөтгөх боломжтойн зэрэгцээ Самоа улсын газар зүйн байрлалд ихээхэн нийцсэн сонголт юм.

Эх сурвалж: Adapted from Asian Development Bank, "Samoa SchoolNet," <http://www.adb.org/Projects/project.asp?id=36513>.



АСУУЛТ

Сургуулиудыг хооронд нь холбох, сургуулиудыг олон нийттэй холбохыг давуу тал, үр дүнгүүд нь юу гэж та бодож байна вэ? Энэхүү стратеги нь танай улсын боловсролын хүртээмж, чанарыг сайжруулахад яаж туслах вэ?

МХХТ-ийн хэрэглээ нь компьютерийн анхан шатны мэдлэг шаарддаг тул боловсролын салбарын хүрээнд анхан шатандаа МХХТ нь дээд боловсролын аргачлал байдлаар нэвтэрсэн билээ. Зайн сургалт нь юуны өмнө дээд боловсролын хүртээмжийг хүн ам ихтэй улсуудад нэмэгдүүлж байв. Өнөөдөр зайн сургалтын хөтөлбөрийг онлайн байдлаар түгээх болсон ба үүнийн цахим сургалт (e-learning) хэмээн нэрлэх болжээ. Гэхдээ тоон хуваагдлаас үүдэн эдгээр хөтөлбөрүүд нь санхүү, дэд бүтэц, мэдлэг бүхий хүмүүст хүрэхэд ч хүндрэлтэй байгаа билээ. Ийм төрлийн асуудалд анхаарлаа хандуулах зорилгоор хамтын нөхөрлөлийн жижиг орнууд ялангуяа Номхон далайн орны орнууд виртуал их сургууль байгуулахын тулд далайд гарцгүй орнуудтай хамтран эвсэл байгуулжээ. Үүний гол зорилго нь чухалчлах хэрэгцээг хангах болон технологийн сонголтыг хамгийн шилдэгээр ашиглах зорилготой байв. Үүний үр дүнд Хамтын нөхөрлөлийн жижиг орнуудын виртуал их сургууль (ХНЖОВИС) байгуулагджээ.



Хамтын нөхөрлөлийн жижиг орнуудын виртуал их сургууль (ХНЖОВИС)

Виртуал их сургууль нь анх 2005 онд Хамтын нөхөрлөлийн боловсролын сайдын санал болгосны дагуу байгуулагджээ. Энэхүү санаачилгад хамаарах 30 орон нь Канадын Ванкувер хотод байрлах Суралцах хамтын нөхөрлөлтэй хамтран тухайн санаачилгын үйл ажиллагааг зохицуулж байна.

Виртуал их сургууль нь дунд шатны ахьсан түвшний болон ур чадварын сургалтыг аялал жуулчлал, бизнесийн удирдлага, гамшгийн удирдлага болон өөр бусад олон төрлийн техникийн болон мэргэжлийн сэдвүүдээр зааж буй юм. Цахим хэлбэртэй, үнэ төлбөргүй курсын материалууд нь тухайн улсын нөхцөлд байдалд нийцсэн, уян хатан бөгөөд хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд кредит олгох боломжтой ажээ. Ингэснээр боловсролын чадавхи болон иргэдэд хүрэх хүртээмж сайжирсан ажээ.

Тус санаачилгын нэгэн томоохон төсөл нь бэлэн байгаа контентийг нэгтгэн Нээлттэй боловсролын эх үүсвэрийг бий болгон Интернетэд байрлуулах үйл ажиллагаа юм.

Виртуал их сургууль хэр амжилтад хүрсэнийг хараахан судлан тодорхойлоогүй байна. Гэхдээ тус санаачилга нь анхан шатандаа байгаа хэдий ч хэдийн тоон хуваагдлыг арилгах гүүр болж, жижиг орнууд ч дэлхийн хэмжээний хөгжлийн асуудалд өөрсдийн хувь нэмрийг оруулан, шинэлэг МХХТ-ийн хэрэглээг ашиглан боловсролын салбарын шинэтгэлийн тэргүүлэгчид байж чадна гэдгийг батлан харуулаад буй юм.

Эх сурвалж: Adapted from Commonwealth of Learning, "A Virtual University for Small States of the Commonwealth (VUSSC)," <http://www.col.org/colweb/site/cache/offonce/pid/100>; and Commonwealth of Learning, "COL in the Caribbean," <http://www.col.org/colweb/site/cache/offonce/pid/3512>.



АСУУЛТ

Виртуал их сургууль нь хамтрагч талуудын өргөн хүрээний хамтын ажиллагааг шаардсан урт хугацааны санаачилга юм. Ийм төрлийн хамтын ажиллагаа нь амжилт олох боломж өндөр ч мөн төрөл бүрийн эрсдэлтэй тулгаран амжилтгүй болох боломжтой. Таны бодлоор амжилтын гол хүчин зүйлс юу вэ? Хэрэв зөв удирдахгүй бол бүтэлгүйтэлд хүргэж болох ямар эрсдлүүд байна вэ?

МХХТ-ийг хөшүүрэг болгон ашиглах боловсролын бас нэгэн салбар албан бус боловсрол билээ. Өнөөдөр АББ нь байнгын тасралтгүй сургалтын үзэл баримтлалын салшгүй нэгэн хэсэг болсон бөгөөд үүгээр дамжуулан залуус, насанд хүрэгсэд байнга өөрчлөгдөж буй орчинд дасан зохицоход нь шаардлагатай мэдлэг, боловсролыг олж авдаг. Хөгжиж буй орнуудад бичиг үсгийн анхан шатны хөтөлбөр нь АББ-ын гол бүрэлдэхүүн хэсэг болдог ба ихэнх улсууд нь энэ хөтөлбөрийг нүүр тулсан танхимын сургалтаар олгодог. Гэхдээ энэхүү хандлагад өөрчлөлт гарч буй нотолгоо бас байна¹⁸.



Хамтын People First (Нэгдүгээрт хүмүүс) сүлжээ, Соломоны арлууд

Нэгдүгээрт хүмүүс буюу Pfnет сүлжээ нь Соломоны арлуудад хэрэгжиж буй төсөл бөгөөд МХХТ-ийг алслагдсан нутгийн хүмүүст АББ-ын сургалтуудыг хүргэхэд ашиглаж буй юм. Pfnет нь одоо үйл ажиллагаа явуулж буй сүлжээ юм. Энэхүү төслийн хүрээнд Pfnет суурин станцыг Сасамунга, Чойсеул тосгонуудад байгуулсан ба сургуулиудад нарын энергиэр ажилладаг компьютерийн төвүүдийг мөн байгуулжээ. Тус төвүүдэд нутгийн иргэдэд зориулан дээд сургуульд элсэгчдэд зориулсан Англи хэл болон ерөнхий Англи хэлний сургалтуудыг явуулдаг байна.

Төсөлд хамрагдсан хүмүүс энэхүү төслийг амжилттай болсон хэмээн үзэж байна. Сасамунга хотын бага болон дунд сургуулиуд Интернеттэй болсоны зэрэгцээ хамгийн чухал нь байгууллагын болон хандлагын өөрчлөлт тосгоны хүмүүсийн дунд ажиглагдаж, МХХТ-ийг ашиглахын ач тусыг ойлгох болжээ.

Эх сурвалж: Adapted from Rural Development Volunteers Association, "Pipol Fastaem," UNDP and UNOPS, <http://www.peoplefirst.net.sb>.

Хөгжиж буй орнуудад МХХТ-ийг боловсролын салбарт ашиглах гол хэрэглээ нь багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулахад мөн төвлөрдөг. МХХТ нь бүх нийтэд боловсрол олгоход тулгарч буй сорилтуудыг даван туулахын тулд ашигладаг сургалтын чухал аргачлал билээ. Багш нар нь хичээлийн үеэр МХХТ-ийг үр дүнтэй ашиглах гол хүмүүс тул тэд өөрсдийн техникийн болон сурган хүмүүжүүлэх ур чадварыг МХХТ-той хослуулан эзэмших зайлшгүй шаардлагатай. Энэ нь шинэ мэдлэгт суурилсан эдийн засагт ихээхэн чухал бөгөөд учир энэхүү эдийн засгийн шинэ үед мэдлэг нь биечилсэн мэдлэгээс илүү "21 дүгээр зууны ур чадвар" болох тунгаан бодох, мэдээлэл авах, асуудал шийдвэрлэх, хамтран суралцах, шинэ мэдлэг олох боломж, олсон мэдлэгээ нөхцөл байдалд тохируулан ашиглах зэрэг зүйлс ихээхэн чухал болоод байна¹⁹.

Сингапур улсад МХХТ-ийг боловсролын салбарт амжилттай ашигласан тохиолдол нь сургуулиудад компьютер суурилуулахаас өмнө багш нарыг МХХТ-ийн орчинд ажиллахад

18. See, for example, Tata Group, "Tata Computer-based Functional Literacy Programme" (Tata Sons Ltd.), <http://www.tataliteracy.com>; and Glen Farrell, *ICT and Literacy: Who benefits? Experience from Zambia and India* (Vancouver: Commonwealth of Learning, 2004), <http://www.col.org/colweb/site/pid/3104>.
19. Wadi D. Haddad and Alexandra Draxler, eds., *Technologies for Education: Potentials, Parameters, and Prospects* (Paris: UNESCO and Washington, D.C.: AED, 2002), 7, <http://unesdoc.unesco.org/images/0011/001191/119129e.pdf>.

нь амжилттай сургасанд оршино. Бутан улс Сингапурын олон улсын сантай хамтын ажиллагааг хөгжүүлэн багш нарт МХХТ-ийн цуврал сургалтуудыг явуулжээ. Энэхүү үйл ажиллагаа нь сургуулиудад техник тоног төхөөрөмж суурилуулахтай зэрэгцэн явагдсан байна. Багш нарын сургалтын анхны үе шат дууссаны дараа хоёрдугаар шатанд МХХТ-ийг хичээлийн програмд нэгтгэн оруулах үйл ажиллагаа явагдсан ба энэ нь бакалаврын зэргийн сургалтад нэн түрүүн хийгдсэн байна²⁰. Непал болон Бангладеш улсад багш нарт мөн компьютерээс эхлээд камер ашиглах зэрэг олон сэдвээр технологийн сургалт явуулжээ²¹. Үүнтэй төсөөтэй санаачилгууд ч Монгол²² болон Самоа²³ зэрэг улсуудад хэрэгжиж байна. Хэдийгээр эдгээр улсууд хоорондоо ялгаа ихтэй ч хоёр оронд багш нарыг МХХТ-ийн сургалтад хамруулан, хичээлийн програмд нэгтгэн оруулах нь боловсролын салбарын шинэтгэлийн томоохон хэсэг гэдгийг сайтар ойлгож буй юм.

МХХТ-ийн боловсролын салбарт үзүүлэх нөлөөлөл нь ач холбогдлоороо бизнесийн салбарт үзүүлж буй нөлөөллийн дараа эрэмбэлэгдэж буй билээ. Олон улсын хэмжээнд хийсэн өргөн хүрээний судалгаа ч гэсэн боловсролын салбарт МХХТ ашиглах нь өргөжиж буйг тэмдэглэсэн байдаг. Өмнө нь эргэлзэнгүй ханддаг байсан боловсролын салбарын бодлого боловсруулагчид, төлөвлөгчид ч одоо МХХТ нь суралцах боломж, хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлдэг, ямар зардалтай болох, боловсролын чанарт ямар нөлөө үзүүлэхийг ихээхэн сонирхон судлах болжээ.

Гэхдээ МХХТ нь боловсролын салбарт тулгарч буй асуудлуудыг шийдэх цорын ганц эмчилгээ биш гэдгийг ойлгох нь чухал. Түүнчлэн МХХТ-ийн боломжит үр дүнг бүхэл системийн хэмжээнд МХХТ-ийг нэвтрүүлж, боловсролын бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлсэнээр хүртэж болно. Суралцах үр дүн болон боловсролын системд гарах ахиц нь боловсролын системийн бүх элемент болох бодлого, үйл ажиллагаа, багш, суралцагчид, бусад оролцогч талууд нэгдэн нийлсэн тохиолдолд нь гарах юм.

ДҮГНЭЛТ

- МХХТ-ийг сургууль болон тасралтгүй боловсролын хүртээмжийг сайжруулах болон танхимын сургалтын чанарыг сайжруулахад үр дүнтэй хэрэглэж болно.
- МХХТ нь өөр өөр сургуулиудын сурагчид, багш нарын хооронд сүлжээ үүсгэх, хамтран ажиллах боломжийг хангаснаар суралцах үйл явцыг оролцоот, сонирхолтой болгоно.
- МХХТ-ийг боловсролын салбарт ашиглахын нэг гол элемент нь багш нарын боловсролыг дээшлүүлэх явдал билээ.
- МХХТ-ийг АББ-д өргөн хүрээнд ашигладаг ба үүгээр дамжуулан залуус, насанд хүрэгсдэд эрүүл мэнд, хоол тэжээл, байгаль орчин зэрэг олон салбарын суурь мэдлэгийг олгон, тэдний амьдралын чанарыг дээшлүүлж байна.



ДАСГАЛ

Дээрх кейс судалгаануудаас харвал МХХТ нь боловсролын хүртээмжийг сайжруулах, SchoolNet зэрэг хамтын сүлжээг байгуулах гэх мэтээр боловсролын чанарыг сайжруулдаг болох нь тодорхой байна. Гэхдээ бичиг үсгийн боловсролгүй ядуу иргэдэд боловсрол олгоход МХХТ-ийг ашиглаж болох уу? Энэ талаар танай оронд болон өөр орнуудад хийгдсэн үйл ажиллагаануудын талаар хэлэлцэнэ үү.

20. Philip Wong, "Bhutan 'Support for Teacher Education' Project," in *ICT in Teacher Education: Case Studies from the Asia-Pacific Region*, ed. Ellie Meleisea (Bangkok: UNESCO, 2007), 3-9, <http://www.unescobkk.org/index.php?id=7035>.

21. Sarah Lucas Pouezevara and Binita Parajuli, "Using Video Technology for Primary School Teacher Training in Rural Nepal," in *ICT in Teacher Education: Case Studies from the Asia-Pacific Region*, ed. Ellie Meleisea (Bangkok: UNESCO, 2007), 62-73, <http://www.unescobkk.org/index.php?id=7035>.

22. Ibid.

23. Ibid.

3.3 МХХТ БОЛОН ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДАЛ



ЗОРИЛГО 3: ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ МЭДЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилт 4: Хүйсийн ялгааг 2005 он гэхэд бага болон дунд боловсролд, 2015 он гэхэд бүх шатны боловсролд арилгах

Хүйсийн тэгш бус байдал нь зөвхөн охид, эмэгтэйчүүдийн асуудал биш юм. Хүн амын бараг тал хувь нь тэгш эрх, боломж эдлэхгүй байгаагаас нийгэм, эдийн засагт өөрийн хувь нэмрийг оруулах боломжгүй нөхцөлд амьдарч буй юм.

Энэхүү баримтыг албан ёсоор дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч хүйсийн тэгш байдлыг МХЗ-уудад тусгайлан багтаасан юм. Гэхдээ одоо ч шийдвэр гаргалт, хэрэгжилтийн шатанд тодорхой бус зүйлс ихээр байсаар байна. Олон тооны хөгжлийн хөтөлбөр, бодлого нь хүйсийн хувьд мэдрэмжгүй, МХХТ-ийн хамааралтай бодлого, үйл ажиллагаанд ч гэсэн энэхүү байдал харагдаж буй юм. Шведийн олон улсын хөгжлийн агентлагаас хийсэн судалгаанаас үзвэл²⁴ МХХТ нь хэд хэдэн салбарт ядуурлыг бууруулахад дэмжлэг болдог ч ихэнх МХХТ-ийн төслүүд нь эмэгтэйчүүдийн асуудлыг тусгайлан анхаарахгүйгээр ерөнхийдөө “ядуу” иргэдэд төвлөрөн ажиллаж буй ажээ²⁵. Үүний улмаас эмэгтэйчүүд тухайн төслүүдийн үр шимийг хангалттай хүртэхгүй байна. МХХТ нь нийгмийн оролцооны аргачлал болж буй энэ үед эмэгтэйчүүдийг МХХТ-ийн ур чадварт сургахад төвлөрөн ажиллахгүй байна гэдэг нь тэднийг улам л цааш нь эмзэг бүлэг рүү түлхэж байгаа хэрэг юм.

Эмэгтэйчүүд МХХТ-ийг өөрсдийн статусыг дээшлүүлэхэд ашиглах замаар шууд, МХХТ-ийг эмэгтэйчүүдэд мэдээлэл, үйлчилгээ хүргэхэд ашиглах замаар шууд бус үр дүнг бий болгох боломжтой. МХХТ нь эмэгтэйчүүдэд цахим худалдаанд шууд оролцох, боловсрол, цахим засаг зэрэг үйлчилгээг авах замаар тэдний эдийн засгийн байдалд саад болж байсан нийгэм-эдийн засгийн саад тотгорыг даван туулж чадна. Эмэгтэйчүүдийн бүлгүүд МХХТ-ийг ашиглан эмэгтэйчүүдийн эрх, оролцоог хангах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах болсон нь тэд өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх, эмэгтэйчүүдийн асуудлаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх шинэ харилцаа холбооны форумыг үүсгэн бий болгож буй юм.

МХХТ-ийн хэрэглээн дэхь хүйсийн хуваагдлын талаарх мэдээлэл ихэнх Ази, Номхон далайн орнуудын хэмжээнд бараг байхгүй. Гэхдээ эмэгтэйчүүд МХХТ-ийг хэрэглэхэд, үүнийг ашиглан боловсрол, эдийн засгийн боломжийг бий болгоход тулгарч буй хамгийн түгээмэл саад тотгор нь бичиг үсэг үл мэдэх байдал, мэдлэг дутагдах, ядуурал, цаг хомс байх, өөртөө итгэх итгэл сул байх болон нийгэм-соёлын хэм хэмжээ зэрэг байгаа нь тодорхой. МХХТ-ийн хүртээмжийг бий болгоход эмэгтэйчүүдэд тулгарч буй бусад саад тотгорыг үндсэндээ гурван ангилалд хамруулж болох ба үүнд хамаарал, хүртээмж болон хэрэглээ багтана. Агуулга буюу контент нь эмэгтэйчүүдийн амьжиргаа болон бусад асуудлуудтай шууд хамааралгүй, эмэгтэйчүүдийн мэдлэг, туршлага болон ухааныг үнэлээгүй бол эмэгтэйчүүдийн МХХТ-ийн хэрэглээ нь хязгаарлагдмал байдаг. Судалгаанаас үзвэл МХХТ-ийг ашиглан түгээж буй контент нь эмэгтэйчүүдийн амьжиргаанд шууд нөлөөлөл үзүүлэхгүй бол тэд МХХТ-ийн хэрэгцээ болон үр шимийг хүртдэггүй ажээ.²⁶

Эмэгтэйчүүдэд амьжиргаагаа дээшлүүлэхэд нь тусалсан МХХТ-ийн шууд үйл ажиллагааны хамгийн түгээмэл жишээ нь Бангладешийн Грамин утасны төсөл юм.

24. Alan Greenberg, ICTs for Poverty Alleviation: Basic Tool and Enabling Sector (Stockholm: Swedish International Development Agency, 2005), <http://www.sida.se/sida/jsp/sida.jsp?d=118&a=3607&language=en>.

25. Anita Dighe and Usha Vyasulu Reddi, Women's Literacy and Information and Communication Technologies: Lessons that Experience has Taught Us (New Delhi: Commonwealth Educational Media Centre for Asia and Commonwealth of Learning, 2006), 33, http://www.cemca.org/CEMCA_Womens_Literacy.pdf.

26. Sophia Huyer and Swasti Mitter, ICTs, Globalisation and Poverty Reduction: Gender Dimensions of the Knowledge Society - Part I. Poverty Reduction, Gender Equality and the Knowledge Society: Digital Exclusion or Digital Opportunity? (New York: Gender Advisory Board, 2005), 19, <http://gab.wigsat.org/part1.pdf>.



Бангладешийн Грамин утасны түүх

Тосгоны утас хэмээх төсөл нь Бангладешийн ядууст харилцаа холбооны орчин үеийн үйлчилгээг хүргэх онцлог санаанаас үүдэлтэй. Бангладешийн хөдөө нутгийн ядууст барьцаагүй зээл олгох чиглэлээр дэлхийд нэрд гарсан Грамин банк энэхүү Тосгоны утас хөтөлбөрт чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тус банк нь Грамин Телекомын Тосгоны утас хөтөлбөрт гишүүдийг сонгох, төлбөр цуглуулах, өдөр тутмын асуудлуудыг шийдэх зэргээр туслалцаа үзүүлсэн байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь:

- Бангладешийн хөдөө орон нутагт утасны үйлчилгээг хурдан, хялбар байдлаар хүргэх;
- Тосгоны иргэдэд зориулан орлого олох шинэ сонголтуудыг санаачлах;
- Мэдээллийн хувьсгалын үр шимийг тосгоны иргэдэд шууд хүргэх (жишээ нь МТ-ийг хаалганд нь хүргэх); болон
- Хөдөө орон нутгийг дэлхийтэй холбож, шинэ боломжийг авчрах замаар ядууралтай тэмцэхэд утасны үйлчилгээг гол аргачлал болгон ашиглах.

Өмнө нь авсан зээлээ хугацаанд нь төлж байсан, бичиг үсэг мэддэг эсвэл бичиг үсэг мэддэг хүүхэд, төрөл төрөгсөд бүхий Грамин банкны гишүүн хэн боловч Тосгоны утас авч, ажиллуулах эрхтэй байжээ. Үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн төлсөн ярианы төлбөр болон тосгоны утас ажилуулагчийн утасны төлбөр зэргээс гол орлогоо олж байлаа.

Энэхүү хөтөлбөр нь ихээхэн амжилттай болсон шалтгаан нь Бангладеш нь үндсэндээ тэгш газар оршдог, шигүү суурьшсан, ядуу иргэд олонтой тул үүрэн телефоны дохио хол зайд тархах боломжтой байж хөрөнгө оруулалт бага шаардаж байсан билээ. Тосгоны утасны операторууд болон хамаарах бусад байгууллагуудын хувьд ч эдийн засгийн үр өгөөж өндөр байсан ба жишээ нь холбооны компани орлого олж, бичил санхүүгийн байгууллагын зээл эргэн төлөгдөж, тосгоны иргэд хямд утсан холбоотой болох зэргээр бүгд үр ашигтай ажилласан байна. Улмаар үнэлгээний үр дүнгээс харвал энэхүү орчин үеийн технологи нь тосгоны утас ажилуулагч эмэгтэйчүүдийн статусыг нэмэгдүүлж, тэд Засгийн газар болон ТББ-уудын үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээг утсаар авах боломжтой болж, илүү хүчирхэгжсэн байна.

Эх сурвалж: Adapted from Grameen Telecom, "The Concept of Village Phones," <http://www.grameentelecom.net.bd/vp.html>; and Grameen Foundation, "Village Phone: Connecting Technology and Innovation," http://www.grameenfoundation.org/what_we_do/technology_programs/village_phone.



АСУУЛТ

Грамин утасны хөтөлбөр нь дэлхийн бусад хэсгүүдэд ч мөн хэрэгжиж эхэлж байна. Гэхдээ үүрэн телефоны технологийн зардал хурдтай буурч буй энэ үед ядуу хүмүүс ч гэсэн өөрсдөө утас худалдан авах боломжтой болж буй тул, та Тосгоны утас мэтийн хөтөлбөр цаашид үргэлжлэх боломжтой гэж үзэж байна уу? Хөтөлбөрийн тогтвортой байдал ямар байх вэ? Хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, өргөтгөхийн тулд юу хийх ёстой бэ?

МХХТ нь эмэгтэйчүүдэд шинээр эдийн засгийн боломжуудыг бий болгосон олон жишээг Энэтхэг, Филиппин зэрэг улсад хэрэгжсэн МХХТ-т суурилсан үйл ажиллагаа болох дуудлагын төв болон дуудлагын утасны үйлчилгээ зэрэг ажилд эмэгтэйчүүд ихээр ажилладаг болсоноос харж болно. Телефонд суурилсан ажил эрхлэлт болон зарим худалдааны ажлууд нь эмэгтэйчүүдэд гэрээсээ ажлаа хийх боломжийг олгож байгаа юм. Эдгээр МХХТ-ийн тусламж бүхий эдийн засгийн боломжууд нь эмэгтэйчүүд тэдгээрийг төлөвлөж, үйл ажиллагааг нь эрхлэж, удирдсан тохиолдолд илүү үр дүнтэй байдаг ба үүний жишээг Малайзын eHomemakers жишээн дээрээс харж болно.



Салаам Ванита, Малайз

Салаам Ванита нь Малайзын анхдагч сүлжээ болох eHomemakers буюу МХХТ-ийг ашиглан жижиг оффис-гэр-оффис зарчмаар бизнес эрхлэж буй эмэгтэйчүүдийн онлайн сүлжээ юм.

Анхан үедээ eHomemakers нь бага болон дунд орлоготой, гэртээ хүүхдээ харах ажилтай Малайзын эмэгтэйчүүдийн хэрэгцээнд анхааран ажиллаж байжээ. Энэхүү төслийн ихэнх хэсэг болох төлөвлөлт, дизайн гаргах болон гүйцэтгэх үйл ажиллагааг сайн дурын эмэгтэйчүүд гүйцэтгэж байжээ. Анхлан байгуулагдсанаас хойш хэдхэн жилийн дараа eHomemakers нь санхүүгийн хувьд ашигтай ажиллах болж, нийгэмд танигдаж эхэлжээ.

Засгийн газраас олгосон тэтгэлгийг ашиглан eHomemakers нь Салаам Ванита сүлжээг байгуулан хүчирхийлэлд өртсөн, хөгжлийн бэрхшээлтэй, архаг өвчтэй болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн асуудлыг шийдэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 2002 онд Салаам Ванитагийн 200 орчим гишүүн компьютер, Интернетийн анхан шатны сургалтад хамрагджээ. Улмаар тэдний зарим хэсэгт зориулан хуучин компьютер худалдан авч өгсөнөөр тэд шинээр эзэмшсэн ур чадвараа орлого олох, бие дааж бизнес эрхлэхэд ашиглах болсон байна. Салаам Ванита нь мөн эмэгтэйчүүдэд эко сагс нэхэх сургалтыг явуулдаг байна. Эмэгтэйчүүд мөн бизнесийн удирдлагын сургалтад хамрагдсанаар бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоох болон санхүүгээ удирдах зэрэгт суралцдаг ажээ.

Эдийн засгийн шинэ боломжуудаас гадна eHomemakers нь эмэгтэйчүүдэд нийгэмд тулгарч буй гол асуудлаа шийдэхэд нь туслалцаа үзүүлдэг байна. eHomemakers сүлжээнд нэгдсэнээр амьдрал тааруу, амиа хорлох шатанд байсан эмэгтэйчүүд ч өөрчлөгдөх болсон байна.

Зөвхөн залуу, боловсролтой хүмүүс л МТ-ийг ашиглах ёстой гэсэн уламжлалт үзлийг сөрсөн eHomemakers нь өөрийн порталыг ардчилсан орон зай болгосон бөгөөд үүгээр дамжуулан сонголтын үзэл баримтлал, ажлын зардал, технологи болон амьжиргааны чиглэлээр олон амжилтад хүрчээ. Хамгийн сүүлийн мэдээгээр eHomemakers нь ойролцоогоор 10,000 гишүүнтэй болсон бөгөөд вебсайтад нь 10,500 зочин зочилж, 28,000 хандалт хийж, 100,000 хуудас үзсэн тооцоо гарсан байна.

Эх сурвалж: Adapted from eHomemakers, "About Us: Empowering Homemakers to Become Homepreneurs: eHomemakers Malaysia," Corpcom Services Sdn. Bhd., <http://www.ehomemakers.net/en/aboutus.php?id=48>. eHomemakers; and "Just Marketing: Salaam Wanita Project," Corpcom Services Sdn. Bhd., <http://www.justmarketing.info>.



АСУУЛТ

eHomemakers болон Салаам Ванита зэрэг хөтөлбөрийн амжилтад ямар хүчин зүйл нөлөөлсөн гэж та үзэж байна вэ? Ийм төрлийн хөтөлбөрийг танай улсад хуулбарлан хэрэгжүүлэх боломжтой юу? Мөн АНДБЭЗНХ-ын тэргүүлэх ач холбогдол бүхий улсуудад хэрэгжүүлэх боломжтой юу?

МХХТ нь үзэл бодлоо солилцох, сонирхлоо нэгтгэх, улс төрийн лидерүүдийг эмэгтэйчүүдийн асуудалд анхаарал хандуулах зэрэг харилцаа мэдээллийн платформыг бий болгох замаар төр засгийн үйл ажиллагаа, улс төрийн харилцаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх үндэс болдог. Эмэгтэйчүүдийн нөлөөллийн бүлэг нь МХХТ-ийн сүлжээг үр дүнтэйгээр ашиглан бие биетэйгээ холбогдох, олон нийтийн санал бодлыг нэгтгэх зэргээр ашиглаж болно. Жишээ нь Эмэгтэйчүүдийн судалгааны төв (CENWOR),²⁷ буюу Шри-Ланкын эмэгтэйчүүдийн бүлгүүдийн МТ-ийн хэрэглээнд мониторинг хийдэг байгууллагын тайланд сүлжээнд нэгдэн ажиллах явдал сайжирсан нь МХХТ-ийн хамгийн гол амжилтуудын нэг хэмээн дүгнэсэн байна. Шри-Ланкын эмэгтэйчүүдийн бүлгүүд нь ижил төстэй олон улсын эмэгтэйчүүдийн бүлгүүд, идэвхтэнүүдтэй үр бүтээлтэй холбоо тогтоож байна. Үүний нэгэн адил Пакистаны хамгийн ихээр хүлээн зөвшөөрөгдсөн эмэгтэйчүүдийн эрхийн бүлэг болох Ширкат Гах нь Интернэтийг ашиглан эмэгтэйчүүдийн сүлжээнд нэгдэх, мэдээлэл харилцааны эрхүүдийг дэмжиж, эмэгтэйчүүдэд тулгарч буй асуудлуудыг стратегийн хүрээнд дэлхий нийтийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй холбон өгсөн байна²⁸.

Гэхдээ энэ бүх үйл ажиллагаанд байнга сорилтууд тулгарсаар байгаа. Нийгэм, соёлын хандлага нь үндэс суурь сайтай, эмэгтэйчүүдийн ихэнх нь боловсрол, амьжиргааны үр чадвар дорой үед тэд МХХТ-ийн бүрэн боломжийг хэрхэн ашиглаж чадахыг төсөөлөхөд бэрх. Орон нутгийн хэл дээрх програм хангамж, контент дутагдалтай байгаа, техник хангамж үнэтэй байгаа нь тулгарч буй саад тотгорын нэг болж байна. Үндэсний хэмжээний МХХТ-ийн бодлого болон хэрэгжүүлэлтийн голлох этгээд нь хүйсийн асуудлыг өөрсдийн гаргаж буй бодлого, төлөвлөгөөний хэсэг болгонд тусган оруулахгүй бол, эмэгтэйчүүдэд тусгай бүлэг болгон төвлөрөн ажиллахгүй бол МХХТ-ийн тусламжтай хөгжил бодит хэрэг болж чадахгүй юм.

ДҮГНЭЛТ

- Эмэгтэйчүүдийн боловсрол, МХХТ-ийн хүртээмжийг сайжруулахад тулгарч буй саад тотгор нь ихэнхдээ ижил- ядуурал, бичиг үсэг үл мэдэх байдал, цаг хомс байх болон хамаарах контент дутмаг байх зэрэг асуудлууд байна.
- Гэхдээ эмэгтэйчүүдэд технологи ханган өгсөн тохиолдолд тэд өөрсдийн эдийн засаг, нийгмийн статусыг сайжруулахад ашиглаж чадна.
- Эмэгтэйчүүд технологийг зөвхөн суралцах, орлого олох зорилгоор ч бус мөн Интернэтэд эмэгтэйчүүдийн орон зайг бий болгох, сүлжээ үүсгэх, асуудлуудаа хуваалцах, хүйсийн тэгш байдлын төлөө лобби хийх зэргээр ашиглаж болно.

27. See CENWOR, <http://www.cenwor.lk>.

28. W. Harcourt, "World Wide Women and the Web," in *Web Studies: Rewiring Media Studies for the Digital Age*, ed. David Gauntlett (Rome: Society for International Development, 2000).



ДАСГАЛ

Өөрийн орон дахь эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл, эдийн засгийн хараат бус байдлыг хөгжүүлэх МХХТ-ийг ашигласан төсөл боловсруул. Юуны өмнө тодорхой эмэгтэйчүүдийн бүлгийг (настай, ядуу, есвэр насны охид, тодорхой орон нутгийн эмэгтэйчүүд гэх мэт) тодорхойл. Тэдний нөхцөл байдал болон нийгэм, эдийн засгийн хэрэгцээг тогтоо. Дараагаар нь төслийн зорилтууд, хүлээгдэж буй үр дүн, төслийн стратегийг тогтоо. Хүлээгдэж буй үр дүндээ хүрэх цаг хугацааг тодорхойлж бас болно.

3.4 МХХТ БОЛОН ЭРҮҮЛ МЭНД



ЗОРИЛГО 4: ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 5: 1990-2015 онд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны хоёроор бууруулах

ЗОРИЛГО 5: ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 6: 1990-2015 онд эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах

ЗОРИЛГО 6: ХДХВ/ДОХ, ХУМХАА БОЛОН БУСАД ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ

Зорилт 7: 2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний тархалтыг зогсоож, бууруулж эхлэх

МХХТ нь хөдөөгийн алслагдсан бүс нутаг болон хот суурин газруудын хооронд эрүүл мэндийн мэдээллийг дамжуулах хоёр урсгал бүхий аргачлал болон хөгжиж, эрүүл мэндийн мониторингийн систем, анагаах ухааны судалгааны шинэ ололтуудыг эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд тасралтгүйгээр олгох болжээ. Үүнээс үзвэл эрүүл мэндийн салбарт МХХТ-ийг хэрэгжүүлсэнээр хоёр гол оролцогч тал үр шимийг нь хүртэж буй юм. Эхний бүлэгт эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай энгийн иргэд ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээллийн хүртээмж муу иргэд буюу эмзэг бүлгийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон гамшигт нэрвэгдсэн хүмүүс орж байна. Товчлоод хэлбэл МХХТ-ийн дэмжлэгтэй эрүүл мэндийн үйлчилгээний анхдагч үр дүнг хүртэгчид нь энгийн иргэд болж байна. Хоёрдахь ангилалд анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид буюу эмч, сувилагч, асрагч, судлаач, эрүүл мэндийн менежерүүд болон эрүүл мэндийн салбарын бодлого боловсруулагч нар ч орно. Эхний бүлгийн хувьд МХХТ-ийн оролцоо нь шууд байх ба өвчтөнүүдийг эрүүл мэндийн үйлчилгээтэй шууд холбож өгнө. Хоёрдахь бүлгийн хувьд МХХТ-ийн оролцоо нь шууд бус буюу дэмжих байдалтай, жишээ нь эрүүл мэндийн мониторингийн системийг бий болгох, мэргэжлийн байнгын сургалтаар хангах зэргээр байна. Доорх хэсэг дээр энэхүү хоёр төрлийн оролцоо, үйл ажиллагааны талаар хэлэлцэх болно.

МХХТ-ийг эрүүл мэндийн салбарт ашиглаж буй хамгийн түгээмэл хэрэглээ нь теле-медицин буюу теле-анагаах ухаан билээ. Цахим эрүүл мэнд (e-Health) хэмээн нэрлэгддэг энэхүү хэрэглээ нь хиймэл дагуулын эсвэл өргөн зурвасын технологид суурилсан бөгөөд хөдөө орон нутгийн алслагдсан байрлалд буй өвчтөнүүдийг хотуудад ажиллаж буй анагаах ухааны мэргэжилтнүүдтэй холбодог. Үүний нэг хэлбэр нь интерактив байдлаар буюу видео конференц байдлаар хийгдэж эмч, өвчтөн алсын зайнаас харьцах боломжийг олгодог. Үзлэгийн өрөөнд буй камер нь өөр байрлалд буй мэргэжилтэнд үзлэг хийх боломжийг олгодог. Өвчтөнийг хот руу аваачих эсвэл эмчийг хөдөө явуулах зардлыг ихээр хэмнэх боломжийг бий болгоно. Энэ нь мөн эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай үед эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг өргөтгөж өгдөг.

Энэтхэг нь теле-анагаах ухааныг өргөн хүрээнд ашиглаж буй хэд хэдэн орны нэг билээ. Одоогоор найман мужийн 78 эмнэлэг Энэтхэгийн сансар судлалын байгууллагын (ЭССБ) сүлжээнд холбогдон мэргэжлийн, өндөр түвшний зөвлөгөөг алслагдсан зүүн хойд хэсэг болон Андаман, Никобарын арлуудад хүргэж байна²⁹. Пакистан улс мөн 1998 оноос хойш³⁰ теле-анагаах ухааны (Store and Forward Telemedicine) системийг ажиллуулдаг бөгөөд энэхүү системээр өвчтөний мэдээллийг орон нутагц цуглуулан хадгалаад, улмаар дэлхийн хаа ч байгаа эмч нарт илгээн 24-48 цагийн дотор онош болон эмчилгээний зааврыг хүлээн авдаг байна. Тайланд³¹ болон Малайз улс (Medical Online)³² нь мөн теле-анагаах ухааны системийг нэвтрүүлжээ. Транс Евро-Азийн мэдээллийн сүлжээ 2 (TEIN2) нь энэхүү бүсийн эмнэлгүүдийг буюу Австрали, Хятад, Индонези, Япон, Малайз, Филиппин, БНСУ, Сингапур, Тайланд, Вьетнам зэрэг улсуудыг өргөн хүрээнд холбож, 30 сая гаруй хэрэглэгчдэд хүрч байна.³³ Афганистан улсад шинэлэг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд теле-анагаах ухааны үйлчилгээг алслагдсан бүс нутгуудад хүргэж байна. Азийн хэд хэдэн оронд³⁴ хэрэгжиж буй теле-анагаах ухааны төслүүдийн тоонд Непалын³⁵ HealthNet, Индонезийн олон талын харилцаат холболт болох МХХТ-т суурилсан хөдөлгөөнт теле-анагаах ухааны систем орж байна.

Доор байгаа Пакистаны кейс судалгаа нь хөдөө орон нутгийн эрүүл мэндийн асуудлыг вебд суурилсан теле-анагаах ухааны хүрээнд ашиглахын давуу тал, чадавхийн тухай өгүүлэх болно.

-
29. See ISRO, "International Telemedicine Conference India 2005," http://www.isro.org/pressrelease/Mar15_2005.htm; and R.L.N. Murthy and L. S. Satyamurthy, "Indian Telemedicine Program: Marching Toward Transforming National Healthcare Delivery System," ISRO, http://www2.telemed.no/ttec2007/presentations/session08_tuesday/s08_tue_1315_Abdul_OK.ppt.
 30. See TelmedPak, "Telemedicine in Pakistan," <http://www.telmedpak.com>.
 31. See PubMed, "The Ministry of Public Health Telemedicine Network of Thailand," National Center for Biotechnology Information, <http://www.ncbi.nlm.nih.gov/pubmed/11311665>.
 32. See Association of Private Hospitals of Malaysia, "About Medical Online," <http://www.hospitals-malaysia.org/index.cfm?menuid=35>.
 33. See DANTE Ltd., "TEIN2," <http://www.tein2.net>.
 34. See Michael Dougherty, Exploring New Modalities: Experiences with Information and Communications Technology Interventions in the Asia-Pacific Region - A Review and Analysis of the Pan-Asia ICT R&D Grants Programme (Bangkok: UNDP-APDIP, 2006), 121-140, <http://www.unapcict.org/ecohub/resources/exploring-new-modalities>.
 35. See Institute of Medicine, Kathmandu, Nepal, "HealthNet Nepal," <http://www.healthnet.org.np/?p=profile>.



Пакистаны теле-анагаах ухаан

Пакистан улсад ядуучуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байдаг учраас TelmedPak хэмээх санаачилга нь МХХТ-ийг ашиглан энэхүү асуудлыг шийдэх оролдлого хийж байна. Үүний эхний аргачлал нь цуглуулах болон илгээх зарчмаар ажилладаг теле-анагаах ухаан юм (дээр дурдсан). Өөр нэгэн ашигладаг аргачлал нь Бодит цагийн теле-анагаах ухаан буюу орон нутгийн эмч дээр өвчтөнг үзүүлэхэд л энэ талаарх бүх мэдээлэл мэргэжилтэн дээр очиж бодит цагийн горимоор зөвлөгөө авах арга юм. Энэхүү аргачлалын хүрээнд видео конференцын технологийг ашиглан, өгөгдлийг шууд дамжуулдаг.

The screenshot shows the TelmedPak website interface. The main header features the TelmedPak logo with the tagline 'a click away'. Below the header is a navigation menu with links for Home, Health, Telemedicine, Medical Education, and About Us. The main content area is titled 'TeleMedicine in Pakistan' and contains an article. The article discusses the challenges of telemedicine in Pakistan, particularly in rural areas, and highlights the importance of telemedicine in developing countries like Pakistan. The article is dated Thursday, 26th June, 2008.

Таксилла, Гилгит болон дээд Пунжаб мужуудад энэхүү систем нь эмч, өвчтөний хооронд шууд харилцаа тогтоодог байна. Энэхүү систем нь мөн гамшгийн үеэр чухал шаардлагатай үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Гималайн нурууны дээд хэсгүүдээр оршдог тосгодод үүнээс өөрөөр туслалцаа үзүүлэх арга бараг байдаггүй ажээ.

Эх сурвалж: Adapted from TelmedPak, "Telemedicine in Pakistan," <http://www.telmedpak.com/> and <http://www.telmedpak.com/Telemedicine/>.



АСУУЛТ

Пакистанд хэрэгжсэн энэхүү төсөл нь алслагдсан, ядуу иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх МХХТ-ийн шууд оролцоо болон эрүүл мэндийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх хэлбэрээр явагддаг МХХТ-ийн дэмжлэгтэй үйл ажиллагаануудыг харуулж байна. Үүний амжилтын нууц юунд байна вэ? Төслийн тогтвортой байдлыг баталгаажуулахад юу хийх хэрэгтэй гэж та үзэж байна вэ? Энэхүү төслийг бусад улсад болон танай улсад хуулбарлан хэрэгжүүлэх боломжтой юу?

Шаардлагатай гэж үзвэл төслийн вебсайт руу орж мэдээлэл аваарай.

МХХТ-ийг ашиглан эмч нар болон алслагдсан нутагт байгаа ядуу өвчтөнүүдийг холбох нь тухайн улсын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж болон чанарт шууд ач холбогдолтой юм. Гэхдээ МХХТ-ийг ашиглан эрүүл мэндийн боловсролын чанар болон удирдлагыг сайжруулах нь ихээхэн чухал бөгөөд учир нь эдгээр нь эрүүл мэндийн үйлчилгээний түгээлт, хангалтад өөрийн эерэг нөлөөг үзүүлдэг. Хөгжиж буй олон оронд эрүүл мэндийн мэргэжилтнүүд дутагдалтай, тэр тусмаа анагаах ухааны сургалтын эмнэлгүүдэд эмч нар бүр их дутагдалтай байдаг. Шаардлагатай анагаах ухааны ном хэвлэлийн хүртээмж нь оюутнууд болон эрүүл мэндийн ажилтнуудад ч хомс байдаг нь тэднийг анагаах ухааны шинэ ололтуудтай зэрэгцэн хөгжих боломжийг хааж өгдөг. МХХТ нь энэхүү хэрэгцээг хангахад ихээхэн чухал үүрэгтэй. Жишээ нь Энэтхэгийн залуу эмч нарын эхлүүлсэн санаачилга нь анагаах ухааны чиглэлийн контентыг мултимедиа хэлбэрээр онлайн болон оффлайн байдлаар оюутнууд, эмч нар болон бусад мэргэжилтнүүдэд түгээж байна³⁶. Дэлхий нийтийн сүлжээ нь анагаах ухааны сэтгүүл болон өргөн хүрээний онлайн номын сангуудад үнэгүй эсвэл хямдруулсан үнээр нэвтрэх боломжийг хангаж байгаа билээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) дэмжлэг бүхий веб-портал болон HINARI нь дэлхий нийтийн эрүүл мэндийн салбарын ажиллагсад болон бодлого боловсруулагч нарт хандсан дэмжлэгийг үзүүлж байна.



Судалгааны санаачилгуудад зориулсан эрүүл мэндийн InterNetwork сүлжээ

Судалгааны санаачилгуудад нэвтрэх Health InterNetwork сүлжээг ДЭМБ томоохон хэвлэн нийтлэгч нартай хамтран байгуулсан ба үүний зорилго нь хөгжиж буй орнуудад дэлхийн хэмжээний хамгийн том био-анагаах ухаан болон эрүүл мэндийн ном хэвлэлийг хүргэх явдал юм. Одоогоор 3,750 гаруй сэтгүүл 113 орны эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй байгаа нь олон мянган эмч нарт дэмжлэг болж, дэлхий нийтийн эрүүл мэндийн сахин хамгаалахад хувь нэмрээ оруулж байна.

2000 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын анхлан нээсэн энэхүү сүлжээ нь төр болон хувийн хэвшлийг нэгтгэн, эрүүл мэндийн мэдээллийг тэгш хүртэх боломжийг ханган, эмч нар, судлаачид болон бодлого боловсруулагчид үр дүнтэйгээр ашиглаж байна.

Эх сурвалж: Adapted from WHO, "HINARI Access to Research Initiative," <http://www.who.int/hinari>.

36. See MEdRC EduTech Ltd., "SmarTeach," <http://www.smarteach.com>.



АСУУЛТУУД

HINARI вебсайт болон бусад мэдээ, тайланг судлан үзэж ийм төрлийн дэмжих систем нь хэр үр дүнтэйгээр сүүлийн үед гарч буй өвчнүүдийн жишээ нь CAPC болон шувууны ханиад зэрэг өвчнийг тандан судлахад хэрэглэгдэж буйг судал. Танай орны эрүүл мэндийн салбарт энэхүү системийг хэрэглэдэг үү? Яагаад?

Эмнэлэг, эрүүл мэндийн удирдлагыг шинэчлэх хүчин чармайлтын хүрээнд эрүүл мэндийн салбарт хэрэглэх олон тооны програм хангамж боловсруулсан билээ. Эдгээр удирдлагын мэдээллийн систем нь хэлтэс, тасаг болгоны өвчтөний мэдээллийг хөтлөх, тайлагнаж, улмаар интранет системд орж удирдахад хялбар болгодог. Ийм төрлийн төслүүдийн нөөц эх үүсвэрийн шаардлагыг аваад үзвэл энэхүү салбарт хувийн эмнэлгүүд тэргүүлж байгаа нь гайхах зүйл биш юм.

МХХТ-ийн эрүүл мэндийн салбар дахь өөр нэгэн чухал хэрэглээ нь МХХТ-т суурилсан тандан судалгааны систем бөгөөд үүний тусламжтайгаар ДОХ/ХДХВ, хумхаа, сүрьеэ зэрэг өвчнөөс сэргийлэх, тайлагнах, хяналт шинжилгээг хийдэг.³⁷ Ийм төрлийн системийн хүртээмж нь олон улсын байгууллагууд болон Засгийн газрууд хил дамнан гарч болох өвчний тархалтад мониторинг хийхэд мөн тустай. Жишээ нь CAPC, шувууны ханиад зэрэг хурдацтай тархаж буй өвчнөөс сэргийлэх болон эмчлэхэд МХХТ-ийн дэмжлэг бүхий эрүүл мэндийн тандан судалгааны систем чухал шаардлагатай.

Гэхдээ Ази тивд хэд хэдэн орон МХХТ-ийг хэрэглээг бий болгоход шаардагдах суурь дэд бүтэц хомс хэвээр байсаар байна. Үүний улмаас МХХТ-ийн эрүүл мэндийн салбарт ашиглах нь дөнгөж анхан шатандаа байгаа юм. МХХТ-ийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхээс нааш МХХТ-ийн дэвшлийг эрүүл мэндийн системд нэвтрүүлэх нь мөрөөдөл хэвээр байх болно.

ДҮГНЭЛТ

- Эрүүл мэндийн салбарын гол оролцогч талууд нь үйлчилгээг хүртэгчид, ялангуяа ядуу болон алслагдсан иргэд болон эрүүл мэндийн ажилтнууд байдаг.
- Теле-анагаах ухаан нь МХХТ-ийн эрүүл мэндийн салбар дахь хамгийн түгээмэл хэрэглээ билээ. Үүнийг Ази, Номхон далайн бүсийн олон оронд өргөнөөр хэрэглэж байна.
- Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хэрэгцээнд зориулсан HINARI зэрэг хэд хэдэн дэлхий нийтийн үйл ажиллагаа явагдаж байгаа.
- Дэлхий нийтийн тандалт судалгааны систем нь улс орнуудад CAPC, шувууны ханиад зэрэг хил дамнасан өвчний аюулыг бууруулах боломжийг олгодог.

37. UNDP, Regional Human Development Report – Promoting ICT for Human Development in Asia: Realising the Millennium Development Goals (New Delhi: UNDP, Elsevier, 2005), 147-160, <http://www.apdip.net/elibrary#rhdr>.



ДАСГАЛ

Танай орон дахь ядуусын дунд байгаа эрүүл мэндийн нэг хэрэгцээ болон энэхүү хэрэгцээг хангаж чадах эрүүл мэндийн нэг үйлчилгээг сонгон ав. Энэхүү хэрэгцээ болон үйлчилгээг үр дүнтэйгээр холбоход МХХТ-ийн ямар хэрэглээг ашиглаж болох талаар хэлэлц.

3.5 МХХТ БОЛОН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГА



ЗОРИЛГО 7: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилт 9: Тогтвортой хөгжлийн зарчмуудыг улс орны бодлого, хөтөлбөрүүдэд тусгаж, байгалийн нөөцийн хомсдлыг арилгах

Зорилт 10: 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэж чадахгүй хүмүүсийн хувь хэмжээг 2 дахин бууруулах

Зорилт 11: 2020 он гэхэд орон байрны нөхцөл муу 100 сая хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах зорилтыг хангах

Нөөц эх үүсвэрийн тэгш бус хуваагдал болон байгалийн нөөц баялагийн хяналтгүй ашиглалт нь дэлхий нийтийн хэмжээнд хямрал үүсгэж буй юм. Уур амьсгалын өөрчлөлт, ган болон үер зэрэг нь дэлхийн хаа ч улам ихээр тохиох болжээ. Арлын орнууд нь уур амьсгалын өөрчлөлт, далайн усны түвшин нэмэгдэхэд нэн эмзэг бол далайд гарцгүй, уулархаг нутгууд нь мөсөн уул, мөнх цас хайлах, хөрсний эвдрэл, цасны нуралт зэрэгт өртөмтгий байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн эмзэг золиос нь ядуус бөгөөд тэд хаана ч амьдарч байсан дэлхийн хэмжээнд үүсэж буй үзэгдлээс хамааран тэдний амьжиргаанд байнга сөргөөр нөлөөлж буй юм. Энэ талаар Энэтхэгийн фермерүүд дээр хийсэн томоохон судалгааны дүн батлан харуулж байна.

МХХТ-ийг байгаль орчны асуудлуудыг шийдэхэд өөрийн гэсэн үүрэгтэй жишээ нь газар зүйн мэдээллийн системийг (ГЗМС) ашиглан байгалийн нөөцийн зураглал хийх, эсвэл ойн хэмжээ буурч буй асуудалд нийтийн анхаарлыг татах зэрэгт ашиглаж болно. Арлын болон бусад алслагдсан бүс нутагт МХХТ-ийг ашигласан нэгдсэн төлөвлөлт, удирдлагын систем нь ихээхэн үр дүнтэй байж болно. Тикивики (Tikiwiki) жишээ нь энэ төрлийн санаачилгын нэг юм.



Судалгааны Тикивики GeoCMS- гео орон зайн контентийн удирдлагын систем, Номхон далайн арлын орнууд

Номхон далайн арлын орнуудын гео-шинжлэх ухааны комиссын Тикивики төсөл нь арлын орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлыг бууруулах, нэгдсэн төлөвлөлт, удирдлагын систем байгуулах зорилготой.

МХХТ-ийн хөгжил болон хамаарах чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа нь төслийн Гео-орон зайн контентийн удирдлагын систем хэмээх чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төслийн оролцогч талуудаас газар зүйн мэдээлэл цуглуулан, түгээдэг. Анхлан төсөл эхлэхэд GeoCMS төсөлд тохирох програм хангамж байхгүй тул өргөн хэрэглэдэг хоёр үнэгүй, нээлттэй эхийн програм хангамжуудыг (ҮНЭПХ) ашиглан шинэ програмыг боловсруулсан нь MapServer болон Tikiwiki хэмээх нэртэй програмууд юм. GeoCMS систем нь Номхон далайн арлын орнуудад газар зүйн мэдээллийн системийг түгээх, Интернетээр дамжуулан солилцох боломжийг олгож байжээ. Мөн дэлхийн бусад орнуудаас ч гэсэн шаардлагатай мэдээллийг хүлээн авдаг байна. Энэхүү бүх үйл ажиллагаа нь тухайн улсуудын гамшигт өртөмтгий байдлыг бууруулах, Засгийн газрууд нь цаг тухайд нь бэлтгэсэн, цуглуулсан чухал мэдээллийг авах боломжийг олгож байна.

Эх сурвалж: Adapted from Nah Soo Hoe, Breaking Barriers: The Potential of Free and Open Source Software for Sustainable Human Development - A Compilation of Case Studies from Across the World (Bangkok: UNDP), <http://www.unapcict.org/ecohub/resources/breaking-barriers/> and <http://www.iosn.net/pacific-islands/case-studies/tikiwikigeocms/>; and Tikiwiki Map Server, "Tikiwiki GeoCMS," <http://maps.tikiwiki.org/tiki-index.php>.

ҮНЭПХ нь улс орнууд, бүс нутгуудад сургалтад маш цөөн хамрагдсан боломжит хүмүүсийг ашиглан динамик платформыг бий болгон ашиглах боломжийг олгоно. *ҮНЭПХ-ийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дөрөвдүгээр модуль дээрээс үзнэ үү.*



АСУУЛТУУД

Танай бүс нутагт бодлого боловсруулагч нарт зайн тандан судалгаа болон ГЗМС-ийн ямар мэдээлэл байдаг вэ? Тэдгээрийг хэрхэн ашигладаг вэ?

МХХТ-ийн ижил түвшний мэдлэгийн эх үүсвэр улс болгонд байдаг. Хятадад гэхэд ХИГЗМС буюу Хөдөлгөөнт интерактив газар зүйн мэдээллийн системийг (MIGIS) Орон нутгийн оролцооны үнэлгээтэй хослуулан ашиглаж орон нутгийн хамгийн шилдэг мэдлэг, шинжлэх ухааны мэдээллийг нэгтгэх замаар орон нутгийн түвшинд байгалийн нөөцийн төлөвлөлт, ашиглалтыг оновчтой болгодог. ХИГЗМС нь оролцооны аргаар хийгдсэн суралцах болон үйл ажиллагаа явуулахтай холбоотой мэдээллийг тоон форматын график мэдээлэл болгон хөрвүүлдэг.³⁸

38. Barbara Fillip, Information and Communication Technologies for Development Self-Paced Learning Materials – Module 6: ICTs and Agriculture (Notes), <http://www.knowledgefordevelopment.com/ICT4D03SP/File/Notes6.pdf>.

Хятадын Лоессын тэгш газрыг нөхөн сэргээсэн³⁹ нь олон жилийн туршид учруулсан хор хохирлыг нөхөх зорилгоор хэд хэдэн оролцогч талын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа болжээ. Энэхүү төсөл нь олон янзын МХХТ-ийг ашиглан байгаль орчны хор хохирлыг баримтжуулах болон үүнийг бууруулахын тулд юу хийж болох талаар мэдээлэл цуглуулах, олон нийтийн мэдлэгийг сайжруулах үйл ажиллагааг явуулдаг. Байгаль орчны боловсрол хэвлэл мэдээллийн төслийн захирал Жон Иугын хэлсэнээр:

Лоессын тэгш газрыг нөхөн сэргээхэд гарсан амжилт нь орон нутгийн иргэдэд мөн маш их өөрчлөлтийг гаргасан: тэдний эдийн засаг, орлого, амьдралын чанар нь ихээр сайжирсан. Тухайн бүс нутагт ноёлж байсан экологийн сүйрэл буурч, ядуурлын гинжин хэлхээ тасарсан... сая сая хүмүүс ядлуурлаас гарсан.⁴⁰

Төслийн хамтрагч нарын хийсэн “Эх дэлхийн найдвар” хэмээх кино сүүлийн 10 жилийн туршид гарсан өөрчлөлтүүдийг бүрэн харуулсан байдаг.

Дэлхий нийтийн хөгжлийн үйл ажиллагаанд гамшгийн удирдлагын асуудлыг тусгаар салбар хэмээн үздэггүй. Гамшгийн удирдлага нь тэгш, тогтвортой хөгжилд маш чухал үүрэгтэй. Зарим талаар МХХТ-ийг ашиглан байгалийн нөөцийн зураглал хийх нь МХХТ-ийн гамшгийн удирдлагын үүрэг рольтой нягт холбогдох ба урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах болон нөхөн сэргээх зэрэг бүх шатанд нь уялдаа холбоотой. ГЗМС-ийг ашиглан гамшгийг урьдчилан таамаглах, хямралын үеэр чухал сүлжээг байгуулах зэрэг дээр ашиглаж болно. Гамшиг болохоос өмнө ГЗМС болон зайн тандан судалгааны мэдээллийг ашиглан эрсдэл өндөртэй газруудыг тогтоон, урьдчилан мэдээлэх системийг бий болгон ажиллуулж болно. Радио, телевиз, гар болон сансарын утас, сонирхогчийн радио станцууд, богино тэмдэгт мэдээний үйлчилгээ (SMS), и-мэйл, Интернет нь олон нийтэд гамшгийн талаар мэдээлэхэд ихээхэн чухал үүрэгтэй. Гамшгийн үеэр суурин утасны систем гэмтдэг тул энэ үеэр бусад боломжит системүүд нь ихээхэн хэрэгцээтэй байдаг.

Ваттегама⁴¹ нь урьдчилан мэдээлэх систем Ази, Номхон далайн бүсийн хэмжээний МХХТ-ийн өргөн хүрээний хэрэглээнүүдийг бий болгон, урьдчилан мэдээлэх систем, гамшгийн аюулыг бууруулах, нөхөн сэргээхэд чиглэн үйл ажиллагаа явуулж байна. Гэхдээ эдгээр үйл ажиллагааны ихэнх нь боловсруулах шатандаа байгаа билээ. Гэхдээ 2004 оны цунамигийн дараа урьдчилан мэдээлэх системийг ашиглах нь ихээхэн ач холбогдолтой гэдгийг ойлгох болжээ. (Доорх кейс судалгааг үзнэ үү). Гунавардена болон Норонна нарын бичсэн Гамшгийн үеийн харилцаа холбоо (Communicating disasters)⁴² хэмээх ном нь гамшгийн аюулыг бууруулах болон сэргээн босгоход МХХТ-ийг хэрхэн ашиглаж болохыг тун дэлгэрэнгүй тусгасан байдаг.

39. John D. Liu. Environment Challenges Facing China: Rehabilitation of the Loess Plateau (2005), http://www.unep.org/pcmu/project_reference/docs/BB_170707Large_scale_ecosystem_restoration_JPMorgan_Essay_2005.pdf.

40. Ibid., 6.

41. Chanuka Wattegama, ICT for Disaster Management (Bangkok: UNDP and Republic of Korea: UN-APCICT, 2007), <http://www.unapcict.org/ecohub/resources/ict-for-disaster-management>.

42. Nalaka Gunawardene and Frederick Noronha, eds., Communicating Disasters: An Asia Pacific Resource Book (Bangkok: UNDP and Nugegoda: Tve Asia Pacific, 2007), <http://www.apdip.net/publications/CommunicatingDisasters.pdf>.



Зүүн-Өмнөд Азид цунамиг урьдчилан мэдээлэх систем

Цунамиг урьдчилан мэдээлэх систем нь Зүүн-Өмнөд Азийн хэд хэдэн орон хамтарсан систем бөгөөд “мэдээллийн нийгэм, технологийн бүрэлдэхүүн хэсгийг хамарсан урьдчилан мэдээлэх систем бий болгох, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг бэлэн байдал, урьдчилан сэргийлэлт, аюулыг бууруулах, хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаагаар хангах” зорилготой юм. Эдгээр орны тоонд Кампучи, Хятад, Лаос, Мьянмар, Филиппин, Тайланд, Вьетнам зэрэг улс хамрагдаж байна.

Энэхүү систем нь Азийн бүх жижиг орнууд нэгдэн нийлж энэхүү санаачилгыг АНУ-ын ОУХА, НҮБХХ, ДАНИДА зэрэг олон улсын хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжүүлж буйгаараа онцлог юм. Азийн гамшгийн бэлэн байдлын төв (АГББТ) хэмээх ашгийн бус байгууллага нь Ази тивийн хэмжээнд аюулгүй, тогтвортой орчин бий болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бөгөөд тус хөтөлбөрийн бүсийн төвийн үүргийг гүйцэтгэж байна.

АГББТ нь гамшгийн эрсдлийн удирдлагын төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, техникийн туслалцаа болон мэргэжлийн үйлчилгээг үндэсний хэмжээний гамшгийн удирдлагын төлөвлөгөө, бодлогод хангах, гамшгийн удирдлагын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг явуулах, бүрэн хэмжээний гамшгийн эрсдлийн удирдлагын хөтөлбөр боловсруулах, гамшгийн дараах үнэлгээ хийх, нийгмийн эрүүл мэнд болон онцгой байдлын үеийн удирдлага, газар ашиглалтын төлөвлөлт, гамшигт тэсвэртэй барилга, яаралтай хариу арга хэмжээний төлөвлөлт, сэргээн босгох зэрэг олон үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.

Эх сурвалж: Adapted from Chanuka Wattedgama, ICT for Disaster Management (Bangkok: UNDP and Republic of Korea: UN-APCICT, 2007), 18-20, <http://www.unapcict.org/ecohub/resources/ict-for-disaster-management>.

Унших материалууд: Asian Disaster Preparedness Centre, “Early Warning System,” <http://www.adpc.net/v2007/Programs/EWS/Default.asp>; and United Nations International Strategy for Disaster Reduction, “Platform for the Promotion of Early Warning,” <http://www.unisdr.org/ppew/tsunami/project-overview/dp-introduction.htm>.

ДАСГАЛ



Танай улс болон бүс нутагт ямар агентлаг гамшгийн бэлэн байдал, гамшгийн хор уршгийг арилгах болон бууруулах чиглэлээр МХХТ-ийг ашигладаг вэ? Тухайн агентлаг яаж хийдэг талаар товч хэлэлц.

Гамшгийн мэдээлэх систем нь зөвхөн нэг улсад дангаараа байх албагүй. Хуй салхи, газар хөдөлт, цунами зэрэг байгалийн гамшиг нь газар зүйн бүсийг бүхэлд нь хамардаг. Байгаль орчны гамшиг болох газрын тос асгах, цөмийн бохирдол (ялангуяа Номхон далайн өмнөд хэсэгт), эрүүл мэндийн гамшиг болох шувууны ханиад нь нэг улсад бүхэл бүс нутгийг хамардаг. Тиймээс хамтын ажиллагаа нь хамгийн гол амжилтын түлхүүр бөгөөд дээрхийн адил олон улсыг хамарсан урьдчилан мэдээлэх систем нь ихээхэн үр дүнтэй байх боломжийг хангадаг. Sentinel Asia⁴³ нь Ази, Номхон далайн бүсийн гамшгийн удирдлагын дэмжих бүлэг бөгөөд эгнээндээ нийт 18 улсын 51 байгууллагыг, мөн 7 олон улсын байгууллагыг нэгтгэсэн цахим платформоор дамжуулан мэдээлэл хуваалцах зорилго бүхий сайн дурын үндсэн дээр нэгдэн, шилдэг туршлагаа хуваалцах үүрэг бүхий байгууллага билээ.

43. Masahiko Honzawa, “Sentinel Asia: Asia Branch Activities,” Japan Aerospace Exploration Agency, <http://unpan1.un.org/intra-doc/groups/public/documents/APCITY/UNPAN025931.pdf>.

Гамшгийн үр дагаврыг арилгах чиглэлээр МХХТ-ийг ашиглах өөр бусад төрлийн хүчин чармайлт гарсаар байгаа юм. Гэхдээ МХХТ-ийг ашиглах ихэнх хүчин чармайлт нь технологиос тэр бүр хамааралтай бус бөгөөд хэрэглээний хувьд хүний хүчин зүйлийн нөлөө л үүнийг амжилттай хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлно. МХХТ-ийг ядуурлыг бууруулах стратегид, байгалийн нөөцийн зураглалд тусгасан цогц бүтэц шаардлагатай буй ба энэ нь ядууст өсөлтийг авчран, тогтвортой хөгжлийг хангах билээ. Фермерүүд, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, нэвтрүүлэх төвүүд, санхүүгийн байгууллагууд болон МХХТ-ийн хөгжүүлэгч нарын дунд нягт холбоо, түншлэл үүссэн тохиолдолд хүнсний баталгаат байдал болон тогтвортой хөгжлийн чиглэлийн МХЗ биелэгдэх боломжтой болно. Энэхүү нягт холбоонд аль нэг тал нь байхгүй байх, оролцохгүй байх тохиолдолд нийт үйл явц нь бүх ажлыг үр дүнгүй болгоход хүргэж болзошгүй. МХХТ нь дангаараа амжилт бий болгож чадахгүй, харин үүнийг дагалдан, дэмжих олон төрлийн хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжин, ядуусын дэмжлэгийг хүлээн хэрэгжиж байх ёстой.

ДҮГНЭЛТ

- МХХТ-д суурилсан зайн тандан судалгаа, гамшгийн урьдчилан мэдээлэх нь бидний цаг агаар, уур амьсгалын талаарх ойлголтыг өөрчилсөн.
- Ядуус, эмзэг бүлгийнхнийг ихээр нэрвэдэг учраас гамшгийн удирдлага нь ямар ч улсад ихээхэн чухал бөгөөд энэхүү үйл ажиллагааг олон төрлийн хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжиж, дэмжиж ядуусын дэмжлэгэд тулгаарлан хийж байх ёстой.



ДАСГАЛ

Танай оронд ашиглаж буй эсвэл шинээр боловсруулсан МХХТ-т суурилсан байгалийн нөөцийн удирдлагын эсвэл гамшгийн удирдлагын нэг системийг тодорхойл. Системийг нарийвчлан хэлэлцэж, энэхүү систем нь ядуусыг хэрхэн хамардаг, харгалздаг талаар тодорхойл. Хэрэв тусгайлан харгалзан үздэггүй бол ямар өөрчлөлтийг хийх шаардлагатай болохыг тогтоо.

3.6 МХХТ БОЛОН ЗАСАГЛАЛ, ЗАСГИЙН ГАЗАР

Модуль 3 нь цахим засаг болон цахим засаглалын талаар тайлбарласан бол Модуль 2 нь МХХТ-ийн дэд бүтэц болон үйлчилгээний засаглал дээр голлон төвлөрч байна. Тийм учраас энэхүү модуль дээр уншигч та бүхэнд засаглалын болон үүнийг хэрэгжүүлэхэд МХХТ-ийг хэрхэн хэрэглэх талаар товч мэдээллийг хүргэх юм.

Төр засаг нь дүрэм журам, шийдвэр гаргаж үүнийг хэрэгжүүлэх супер бүтэцтэй байдаг энэ нь үйл ажиллагааны гол гарц, үр дүн болдог. Төр засгийн ажлын үйл явц нь ажилтнууд, салбар, ажилтнууд байгууллагууд болон агентлагуудын дунд явагдах олон тооны дотоодын үйл явц бүхий байдаг бөгөөд гаргасан шийдвэр нь олон нийтэд хүрч, өөрийн үр нөлөөгөө үзүүлж эхлэхээс өмнө маш их үйл явц, шат дараалал байдаг. Засаглал нь Засгийн газар болон иргэний хоорондын харилцааг хэлэх ба ийм учраас маш олон арга замаар явагддаг үйл явц байдаг. Засаглал нь гүйцэтгэх үүрэг, үйл явц, зорилго, гүйцэтгэл болон зохицуулалтаас бүрдэх ба эдгээр нь иргэд болон Засгийн газрын хоорондын үйл явц байдлаар ил харагдахуйц байдаг.

Олон тооны судалгаа засаглал болон өсөлтийн хоорондын эерэг корреляцийг батлан гаргасан байдаг. Кауфман болон Краай нар⁴⁴ “нэг хүнд ноогдох орлого болон засаглалын чанар нь улс болгонд ямар корреляц хамааралтай буйг” харуулсан байдаг. Ихэнх олон улсын хандивлагч байгууллага болон хөгжиж буй орнуудын Засгийн газар нь тогтвортой, ардчилсан засаглал, удирдлага сайтай төрийн байгууллагууд нь ядуурлыг бууруулж, ядуусын амьжиргааг сайжруулахад ихээхэн чухал болохыг сайтар ойлгох болжээ. Сайн засаглал болон өндөр хэмжээний хөрөнгө оруулалт, өсөлтийн өндөр хувь, эдийн засгийн үр дүнтэй үйл ажиллагаа, насанд хүрэгсэдийн бичиг үсгийн өндөр боловсрол, авлигыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах зэрэг бүгд харилцан уялдаатай болохыг харуулсан нотолгоо олон бий. Гэхдээ сайн үйл ажиллагаатай, чадавхитай төр нь дангаараа төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд нийцтэл сайн хүргэж чадахгүй, харин өөрөө хариуцлагатай, иргэддээ эргэн тайлагнадаг байх ёстой хэмээн илүү ихээр үзэх болсон.

Төрөөс төр (G2G), төрөөс бизнес (G2B) болон төрөөс иргэн (G2C) гэсэн холбоо нь МХХТ-ийг засаглалын чиглэлд хэрэглэх хэрэглээний гол ноён нуруу болдог. Үүний гол санаа нь Засгийн газрыг илүү үр дүнтэй, хэмнэлттэй ажилладаг, үйлчилгээг үр дүнтэйгээр хүргэдэг болгохын зэрэгцээ (цахим засаг буюу e-government) илүү нээлттэй, хариуцлагатай, иргэдийн оролцоотой, ардчилсан болгох явдал билээ. Цахим засаг болон цахим засаглал гэсэн үгсийг ихэнхдээ хольж, бие биенийг нь орлуулсан байдлаар ашигладаг тул зарим тохиолдолд эргэлзээнд хүргэх нь бий. Засаглал нь Засгийн газар болон иргэдийн хоорондын харилцааг тусгасан илүү өргөн хүрээний үйл ажиллагааг илэрхийлэх бол засаг гэсэн үг нь төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, иргэдэд боловсрол, эрүүл мэнд, татвар, газар зохион байгуулалт гэх мэтийн үйлчилгээг үзүүлэх үйл явцыг хэлнэ. Засгийн газар нь тухайн системийг үр дүнтэй ажиллуулах үүрэг бүхий албан ёсны аппарат бол засаглал нь үйлчилгээг хүлээн авч буй иргэдэд хүрч буй үр нөлөөг хэлнэ. Цахим засаг нь сайн хэрэгжүүлж, удирдсан тохиолдолд Засгийн газрыг илүү үр дүнтэйгээр ажиллуулах аргачлал байдлаар байх бол цахим засаглал нь зохистой зарчим, зорилтууд, хөтөлбөр болон бүтэцтэйгээр дэмжин өгсөн тохиолдолд оролцоот засаглал хэмээх утгыг агуулна.⁴⁵

Ази, Номхон далайн бүсийн зарим орнууд жишээ нь Хонгконг, Япон, БНСУ болон Сингапур нь цахим бэлэн байдлын индексээр ихээхэн өндөрт орж, цахим засаглалын механизмууд бүрдсэн байдаг. Эдгээр орнуудад төрийн ажлын ихэнх хэсэг нь цахим хэлбэрээр явагддаг. Гэхдээ бус нутгийн бусад ихэнх орон цахим бэлэн байдлын индексээр доогуур, цөөн тооны төрийн үйлчилгээ л компьютержсэн байдаг⁴⁶. Ази, Номхон далайн бүсийн цахим засаглалын талаарх 20 орчим кейс судалгааг хянан үзсэний дараа доорх дүгнэлтэд хүрчээ:

44. Daniel Kaufmann and Aart Kraay, *Governance and Growth: Causality which way? - Evidence for the World*, in brief (Washington, D.C.: World Bank Institute, 2003), 1, http://www.worldbank.org/wbi/governance/pdf/growthgov_synth.pdf.

45. Thomas B. Riley, *E-Government vs. E-Governance: Examining the Differences in a Changing Public Sector Climate*, International Tracking Survey Report '03, Number Four (London: Commonwealth Secretariat, 2003), http://www.rileyis.com/publications/research_papers/tracking03/IntlTrackRptMay03no4.pdf.

46. Subhash Bhatnagar, *Paving the Road towards Pro-poor e-Governance: Findings and Observations from Asia-Pacific Case Studies* (Bangkok: UNDP, 2006), 1, <http://www.apdip.net/projects/e-government/capblg/casestudies/Overview.pdf>.

Ихэнх МХХТ-ийн хэрэглээ нь үйлчилгээний хүргэлт дээр бус харин дотоод үйл ажиллагаанд төвлөрч байна. Цэвэр үйлчилгээн дээр төвлөрсөн цөөн тооны төсөл нь ихэнхдээ тусгай зөвшөөрөл болон татварын чиглэлээр байгаа билээ. Хэрэглээний дийлэнх хэсэг нь хот суурин газарт төвлөрсөн байна. Ядуу иргэдийн хэрэгцээнд тусгайлан чиглэсэн үйл ажиллагаа цөөн байна.

Энэтхэг зэрэг улсын зарим мужуудад үйлчилгээг цахим байдлаар хүргэхэд ихэнх амжилт гаргасан баядууст зориулан цахим засаглалын үйлчилгээг хүргэхэд дараах зүйлс дээр сорилтуудтай тулгарч байна: а) ядууст хандсан үйл ажиллагаа явуулах зорилтууд тодорхой бус, б) орон нутагт төрийн үйлчилгээг хүргэх, в) стандартчилал болон нутагшуулалтыг тэнцвэржүүлэх, г) орон нутагт үйлчлэхийн тулд хувийн хэвшлийг идэвхжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох, [болон] д) бие даасан нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх. Түүнчлэн цахим засаглалын төслийн үзэл баримтлалыг гаргах болон хэрэгжүүлэхэд дотоодын чадавхи тааруу байна⁴⁷.

Цахим засгийн үйлчилгээг хүргэх нийтлэг загвар нь порталаар дамжуулах явдал хэдий ч ийм төрлийн олон порталыг өнгөц судлан үзэхэд мэдээллийн зөвхөн нэг чиглэлийн урсгалтай, интерактив байдал огт хангагдаагүй байна. Энэтхэгээс бусад өөр хэд хэдэн орон нийтлэг үйлчилгээний төвүүдийг хот сууринд байгуулсан ба эдгээрт онлайн терминал дээр ажиллаж буй оператор нь хэрэглэгчдэд үйлчилгээг хүргэдэг байна. Энэтхэгт нэвтрүүлсэн зарим үйлчилгээнээс хөдөө орон нутгийн ядуус ч гэсэн эдгээрийг ашиглан, үр дүнг нь хүртэх боломжтой байна. Эдгээр үйлчилгээнүүдээс хамгийн их алдартай нь Компьютержсэн бүртгэлийн алба, Бхооми (Bhoomi) болон e-Seva зэрэг багтаж байна. Азийн хөгжиж буй ертөнцийн өөр нэгэн хэсэг болох Монголын Засгийн газар ч гэсэн иргэд татвараа төлөх үйл ажиллагааг хялбарчилсан МХХТ-ийн хэрэглээг нэвтрүүлэхэд дэвшил гаргасан байна.



Монголын татварын алба онлайн болсон нь

Монголын татварын албаны вебсайт (<http://www.mta.mn>) нь зөвхөн тухайн албаны талаарх мэдээллийг агуулаад зогсохгүй иргэд, байгууллагуудад зориулсан үйлчилгээний урт жагсаалттай байгаа. Эдгээрийн дотор татаж авах боломжтой (өмнө нь онлайн байгаагүй тул татварын албадаас авдаг байсан) татварын хүснэгт, баримтууд байгаа. Бизнес эрхлэгчид болон хувь хүмүүс эдгээрийг вебсайтаас татан авч, бөглөөд, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд хүргэн өгдөг байна. Энэ нь Монголын татварын албанд МХХТ-ийг ашигласан томоохон алхам болсон юм.

Гэхдээ одоогоор зөвхөн Интернеттэй хүмүүс л энэхүү үйлчилгээг ашиглан, үр дүнг нь хүртэх боломжтой байгаа юм. 2003 онд хийгдсэн судалгаагаар Монгол улсад 50,000 гаруй Интернет ашиглагч байгаа нь хүн амын 4%-ийг л эзэлж байна. Энэхүү төсөл нь өмнөө тавьсан ихэнх зорилгоо биелүүлсэн ч, эмзэг бүлгийнхэнд хүрэх, үр дүнг хүртэгч нартай интерфэйс үүсгэх, олон нийтийн оролцоог хангах, ажиллах хүчийг хадгалах болон байгууллагын хандлагыг өөрчлөх зэрэг дээр тодорхой асуудлууд тулгарсаар байна.

Эх сурвалж: Adapted from Mongolian Taxation Authority, <http://www.mta.mn>.

47. Ibid., 2.

Монголын татварын албатай адил цахим засгийн систем нь төр болон иргэдийн хувьд зардал бууруулах, татвар хураалтыг сайжруулах, төрийн байгууллагын ид тод байдлыг сайжруулах зэрэг ач холбогдолтой. Гэхдээ Монголын энэхүү жишээний хувьд ядууст хүрэх тал дээр асуудлууд тулгарч буй нь харагдаж байна. Эдгээрийн тоонд дэд бүтэц, холболт муу, хэлний ялгаа болон бичиг үсэгт тайлагдсан байдал, төрийн байгууллагын хүн хүчний хомсдол, бага эрэлт, дээрээс доош чиглэсэн төлөвлөлт болон үр дүнтэй хяналт-шинжилгээ болон үнэлгээ дутагдалтай байгаа зэрэг багтаж байна.



ДАСГАЛ

Засгийн газрын хоёр порталыг (танай улсад буй нэгийг багтаана) үүнд буй боломжит сул тал буюу асуудалтай хэсгүүдийг тогтоон, үүнд таарах шийдлийг санал болго.

Ази, Номхон далайн бүсийн бусад цахим засгийн хэрэглээ нь төлөвлөлт болон хэрэгжилтийн үе шатандаа байна. Кампучи улсад Төрийн захиргааны мэдээллийн системийг бий болгон үүгээр дамжуулан газар болон автомашины бүртгэл, цахим зөвшөөрлийн систем, төрийн захиргааны үйлчилгээ зэргийг хэрэгжүүлсэнээр тус улс Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоонд (ASEAN) элссэнээс болж алдсан орлогыг нөхөн олох зорилгоор ажиллуулж байна. Орлого олох зорилго биелэгдсэн ч цахим зөвшөөрлийн системээр дамжуулан төрийн захиргааны үйл явцыг сайжруулах зорилго хараахан биелээгүй байна.

Хятад, Тайланд⁴⁸ улсуудад эмзэг бүлгийнхэн болон ядуусын хэрэгцээнд нийцэх цахим засгийн хөтөлбөрүүдийг боловсруулах алхмууд хийгдсэн ч гарч буй үр дүн нь өөр өөр байна. Тайландын хөдөө орон нутагт цахим худалдааг хөгжүүлэх зорилгоор хийгдсэн ОТОР хэмээх санаачилга нь бараа, бүтээгдэхүүнийг зах зээл рүү тээвэрлэх тоног төхөөрөмж дутагдалтай байснаас амжилтад хүрээгүй байна. Энэхүү жишээ нь МХХТ-ийн үр дүнг хүртэхийн тулд дэмжих үйл ажиллагаа шаардлагатай болохыг харуулж байна. Хятад улсад нүүдлийн ажилчидтай ярилцлага хийх видео конференцийн технологийг нэвтрүүлсэн нь ядуусын хувьд зардал хэмнэсэн шинэлэг санаа байлаа. Энэхүү хэрэглээ нь технологийн бус харин нийгмийн асуудлыг тэргүүлэх зорилгоо болгосон учраас амжилттай болжээ.

Дээр товч дурдсан цахим засгийн хэрэглээ нь төрөөс иргэнд хандсан үйл ажиллагааны жишээ бөгөөд нийлүүлэлтийн тал дээр нь төвлөрсөн байна. Цахим засаглал нь эрэлтийн тал дээр суурилдаг. Цахим засаглалын үзэл баримтлалын талаар судалж эхлэхийн өмнө энэхүү онцлог шинжийг сайтар ойлгох нь чухал юм.

Цахим засаглал нь авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. Жишээ нь цахим санал хураалт нь сонгуультай холбоотой асуудлуудыг шийднэ. Төрийн бүх үйл явц нь онлайн байдлаар хэрэгжиж эхлэхэд хэвлэл мэдээлэл, иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд төрийн үйл ажиллагааг хянах илүү боломжтой болно.

Цахим худалдан авалт нь МХХТ нь хэрхэн засаглалыг сайжруулж болохын нэгэн жишээ юм. Автомат худалдан авалтын системийг нэвтрүүлэх нь тендерийн үйл явцыг стандартчилах, хэмнэлт гаргах, хүнд суртлыг бууруулах, худалдан авалтын үйл явцын ил тод болгох зэрэг үр дүнтэй. Нийлүүлэгч болон худалдан авагч тендерийн өмнө болон дараах үе шатуудад шууд харьцах байдлыг таслан, тендерийн материалыг хүлээн авах, үнэлэх үйл явцын объектив байдлыг ханган, авлигын боломжийг бууруулдаг. Ил тод байдлыг баталгаажуулахын тулд бүх мэдээллийг агуулсан тендерийн баримт бичгүүдийг вебсайт дээр байрлуулан, сонирхсон хэн боловч үүнийг үнэ төлбөргүй татан авах боломжтой байдаг. Тендерийн үйл явцын аль ч үед санал гаргагч этгээд нь

48. Ibid.

шаардлагатай мэдээлэл авах тэр дундаа өрсөлдөх буй нийлүүлэгч нарын нэр болон бусад мэдээлэл, үнийн санал болон үнэлгээний дүн зэргийг авах эрхтэй байдаг.

Цахим засаглал нь олон нийт төрийн үйл ажиллагаанд оролцох бусад хэлбэрүүдийг бий болгож байдаг. Төрийн байгууллагуудын вебсайтууд, порталууд нь иргэдэд зориулан тодорхой үйлчилгээтэй холбоотой тэдний эрхийн талаар мэдээлэл тавьж болно. Вебсайтууд нь тодорхой асуудлаар онлайн хэлэлцүүлэг, санал хураалт явуулах зэргээр шийдвэр гаргалтыг илүү оролцооны шинж чанартай болгодог. Вебсайтууд нь мөн иргэдийн санал бодлыг тандах, тэдний асуудлуудад илүү бүтээлчээр хандах боломжийг олгоно. Харин иргэд төрийн байгууллагын ажлалтнуудтай харилцах замаар тулгараад буй асуудалд тэдний анхаарлыг хандуулах, түргэн хариу авах болон иргэдийн тайлангийн карт болон нийгмийн аудит зэрэг аргачлалуудыг боловсруулан төрийн байгууллагууд хэр үр дүнтэй ажиллаж байгаад үнэлгээ хийж болно. Эдгээр бүх үйл ажиллагааг бага зардлаар, өндөр үр дүнтэйгээр хийх боломжтой. Зохистой мэдээллийн дэд бүтцийг хямд зардлаар ашигласнаар (жишээ нь олон нийтийн теле-төвүүд гэх мэт), төрийн байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны үр дүнг ядуусд хүргэж чадна.

Төрийн үр дүнтэй, зардал багатай, тогтвортой үйл ажиллагаа нь тайван, тогтуун байдал, иргэдийн оролцоог хангаж, тухайн улсууд нь МХЗ-уудад хүрэхэд илүү үр дүнтэй байхыг баталгаажуулна.

ДҮГНЭЛТ

- Төр засаг нь албан ёсны бүтцээс тогтдог бол засаглал нь үйл ажиллагааны үр дүнг хэлнэ.
- МХХТ-ийн үйл ажиллагааг төр, засгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийн зорилго нь үр нөлөөг хангаж, иргэдэд ээлтэй үйлчилгээг үзүүлж, иргэдийн оролцоог идэвхжүүлдэг.
- МХХТ-ийн үйл ажиллагааг төр, засгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх нь үйл явцыг ил тод болгож, төрийн ажилтнуудтай ямар нэгэн байдлаар хууль бусаар холбогдох (жишээ нь хээл хахууль) боломжийг хааснаар авлигын түвшинг бууруулах ач холбогдолтой.



ДАСГАЛ

1. <http://www.esevaonline.com> хаягаар орж Энэтхэгийн Андхра Прадеш мужийн шинэлэг цахим засаг үйлчилгээг хэрхэн танай оронд нэвтрүүлж болох талаар судал.
2. Өөрийн орны цахим засгийн санаачилгаас нэгийг сонгон авч үүний давуу болон сул талуудыг хэлэлцэж, сул талуудыг засварлах саналыг боловсруулан гарга.

3.7 МХХТ БОЛОН ЭНХ ТАЙВАН

Энх амгалан байдалгүйгээр хөгжил байхгүй нь ойлгомжтой. Хөгжил, цэцэглэл нь орон нутгийн нөхцөл байдал тайван, тогтвортой үед л бий болох боломжтой. Мөргөлдөөнтэй байгаа бүс нутаг нь хөгжлийн доогуур түвшинтэй байдаг. Улс орнууд болон олон улсын байгууллагуудын бүтээсэн олон арван жилийн хөгжил мөргөлдөөнөөс үүдэн долоо хоногийн дотор л алга болж болно. Мөргөлдөөнөөс сэргийлэх эсвэл энх тайвныг тогтооход оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж нь тухайн улсыг мөргөлдөөний дараа сэргээн босгох, энхийг тогтооход оруулах хөрөнгөний үр өгөөжтэй харьцуулбал хамаагүй өндөр байх нь ойлгомжтой.

ICT4Peace⁴⁹ (Энхийн төлөө МХХТ) гэдэг нь өнөө үед шинээр гарч ирж буй нэгэн салбар юм. Энэ нь мөргөлдөөнөөс сэргийлэх, удирдах, энхийг тогтоох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үеийн туслалцаа, мөргөлдөөний дараа энхийг тогтоох, сэргээн босгох зэрэгт МХХТ-ийн дэмжлэгтэй олон төрлийн үйл ажиллагааг үүнд хамруулан авч үздэг. Эдгээрийн зарим жишээг доор товч дурдлаа.

ReliefWeb⁵⁰ нь НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах албаны⁵¹ (ОСНА) эрхлэн явуулдаг хүмүүнлэгийн төв сүлжээ (hub) юм. Энэхүү вебсайт нь тогтсон контент агуулга бүхий “Web feed” буюу веб хангалтыг хамтрагч талуудын вебсайтад зориулан эрхлэн явуулдаг бөгөөд хэрэглэгчид нь өөрсдийн тодорхой сонирхол бүхий материалыг удирдах нууц үгээр хамгаалагдсан хэсгийг (profile) нээж болдог. Энэ веб нь өдөр тутам 2,000 гаруй эх үүсвэрээс авсан 150 газрын зураг болон баримт бичгийг нийтэлдэг бөгөөд цагийн гурван бүсэд өөрийн оффисыг ажиллуулан байнгын ажиллагааг хангаж байна.

Alertnet⁵² нь Ройтерс сангийн төсөл бөгөөд цаашид тулгарч болох онцгой нөхцлүүдийн үеэр яаралтай хүмүүнлэгийн үйл ажиллагаа, урьдчилан мэдээлэх үйл явцыг хангах зорилготой. Жишээ нь өөрийн мэдээ, гамшгийн талаарх фото мэдээлэл, тусламжийн агентлагт зориулсан мэдээ зэрэг өөрийн үйлчилгээгээр дамжуулан цаг тухайд нь, найдвартай, хэрэгцээт мэдээллийг тусламжийн байгууллагуудад хүргэн, үйл ажиллагаа явуулах боломжийг нь ханган өгдөг.

Governance Out of a Box (GooB) буюу Хязгаарлагдмал бус засаглал санаачилга⁵³ нь МХХТ-ийг мөргөлдөөний дараах сэргээн босголтод хэрхэн ашиглаж болохыг харуулсан жишээ билээ. GooB төсөл нь сэргээн босголтод тулгарах асуудлуудыг шийдэх шинэ хандлага, арга замуудыг боловсруулах зорилготой. Төслөөр хийгдэж буй үйл ажиллагааны тоонд хямралтай орнуудын захиргааны үйл явцыг хэрхэн түргэн хугацаанд сэргээн босгох, иргэдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлж эхлүүлэх талаарх багц аргачлал боловсруулах үйл ажиллагаа багтана. Эдгээр аргачлалуудыг нь тухайн мөргөлдөөнтэй болон дөнгөж зогссон орнуудад буй олон улсын байгууллагууд голлон хэрэгжүүлдэг. Багц аргачлал нь төрийн захиргааны үйл ажиллагааг сайжруулах, сэргээн эхлүүлэхэд ихээхэн дэмжлэг болдог. Боловсруулсан аргачлалууд нь стандарт байх ба үүний зэрэгцээ уян хатан байж, нөхцөл байдалд тохирох боломжтой байх ёстой.

Мөргөлдөөний дараах сэргээн босголтын үйл ажиллагаанд МХХТ нь гал зогсоох нөхцлийг түгээх, сэргээн босголтын үйл ажиллагааны талаарх нөхцөл байдлыг тодруулах зэрэгт ашиглагдаж болно. Мөн цэргийн гэмт хэрэгтнүүдийн шүүх ажиллагааны талаар мэдээлэх, хууль сахиулахад шаардлагатай зайлшгүй чухал үйл явцын талаар нийтлэг ойлголт бий

49. This section is drawn from the publication: Daniel Stauffacher, William Drake, Paul Currion and Julia Steinberge, Information and Communication Technology for Peace: The Role of ICT in Preventing, Responding to and Recovering from Conflict (New York: United Nations ICT Task Force, 2005), <http://www.unicttaskforce.org/perl/documents.pl?id=1571>.

50. See “ReliefWeb,” OCHA, <http://www.reliefweb.int>.

51. See OCHA, <http://ochaonline.un.org>.

52. See “Alertnet,” Reuters Foundation, <http://www.alertnet.org>.

53. “Crisis Management Programme: Governance Out of a Box,” Crisis Management Initiative, http://www.cmi.fi/?content=cpcr_programme.

болгоход мөн ашиглах боломжтой.

Эв нэгдэлд хүрэхийг дэмжсэн МХХТ-ийн оролцоотой кампанит ажил нь улс төрийн лидерүүдэд нөлөөлж, мэдээлэл солилцоог дэмжиж, иргэдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг ач тустай. Төгсгөлийн дүн шинжилгээ болгон хэлэхэд хүмүүс хоорондын харилцан яриа, хэлэлцүүлгүүдийг бий болгож, итгэлцлийг бий болгон, иргэдийн энхийг тогтоох үйл ажиллагааг гүйцэтгэх боломжийг ханган өгөх юм.

ДҮГНЭЛТ

- МХХТ-ийг энх тайван тогтоох, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, том, жижиг хэмжээний мөргөлдөөний үр дагаварыг бууруулахад ашиглаж болно.



ДАСГАЛ

1. Хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохицуулах албаны вебсайтад орж үүний зорилтот бүлэг нь хэн болохыг тогтоо. Вебсайт нь ямар зорилготой байна вэ? Энэхүү вебсайт нь энхийг тогтооход хэр үр дүнтэй гэж та үзэж байна вэ?
2. Танай орон эсвэл өөр улс дахь зэвсэгт мөргөлдөөний талаарх мэдээллийг ол. Тухайн мөргөлдөөний талаар дэлгэрэнгүй тодорхойл (юунаас болсон, хэзээ, хаана эхэлсэн, хэн оролцож буй, ямар нөлөө үзүүлж буй гэх мэт). Дараагаар нь МХХТ-ийг хэрхэн ашиглаж энэхүү мөргөлдөөнийг шийдэж болох, нөлөөг нь хэрхэн бууруулж болох талаар санал зөвлөмж гарга. МХХТ-ийн оролцоог тогтоохдоо тун тодорхой дурдана уу (жишээ нь ямар технологи болон технологийн хослолыг ашиглах, хэрхэн ашиглах, хэн оролцох болон зорилго юу болох гэх мэт).

Энэ бүлэг дээр Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн хэрэгцээ шаардлагуудад нийцүүлэн МХХТ-ийг хэрхэн ашиглаж болох талаар дурдлаа. Хэдийгээр салбар бүрээр нь авч үзсэн ч гэсэн МХХТ-ийг МХЗ-уудад хүрэхийн тулд ашиглахдаа илүү нэгдмэл хандлагаар хандах хэрэгтэйг анхаарна уу. Учир нь хөгжлийн үйл явцад нэг салбарт гарсан алдаа нь нөгөө салбарууддаа нөлөөлдөг (жишээ нь боловсролын салбарт амжилтгүй болоход ядуурлыг бууруулах үйл явц нь амжилтад хүрэхгүй гэх мэт) тул энэхүү хандлага зайлшгүй шаардлагатай. Гэхдээ зарим улсууд МХХТ-ийг хөгжлийн төлөө үр дүнтэйгээр ашиглаж байгаа бол зарим улсад ихээхэн сорилтуудтай тулгараад буй тохиолдол байна. Дараагийн бүлэг дээр эдгээр асуудлуудыг шийдэх арга замуудыг судлах болно.



ӨӨРИЙГӨӨ ШАЛГАХ НЬ

Өөрийн орон дахь хөгжлийн нэг салбарыг сонгон аваад тухайн салбарыг сайжруулах, оновчтой болгох, хөгжлийг нь хурдасган МХЗ-уудад хүрэхийн тулд МХХТ-ийг хэрхэн ашиглаж болох талаар санал зөвлөмж боловсруул. Тухайн салбарыг дэлгэрэнгүй тодорхойлж, бусад салбартай ямар хамааралтай болохыг тогтоо.

Хариугаа бичихдээ өөрийн орны Сангийн яаманд тухайн салбар дахь МХХТ-ийн хэрэглээг тайлбарлаж буй байдлаар бич.

4. МХХТ-ИЙГ ХӨГЖЛИЙН САЛБАРТ АШИГЛАХ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛС

Энэхүү бүлгийн зорилго нь:

- Хөгжлийн төлөөх МХХТ-ийн төсөл, хөтөлбөрүүдийн амжилт, алдааг тодорхойлж буй гол асуудлуудын талаар хэлэлцэх;
- МХХТ болон хөгжлийн хоорондын хамаарлын макро асуудлуудыг хэлэлцэх; болон
- Энэхүү модуль болон бусад модулиудын хоорондын хэлхээ холбоог бий болгох юм.

4.1 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ МХХТ-ИЙН БОДЛОГО

МХХТ-ийн бодлого эсвэл МХХТ-ийн хэрэглээ нь нэгдүгээрт байх уу гэсэн маргаан хаа сайгүй гардаг. Энэ нь өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэгтэй адилхан асуулт юм. Зарим тохиолдолд хэрэглээ нь бодлого боловсруулах арга замыг заадаг бол харин бусад тохиолдолд бодлого, зохицуулалт нь МХХТ-ийн хэрэглээг тодорхойлдог. Энэ талаар нарийвчлан ярилцах нь энэ модулийн зорилго бус ч бодлого болон хэрэглээний аль аль нь шаардлагатай, бодлого, төлөвлөлт болон хэрэгжилт нь тодорхой байх ёстой нь ойлгомжтой. Ази, Номхон далайн орнуудын хувьд тодорхой бодлого нь хамгийн эхний гол үе шат юм. Модуль 2 нь МХХТ-ийн бодлогын үйл явцыг тодорхой тусгасан, Модуль 7 нь МХХТ-ийн төслийн төлөвлөлтийг хамарсан тул энэ модуль дээр МХХТ-ийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд хэрэглэх цар хүрээ болон нөхцөл байдлын талаар ерөнхийлөн судлах юм.

Ихэнх хөгжиж буй орнуудад хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлого нь МТ болон харилцаа холбооны салбарын гол үйл ажиллагаа байдаг⁵⁴. Энэхүү салбарын хамаарах газар, агентлаг нь бизнес болон технологийн асуудлуудад илүү төвлөрөх ба хөгжлийн салбарт тэр болгон хандахгүй байдаг. Зарим оронд МТ болон харилцаа холбооны салбар нь хөгжлийн асуудалд анхаарал хандуулж байгаа ч тэдний хандлага нь хөгжлийн үүднээс бус харин технологи талаасаа байж холболт болон дэд бүтэц, цахим засаглал, цахим түгээлт болон өсөлт дээр түлхүү анхаардагаас иргэдэд төвлөрсөн амьдралын чанарын асуудлыг орхигдуулсан байдаг. Нөгөө талаар хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь үйл ажиллагаандаа хөгжлийн төлөөх МХХТ-ийн технологийн чиглэлийн үйл ажиллагааг багтаагаагүй, багтаасан байсан ч хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлогод үзүүлэх нөлөө нь бага байдаг. Энэхүү нөхцөл байдал алгуур өөрчлөгдөж эхэлж буй ч юуг ойлгох шаардлагатай гэвэл хөгжлийн төлөөх МХХТ-ийн шинэ бодлого нь технологийн болон хөгжлийн асуудал хариуцсан байгууллагуудыг оролцуулан боловсруулагдахгүй бол МХХТ-ийг стратегийн зорилгоор ашиглах үйл явц нь үр дүнгүй болно гэдгийг ухамсарлах шаардлагатай.

Хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлого нь МТ-ийн бодлогоос эрс өөр юм. Энэ нь инженерийн шинжлэх ухаанаас өөр зарчим шаардана. Бодит байдал дээр МХХТ-ийг хөгжлийн чиглэлд ашиглах нь олон салбарын хамаарал, багийн үйл ажиллагааг шаардана. Түншлэл, хамтын ажиллагаа нь хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлого боловсруулах, төлөвлөх болон хэрэгжүүлэхэд амин чухал.

54. Anita Gurumurthy and Parminder Jeet Singh, Political Economy of the Information Society: A Southern View (Montevideo: Instituto del Tercer Mundo, 2005), 18, http://wsispapers.choike.org/papers/eng/itfc_political_economy_is.pdf.

Энэхүү модулийн бүлэг 2.2 дээр технологийн нэгдэн нийлэлтийн талаар МХХТ-ийг хэрэглээг нэмэгдүүлэх гол хүчин зүйл хэмээн дурдсаныг санаж буй байх. МХХТ-ийн нэгдэн нийлэлт гэдэг нь зөвхөн технологи хамтдаа байна гэсэн үг биш. Өнөөдөр энэ нь олон зарчим, арга зам, систем нэгдэж, бодит шинжлэх ухааны (хяналтын онол, системийн онол, статистик гэх мэт) салбар, технологи (компьютерын ухаан, цахилгааны инженер) болон нийгмийн шинжлэх ухаан (удирдлагын онол, социологи, сэтгэл зүйн хэл шинжлэл, эдийн засаг) нэгдэн нийлж буй хэлбэр юм. Тиймээс хөгжлийн ямар нэгэн үйл ажиллагаанд МХХТ-ийг нэвтрүүлэхэд байгууллагын дотор тусдаа функц, хариуцлагуудын бүтэц бүхий их хэмжээний нийгмийн болон соёлын өөрчлөлтийг шаардах юм.

Зэрэгцээ нэгдэн нийлэлт эсвэл үндэсний эвсэл буюу Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийг хамруулсан эвсэл нь МХХТ-ийн хөгжлийн орчны бий болгож буй боломжуудыг гүйцэд ашиглахад чухал шаардлагатай. Засгийн газар нь ээлтэй бодлого, зохицуулалтын орчныг бий болгох, эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх нийтлэг санг хангах, цахим-засаг ажиллуулах, үндэсний чадавхийг бэхжүүлэх, МХХТ-ийг хөгжилд ашиглахыг хүлээн зөвшөөрөх зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Хувийн хэвшил нь МХХТ-ийн дэд бүтэц, үйлчилгээнд хөрөнгө оруулна.

Модуль 8 дээр дэлгэрэнгүй дурдсан төр-хувийн хэвшлийн түншлэл нь олон хэлбэр, төрөлтэй байж болох ба МХХТ-ийн хэрэглээг хөгжүүлэхэд компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд оролцох энгийн оролцооноос эхлээд түлхүүр өгөх нөхцлөөр хүлээлгэн өгөх том төсөл хүртэл байж болно. Ийм төрлийн түншлэлийн үр дүн нь Засгийн газрууд хөрөнгө гаргаж дийлэхээргүй томоохон санхүүгийн болон техникийн дэд бүтцийг хувийн хэвшилд шилжүүлж, хямд зардалтай, хэмнэлттэй технологийг дэлгэрүүлэх боломжийг бий болгоно.

Иргэний нийгэм нь олон нийтийг идэвхжүүлэх, ядуурлыг бууруулахтай холбоотой контент хөгжүүлэх, оролцоог хангах замаар цахим оролцоог бий болгох үүргийг хүлээж болно. Өөриймшүүлэл болон үйл ажиллагаа нь олон нийтэд суурилсан, олон нийт өөриймшүүлсэн болж, ололт амжилтдаа бахархах сэтгэлийг төрүүлж, хөрөнгө оруулалтын өгөөж нь ил, хурдан байна. Ийм төрлийн олон оролцогч талуудын түншлэлийн үед үндэсний эвсэл дэхь оролцогч болгон орон нутгийн түвшинд хамгийн тохиромжтой өөрийн гэсэн загвар, соёлыг бий болгож, ядууст гол үр дүнг хүртээдэг.

МХХТ-ийн эргэн тойронд буй өндөр хүлээлтээс үүдэн дэлхийн удирдагч нар, улс төрчид, үйлдвэрлэгчид болон хөгжлийн мэргэжилтнүүд МХХТ-ийг ихээр ярьж буй нь МХХТ болон хөгжлийн салбарынханд ихээхэн хариуцлага ноогдуулж буй юм. Хамгийн чухал нь МХХТ нь нийгэмд тун өндөр нөлөөтэй бөгөөд байгууллага, олон нийтийн бүх хэсэгт өөрчлөлт авчирдаг, харин үр дүнг нь урьдчилан таахын аргагүй байдаг. Үүнээс үүдээд гарах үр дүн, нөлөөний талаар тодорхой бус байдалтай байдаг.

МХХТ-д суурилсан үйл ажиллагаа нь уламжлалт үйл ажиллагаанаас эрс ялгаатайг ухамсарлах шаардлагатай. Ази, Номхон далайн бүсийн хэд хэдэн улсад зохицуулах болон үнэ тогтоох механизм нь ямар технологи ашиглах, тэр технологийг ашиглан ямар контент дамжуулахыг тодорхойлдог. Бодлогын бүтэц нь мөн ихээхэн төвлөрсөн, технологийг хянах байдалтай байдаг. Ийм төрлийн зохицуулалт нь боломжит МХХТ-той зөрчилддөг. Технологи нь үндсэндээ техник хангамж бус харин удирдлага, үйл ажиллагааны цогц практик юм. Тиймээс үүний ашиглалтыг захирч буй бодлого нь нээлттэй, уян хатан, шинэлэг, хариу үйлдэл үзүүлдэг байх нь их чухал. Бодлогыг байнга хянан үзэж, МХХТ-д суурилсан төсөл, хөтөлбөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн эсэхийг баталгаажуулж байх ёстой.⁵⁵ Модуль 2 нь МХХТ-ийн бодлого боловсруулах болон үйл ажиллагааны талаарх ийм төрлийн нийцлийг авч үзнэ.

Уламжлалт, хуучинсаг Засгийн газруудаас хөгжлийн өргөн хүрээнд боловсруулж, хэрэгжүүлж буй санаачилгууд нь ихэнхдээ “хуучинсаг” байдлыг агуулсан, захиргааны

55. Usha Vyasulu Reddi and Rukmini Vemraju, “Using ICTs to bridge the digital divide,” in ed. Anita Gurumurthy, Parminder Jeet Singh, Anu Mundkur and Mridula Swamy, Gender in the Information Society (UNDP-APDIP and Elsevier, 2006), <http://www.apdip.net/publications/ict4d/GenderIS.pdf>.

шат дараалсан, хүнд суртал бүхий системтэй байдаг. Гэтэл төвлөрсөн байдлаар төсөл, санаачилгуудыг хэрэгжүүлж буй газруудад төслийн удирдлагын загвар нь орон нутгийн хэрэгцээг хангалттай хэмжээнд анхаараагүй байснаас амжилтгүй болдог. Тиймээс орон нутгийн иргэдийг идэвхтэйгээр татан оруулсан орон нутгийн шийдлийг гарган ирэх шаардлагатай байдаг. Модуль 3 нь төр болон иргэдийг хамруулан оролцуулах байдлаар МХХТ-ийн хэрэглээг төлөвлөх, хөгжүүлэх талаар авч үзэх болно.

МХХТ-ийг хэрэглэхэд төслийн удирдлагын уламжлалт хуучин арга баримтлах тохиолдолд юуны өмнө дэд бүтэц нэгдүгээрт шаардлагатай гэж үздэг тул техник хангамж, барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажилтан авах зэрэг дээр илүү ач холбогдол өгдөг. Хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг нь эдгээр захиргааны зардалд явдаг тул төслийн үйл ажиллагаанд багахан эх үүсвэр үлдэх тал бий. Дэд бүтэцтэй зэрэгцэн хүмүүс, сайн чанарын нийгмийн судалгаа, олон нийтийг дайчлах, оролцоог хангах зэрэг үйл ажиллагаа маш хязгаарлагдмал байдлаар явагддаг. Тиймээс тодорхой нэг хөгжлийн төлөөх МХХТ-ийн хүчин чармайлтын технологийн тал нь амжилттай болдог ч иргэдийн амьдралд бараг нөлөө үзүүлэхгүй хэмжээнд байх тохиолдол олон бий. Модуль 7 нь хөгжлийн төлөөх МХХТ-ийн төслийн удирдлагын асуудлыг авч үзэх бол Модуль 8 нь хөгжлийн төлөөх МХХТ-ийн хөтөлбөр, төслүүдийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэхэд туслах юм.

Хөгжиж буй орнуудад МХХТ-ийн хэрэглээг эрчимжүүлэх нь МХХТ-ийн олгож буй боломжуудыг ойлгохоос гадна үүний хязгаарлалтуудыг сайтар ойлгосон байхыг шаардана. Төслийн үйл явцад хэзээ, хаана МХХТ-ийг гол элемент болгон нэвтрүүлэх, эсвэл нэвтрүүлэхгүй байхыг ойлгох нь мөн чухал. МХХТ-ийг ашиглах шийдвэр гарсан бол үүнийг төслийн үйл явцад хэрхэн нэгтгэн оруулах талаар сайтар тунгаан авч үзэх шаардлагатай. Энэ тохиолдолд анхааран үзэх ёстой хэд хэдэн асуудал байдгийг бид дараагийн хэсэг дээр хэлэлцэх болно.

ДҮГНЭЛТ

- Хөгжлийн төлөөх МХХТ-ийн бодлого нь төлөвлөлт, удирдлага, төсөл хэрэгжүүлэх шинэ системийг шаардах бөгөөд энэхүү систем нь иргэд болон эдийн засгийн бусад салбаруудын идэвхтэй оролцоо, хамтын ажиллагааг шаарддаг.
- МХХТ-ийн хэрэглээг эрчимжүүлэхийн тулд үүний боломж болон хязгаарлалтуудыг ойлгох хэрэгтэй.
- Нэгдэн нийлэлт нь зөвхөн технологи нэг дороо цугларах бус харин инженерийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухаан гээд олон салбар, мэдлэгийг нэгдэн нийлүүлэлтийг хэлнэ.
- Нэгдэн нийлэлт нь мөн Засгийн газар нь ээлтэй бодлого, зохицуулалт, санхүүжилт, чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, хувийн хэвшил нь дэд бүтцийг барьж байгуулан, үйлчилгээнд хөрөнгө оруулсан, иргэний нийгэм нь олон нийттэй ажилласан, олон нийт нь санаачилгуудыг өөриймшүүлж, хэрэгжүүлсэн олон талын оролцоот түншлэлийг мөн хэлнэ.



ДАСГАЛ

Танай оронд МХХТ-ийн бодлого боловсруулах үүрэг бүхий байгууллагыг тодорхойл. Тухайн байгууллага нь яам хоорондын эсвэл байгууллага хоорондын зөвлөлдөх бүлэгтэй (ханган нийлүүлэгч болон ашиглагч яамд оролцсон) юу? Хэрэв тийм бол үүний бүрэлдэхүүнийг судлан үзэж хамрагдах ёстой бүх яам/байгууллага хамрагдсан эсэхийг тогтоо.

Хэрэв та МХХТ-той холбоотой хуулийн төсөл боловсруулахад дээр дурдсан зөвлөлдөх бүлэг байхгүй бол энэхүү бүлгийг байгуулахын тулд та ямар баримт, нотолгоог баримтлан санал гаргах вэ (бүлэгт ямар байгууллагууд төлөөлөлтэй байх талаар дурд)?

4.2 МХХТ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ НЬ

МХХТ-ийн үйл ажиллагааг төлөвлөхдөө хамгийн түрүүн гаргах ёстой шийдвэр нь тухайн үйл ажиллагаа нь МХХТ-ийн удирдлагатай байх уу, МХХТ-ийн дэмжлэгтэй байх уу гэдгийг шийдэх явдал билээ. Дээрх хоёр хандлага нь хоёул чухал, гэхдээ МХХТ-ийг хөгжлийн зорилгод ашиглах тохиолдолд эдгээрийн дунд маш том ялгаа байдаг. МХХТ-ийн удирдлага бүхий хандлага нь МХХТ-ийг ашиглан мэдээлэл цаг тухайд нь авах нь орлого олох боломжуудыг бий болгодог ч эдийн засгийн өсөлтийн гол үндэс хэмээх үзэл дээр суурилдаг. Жишээ нь и-мэйлээр үйлчилгээ үзүүлдэг теле-төвүүд, вебсайтыг маркетингийн аргачлал байдлаар ашиглах гэх мэт санаачилга нь энэ чиглэлд хамаарах бөгөөд учир нь эдгээр нь борлуулалтаа нэмэгдүүлэх боломжийг хангадаг. Түүнчлэн хөгжлийн МХХТ-ийн удирдлагатай буюу тэргүүлсэн хандлага нь мэдээлэл, харилцааг сайн орлого хэмээн үзэж үйл ажиллагаагаа явуулдаг. МХХТ-дэмжлэг бүхий хандлага нь тухайн төслийн өмнөө тавьсан хөгжлийн зорилгыг тодорхой болгон, үүний мэдээлэл, харилцаа холбооны хэрэгцээнд нийцэн ажиллаж, МХХТ-ийг тулгарч буй хэрэгцээ болон зорилгыг хангах зардал багатай арга замуудыг эрэлхийлдэг.

Аль ч хандлагыг ашигласан төлөвлөгөө болон бодит байдлын хоорондын ялгаа, орхигдлоос зайлсхийхийн тулд төслийн төлөвлөлтийг анхааралтай гүйцэтгэх нь амин чухал юм. Мөн энэхүү хандлагыг хэрэглэх тохиолдолд өөр өөр оролцогч талуудын философийг төлөвлөлт, хэрэгжилтэд тусгах, анхаарах шаардлагатай. Төлөвлөлтгүйгээр төслийг хэрэгжүүлэхийн үр дагавар нь тэргүүлэх зорилтууд биелэхгүй байх, хөрөнгө оруулалт буруу зүйлд орох болон хүлээгдэж буй үр дүнд хүрэхгүй байх зэрэг болно.

Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг (AusAID)⁵⁶ нь МХХТ-ийн төслүүдийг төлөвлөх, төлөвлөлтийн үйл явцыг тодорхой болгох зорилгоор төлөвлөлтийн бүтэц болон шалгах хуудсыг боловсруулсан байна.

Нэмэлт мэдээлэл 2. МХХТ-ийг ашиглах тэргүүлэх аргачлалын зааварчилгаа

Яагаад?	МХХТ-д суурилсан төслийн хэрэглээ нь тодорхой ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд хийгдэж буй юу?
Хэн?	Ядуурлыг бууруулах зорилгоор тодорхой тогтоосон зорилтот бүлэг байгаа юу?
Хэрхэн?	Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй МХХТ нь зардал, үзүүлэх дэмжлэг, хэрглээ болон засвар үйлчилгээ, өнөөгийн мэдээллийн урсгалтай нийцэх байдал зэргээрээ зохистойд тооцогдож буй юу?
Хэрхэн?	Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй МХХТ нь өргөтгөх, бусад газарт хуулбарлан хэрэгжүүлэх боломжтой юу?
Хэрхэн?	Тохиромжтой дундын зуучлагч нарыг ашиглаж байгаа юу?
Хэрхэн?	Төр-хувийн хэвшлийн түншлэл ямар түвшинд байгаа вэ?
Юу?	МХХТ-ийг ашиглан дамжуулж буй контент нь зорилтот бүлэгт тохирсон, зохимжтой, тэдний хялбар ойлгох хэл дээр байгаа юу?
Хэр хугацаанд?	Төсөл хэдий хугацааны дараа бие даасан хэлбэрт бүрэн шилжих вэ?
Хэр үр дүнтэй?	Гүйцэтгэлийг хэмжих, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулах вэ?
Ямар эрчдэлтэй?	Эрсдлийг удирдах: “Урьдчилан тооцоогүй ямар зүйл гэнэт тохиож болох вэ? болон “Үүнийг удирдахын тулд юу хийх вэ?”

Эх сурвалж: Richard Curtain, Information and Communications Technologies and Development: Help or Hindrance? (Canberra: AusAID, 2004), 29, <http://www.developmentgateway.com.au/jahia/webdav/site/adg/shared/CurtainICT4DJan04.pdf>.

56. Richard Curtain, Information and Communications Technologies and Development: Help or Hindrance? (Canberra: AusAID, 2004), 29, <http://www.developmentgateway.com.au/jahia/webdav/site/adg/shared/CurtainICT4DJan04.pdf>.

Хамтрагчид болон оролцогч талуудтай хамтран эдгээр асуудлуудыг урьдчилан шүүн тунгаан хэлэлцэх нь төслийг төлөвлөж буй этгээдүүд, хэрэгжүүлэгч нарт өмнө нь олон тооны МХХТ-ийн төслүүдийн амжилтгүй болсон тохиолдлуудаас зайлсхийх боломжийг олгоно. Олон тооны МХХТ-ийн чиглэлийн үйл ажиллагааны сургамжууд нь дээр дурдсан хүчин зүйл нь төлөвлөлтийн үе шатны ихээхэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг батлан харуулна.⁵⁷

Нэгдүгээрт, МХХТ-ийн санаачилгууд нь өөрсдийн өмнөө тавьж буй хөгжлийн зорилго болон хүлээгдэж буй үр дүнг тодорхой дурдсан байх ёстой. AusAID байгууллагаас Вуртуал Коломбо⁵⁸ хэмээх төсөл дээр хийсэн шинжилгээгээр МХХТ-ийн төслүүдийн зорилго нь тодорхой, аль нэг МХЗ-той шууд уялдсан байх ёстойг харуулсан байна. Ийм төрлийн тодорхой холбоосыг үүсгэснээр тодорхой үр дүн үзүүлэхгүй төслүүдийг хасах боломжийг олгоно. Тухайн төсөл нь МХХТ-ийн удирдлагатай байх уу, МХХТ-ийн дэмжлэгтэй байх гэдгийг шийдэх нь ач холбогдолтой. Ингэсэн тохиолдолд технологийн сонголт нь хялбар болж, төсөл амжилтгүй болохоос сэргийлнэ.

Хоёрдугаарт МХХТ-ийн үйл ажиллагаа нь нийлүүлэлтэд бус харин эрэлтэд суурилсан байх ба энэхүү эрэлт нь олон нийтээс үүсэн гарах ёстой. Үүний хүрээнд олон нийттэй түншлэл үүсгэх, тухайн төслийг олон нийт өөрийшүүлэх сэтгэгдлийг төрүүлэх хэрэгтэй. Гуравдугаарт, МХХТ-ийн шийдэл нь орон нутгийн нөхцөл байдал, үүнээс үүдэх хязгаарлалтыг тэр дундаа дэд бүтэц, хүртээмж, хамаарах болон хэл зэргийг сайтар харгалзан үзэж, төслийн урт хугацаанд, тогтвортой үргэлжлэх хэмжээнд төлөвлөх ёстой. Хүртээмжийг бий болгох технологийн тоонд компьютерын програм хангамж, техник хангамжийн элементүүд, өгөгдөл болон системийг гадны халдлага, вирус болон бусад аюулаас хамгаалах аюулгүй байдлын систем зэргийг багтаана. Модуль 4, 5 болон 6 нь энэхүү асуудлаар илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Дөрөвдүгээрт, Засгийн газрын зүгээс улс төрийн хүсэл, эрмэлзлэл ихээхэн шаардлагатай. Энэхүү хүсэл зориг нь төсвийн хуваарилалтаас ихээхэн хамааралтай. Эх үүсвэр хязгаартай тохиолдолд олон талын оролцоот түншлэлийг хөгжүүлэх нь тулгараад буй ачааллыг бууруулах боломжит арга байж болно. Олон талын оролцоот түншлэлийг баталгаажуулсанаар Засгийн газар нь тэгш хүрэлцээтэй дэд бүтэц байгуулах, амжилттай төслүүдийг өргөтгөн хэрэгжүүлэх өөрийн үүрэг ролийг багасгах боломжтой. Хувийн хэвшил болон иргэний нийгэм нь контент хөгжүүлэхэд санхүүжилт олох, олон нийтийн оролцоог хангах зэрэг үүргийг өөртөө авах бололцоотой. Мөн стратегийн ач холбогдол бүхий олон улсын болон бүс нутгийн түншлэлийг ч эрэлхийлэх нь чухал. Ховор нөөц эх үүсвэрийг ийнхүү нэгтгэснээр бүх талуудад үр дүнгээ өгөх нийтлэг системийг бий болгоно. Энэ шатан дахь хамтын ажиллагаа нь тодорхой цаг авах ч гэсэн үр дүнг нь бүх талууд хүртдэг.

Тавдугаарт, МХХТ-ийн төсөл нь тодорхой хугацаанд баригдаагүй, эсвэл зорилтот нэг л бүлэг явцуу хандаагүй харин үйл явцад төвлөрсөн байх нь чухал. Хөгжлийн ихэнх төслүүд нь донор байгууллагын санхүүжилттэй бол тодорхой заагдсан зорилттой, хугацаатай байдаг. Хэдийгээр төлөвлөлтийн хүрээнд өргөн хүрээг хамрах боломжгүй нь ойлгомжтой ч МХХТ-ийн хөгжлийн аргачлал хэлбэрээр үр дүнтэй ашиглахын тулд урт хугацааны, тогтвортой хэрэглээ шаардагддаг. Учир нь МХХТ-ийн хэрэглээ нь байгууллага, олон нийтэд хандлагын болон системийн өөрчлөлтийг хийхийг шаарддаг учраас МХХТ-ийг нийгэмд хэвшүүлэхэд тодорхой өмнөтгөл хугацааг шаарддаг. Мөн тохирох технологийн ашиглахтай холбоотой, чадавхийг бэхжүүлэх, хэрэглээг бий болгоход тодорхой хугацаа шаардлагатай байдаг. Эдгээр үйл явц нь үндсэндээ зэрэг явагддаг ч анхлан төлөвлөснөөс хавьгүй илүү хугацааг шаарддаг.⁵⁹ Энэ шалтгааны улмаас төсөл үр дүнгээ үзүүлж эхлэх үед тогтоосон хугацаа дуусаж, донорын санхүүжилт зогсож, төсөл тодорхойгүй байдалд орж эхэлдэг.

57. Accenture, Markle Foundation and UNDP, Creating a Development Dynamic: Final Report of the Digital Opportunity Initiative (2001), <http://www.opt-init.org/framework/DOI-Final-Report.pdf>.

58. Curtain, op. cit., 29.

59. Farrell, op. cit.

Технологийн сонголтыг хэрхэн хийх вэ гэдэг нь мөн л анхаарал татах асуудал юм. Редди болон Дигхе нар технологийн сонголтыг хийхэд зориулсан доорх асуултуудыг боловсруулсан байна:

- Тухайн технологи нь хялбар олдоцтой юу? Технологид зориулан сонгосон биет нөхцөл байдал нь (жишээ нь эрчим хүч гэх мэт) зохистой юу?
- Холболт, хүртээмжийг бий болгохын тулд ямар арга хэмжээг авах вэ? Технологийн төв хаана байрладаг вэ? Тухайн байрлал нь биет байдлаар болон нийгмийн хүрээнд зорилтот (ялангуяа эмэгтэйчүүдэд) бүлэгт аюулгүй, хүрч очиход хялбар, тухайн бүлгийн бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад учруулж болохоор уу?
- Технологийн хүртээмж, холболтыг хэн эзэмшиж, хянаж байдаг вэ?
- Санхүүжилт болон үйл ажиллагааны хувьд нэвтрүүлж буй технологи нь агентлаг болон хэрэглэгчдээс ямар хэмжээний зардал шаардах вэ? Алдагдсан боломжийн өртөг ямар вэ?
- Технологи нь ашиглахад хэр хялбар/хэцүү вэ?
- Технологи нь интерактив уу? Интерактив байдлыг нь хэрхэн хангасан бэ?
- Технологи нь зөөвөрлөх боломжтой юу? Үүнийг байнга, хаана ч ашиглах боломжтой юу эсвэл телевиз гэх мэт технологийн адилаар тодорхой цаг хугацаа, орон зайн хязгаарлалтын хүрээнд ашиглах уу?
- Суулгах, ашиглах, завсар үйлчилгээ хийх, өөрчлөх, шинэчлэхэд технологи нь хэр хялбар вэ?
- Эдгээр үүргүүдийг хэн биелүүлэх үүрэгтэй вэ?⁶⁰

Реддигийн дурдсанаар:

Ихэнхдээ технологийн байрлалын сонголт нь хүртээмжийг бус харин аюулгүй байдлыг харгалзан хийгдэх ёстой байдаг. Олон нийтийн хүрээлэлд технологийг хаана байршуулах нь нийгмийн асуудлуудтай холбогдоно. Хэрэв технологи нь орон нутгийн төрийн байгууллага эсвэл сургууль дээр байршиж буй бол хотын нөгөө захад амьдардаг ядуус үүнийг шимийг хэрхэн хүртэх вэ? Эмэгтэйчүүд, хүүхдүүд тухайн газарт дуртай цагтаа, аюулгүйгээр хүрэлцэн ирэх боломжтой юу? Тухайн байрлал болон технологийн хариуцан ажиллах хүнийг томилох бол тухайн хүний эрх мэдэл ямар байх вэ? Хэрэв технологийг хянах болон ажилуулах эрх нь төрийн байгууллагын ажилтан эсвэл сургуулийн багшид ноогдсон бол энэ нь эмзэг бүлгийн иргэдэд ямар нөлөөтэй байх вэ?⁶¹

Технологийг ашиглах зардал нь мөн хүртээмжийн хэмжээг тодорхойлох томоохон хүчин зүйлс болдог. Улс орнууд нь технологийн нэгдэн нийлэлтийн үр дүнд бий болж буй боломжийг зардал багатай шийдлээр дамжуулан капитал болгон авах ёстой. Бүлэг 2 дээр дурдсанчлан тосгон дахь сайн дурын ажилтан бүхий жижиг мухлаг эсвэл мэдээллийн цэг тухайн тосгоныг дэлхий ертөнцтэй холбоход чухал үүргийг гүйцэтгэх юм. Теле-төв нь олон төрлийн үүргийг биелүүлж болох ба үүний тоонд олон нийтэд мэдээлэл авах боломжийг хангаад зогсохгүй тосгоын хэмжээний хэлэлцүүлэг, үйл ажиллагааны гол төв байж болно.

МХХТ-ийн удирдлагатай эсвэл дэмжлэгтэй төслийг төлөвлөхөд контенттой холбоотой өөр бусад асуудлуудыг харгалзан үзэх ёстой. Редди, Дигхи нар үүнтэй холбоотойгоор доорхи асуултуудыг боловсруулсан байна:

- Хэрэглэгчид хэн болох, тэдний хэрэгцээ ямар болох- жишээ нь хэрэглэгчдийн төрөл, суралцах хэрэгцээ, түвшин ямар вэ? Контент нь хэнд илүү тохирсон бэ?

60. Dighe and Reddi, op. cit., 43.

61. Usha Vyasulu Reddi, "Using ICTs to Remove Barriers in Education" (paper presented at the SEAMEO - UNESCO Education Congress and Expo: Adapting to Changing Times and Needs, Bangkok, Thailand, 27-29 May 2004).

- Агуулга нь ямар ялгаа, хуваагдлыг- нийгмийн, соёлын, эдийн засгийн, шашны, хэл шинжлэлийн болон хүйсийн- контент нь хамаарч буй вэ?
- Контент нь олон нийтэд хамааралтай юу? Жишээ нь контент нь эмэгтэйчүүдэд хамааралтай юу? Контентийг орон нутагт хөгжүүлсэн үү? Контент хөгжүүлэхэд олон нийтийн оролцоо ямар байдаг вэ?
- Контент нь хэрхэн зохион байгуулагдсан бэ?
- Контент нь үнэн зөв, шинэлэг үү?
- Хэрэглэгчдэд зориулан тэдний ашиглах, сонсох болон ойлгох түвшнийг сайжруулах, хялбаршуулах зорилгоор технологийг хэрхэн өөрчилсөн бэ?
- Ганчаарчилсан болон бүлгээр суралцах боломжийг хангасан уу?
- Контент нь интерактив байдал болон эргэх холбоог дэмжиж, бий болгож буй юу?
- Анхан шатны чиглүүлэгч нар болон сургалтын материал зэрэг ямар дэмжих системийг агуулсан, бий болгосон бэ?
- Контентыг засварлах, өөрчлөлт оруулах ямар механизмуудыг бий болгосон бэ?⁶²

МХХТ-ийн төслүүд нь олон шалтгааны улмаас хүндрэлтэй тулгарч болно. Төслийн удирдагч нарын зорьж буй зорилго болон зорилтот бүлгийн зорилгын хоорондын ялгаа нь төслийн амжилтыг бууруулах шалтгаан болдог. Өөр өөр нөхцөл байдал дахь төлөвлөлт болон бодит байдлын зөрүү нь мөн л бүтэлгүйтэх шалтгаан болно. Олон тооны хөгжлийн үйл ажиллагааны хувьд энэ нь бодит зүйл байхыг зэрэгцээ хөгжлийн төлөө МХХТ-ийн чиглэлийн үйл ажиллагааны хувьд боломжит мэдээлэл, технологийн дэд бүтэц, ажлын үйл явц, соёлын хандлага болон эрмэлзлэл, ажиллагсад болон тэдний ур чадвар, төслийн үргэлжлэх хугацаа, удирдлагын бүтэц болон төсвийн хомсдол зэрэг дээр зөрүү үүсэх магадлал өндөр байдаг⁶³. Эдгээр асуудлуудын ихэнхийг нь энэхүү цувралын Модуль 7 дээр хэлэлцсэн байгаа.

Эцэст нь хөгжиж буй орнууд дахь МХХТ-ийн чиглэлийн үйл ажиллагаа нь цар хүрээний хувьд сорилттой тулгардаг. Томоохон хэмжээний системд хөрөнгө оруулалт хийсэн улсууд нь төвлөрсөн төлөвлөлт болон нэвтрүүлэлтийн асуудлаар орон нутгийн хамаарал болон эрэлт, хэрэгцээний хоорондын заагтай хамаатай асуудлуудыг шийдэх шаардлагатай болно. Эдгээр нь бүгд хүртээмж, тэгш байдал болон интерактив байдлын талаар сорилтуудтай тулгарах ба тоон хувьсгалаас үүдсэн технологийн давалгаанаас үүдэлтэй. Эсрэгээр тоон МХХТ-ийн чиглэлийн үйл ажиллагаа нь мөн жижиг хэмжээний, хэрэглэгчдэд тохирсон, олон нийтийн хэрэгцээнд нийцтэй, асуудалд мэдрэмжтэй байх хандлагатай байна. Гэхдээ эдний ихэнх нь үндсэндээ “туршилтын” төсөл хэлбэрээр хэрэгжээд л дуусч байна. Үүнээс үүдээд донорын санхүүжилт дуусахад л эдгээр туршилтын төслүүд дуусч байгаа. Амжилттай хэрэгжсэн бол тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх оролдлого хийгдэж буй ч тухайн нөхцөл байдлыг харгалзахгүй байгаагаас тэр болгон амжилт олохгүй тохиолдол элбэг байна. Ази, Номхон далайн хөгжлийн мэдээллийн хөтөлбөр болон НҮБХХ-ийн дурдсанчлан “МХХТ-ийн олгож буй боломжуудыг нутагшуулах нь харьцангуй хялбар... үндэсний хэмжээнд хийгдэх өөрчлөлтүүд нь бүрэн хэмжээний институцын шинэтгэл, өөрчлөлтийн удирдлагын үйл явцыг шаардах бөгөөд үүнийг эсэргүүцэх, эргэлзэх явдал түгээмэл гардаг” гэжээ⁶⁴.

62. Dighe and Reddi, *op.cit.*, 46.

63. Richard Heeks, *Failure, Success and Improvisation of Information Systems Projects in Developing Countries*, Development Informatics Working Paper Series, Paper no. 11 (Manchester: Institute for Development Policy and Management, University of Manchester, 2002), http://www.sed.manchester.ac.uk/idpm/research/publications/wp/di/di_wp11.htm.

64. APDIP, “ICTs for Governance and Poverty Alleviation in India,” UNDP, <http://www.apdip.net/projects/2003/in>.

Эрдэмтэд болон олон улсын байгууллагуудын зүгээс МХХТ-ийн төслүүдийн амжилт, бүтэлгүйтлийн шалтгаанд хийсэн хэд хэдэн дүн шинжилгээ байдаг.⁶⁵ Зорилтууд, зорилтот бүлгийн тодорхой байдал, дундын оролцогч нар, бодлогын орчин, институцийн бүтэц, гол холбоосууд, үйл явц, чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлт, технологийн сонголт, санхүүжилтийн загвар гээд бүгд амжилт, алдааг тодорхойлох гол хүчин зүйлс болохыг тогтоосон байна.

ДҮГНЭЛТ

- МХХТ-ийн төсөл, хөтөлбөр амжилт олохын тулд МХХТ-д төвлөрсөн бус харин хүмүүст төвлөрсөн хандлага чухал байдаг.
- МХХТ-ийн чиглэлийн төслүүдийн амжилт, бүтэлгүйтлийг тодорхойлогч хүчин зүйлсийн тоонд зорилтууд, зорилтот бүлгийн тодорхой байдал, дундын оролцогч нар, бодлогын орчин, институцийн бүтэц, гол холбоосууд, үйл явц, чадавхийг бэхжүүлэх хүчин чармайлт, технологийн сонголт, санхүүжилтын загвар зэрэг багтана.
- Амжилттай, жижиг хэмжээний санаачилгыг өөр нөхцөл байдалд зүгээр шууд хуулбарлан хэрэгжүүлэх бус өөр бусад зүйлсийг шаарддаг. Хөгжлийн төлөөх МХХТ-ийн хүчин чармайлтыг түгээн дэлгэрүүлэх нь бүрэн хэмжээний институцын шинэтгэл, өөрчлөлтийн удирдлагыг шаардана.



ДАСГАЛ

Танай оронд хэрэгжиж буй МХХТ-ийн нэг хөтөлбөрийг сонгон аваад үүний бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хий. Бодлогын өнцгөөс асуудлыг судлахдаа МХХТ-ийн ямар бодлого нь тухайн хөтөлбөрийг дэмжиж буйг тогтоо. Төлөвлөлт, хэрэгжилтийн түвшнийг судлахдаа хөгжлийн төлөөх МХХТ-ийн зааварчилгааг (нэмэлт мэдээлэл 2) харж хөтөлбөрийг үнэл. Эцэст нь өөрийн тогтоосон дээр үндэслэн тухайн хөтөлбөрт тулгарч буй хязгаарлалтыг тогтоож, хөтөлбөрийг сайжруулах арга замуудыг тодорхойл.



ӨӨРИЙГӨӨ ШАЛГАХ НЬ

Доор дурдсан (Доорхийг үзнэ үү) логик бүтцийг ашиглан доорх даалгавруудыг гүйцэтгэ:

1. Өөрийн боловсруулах онцлог МХХТ-ийн дэмжлэг бүхий хөтөлбөрийг тодорхойлон, хөтөлбөрийн нийтлэг зорилго болон зорилтуудыг тогтоо.
2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоо. Хөтөлбөрийн зорилтууд болон зорилгыг биелүүлэхийн тулд та ямар механизм бий болгох вэ? Ямар бүтцийг үүсгэх вэ? Тэр нь хэрхэн ажиллах вэ?
3. Гүйцэтгэлийг үнэлэхийн тулд ямар арга зүйг ашиглах вэ? Аль шатанд нь гүйцэтгэлийг үнэлэх вэ? Үзүүлж буй нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд нь ямар байх вэ? Үүнийг дараагийн хөтөлбөртөө хэрхэн тусгах вэ?

65. See Karen Eggleston, Robert Jensen, and Richard Zeckhauser, "Information and Communication Technologies, Markets, and Economic Development," in ed. Geoffrey Kirkman, et al., *The Global Information Technology Report 2001-2002: Readiness for the Networked World* (New York: Oxford University Press, 2002), http://cyber.law.harvard.edu/publications/2002/The_Global_Information_Technology_Report_2001-2002; and S. Batchelor and S. Sugden, *An Analysis of infoDev Case Studies: Lessons Learned* (Readings: Gamos Ltd. and Big World, Washington D.C.: infoDev, 2003), <http://www.sustainableicts.org/execsumm.htm>. For case studies from the region, see APDIP, "ICTD Case Studies," UNDP, <http://www.apdip.net/resources/case>. For case studies from India, see Avik Ghosh, *Communication Technology and Human Development: Recent Experiences in the Indian Social Sector* (New Delhi: Sage Publications, 2006).

**МХХТ болон МХЗ - Бодлого боловсруулагчид / хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан менежерүүдэд зориулсан төлөвлөлтийн бүтэц
Үүрэг, үйл ажиллагаа болон нөлөөлөл нэг бүрийн мэдээлэл цуглуулах бүтэц**

Төслийн нийтлэг зорилго, зорилтууд	Хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	Ямар систем, үйл явцыг бий болгох	Хөтөлбөрийн ахиц, гарц болон нөлөөг хэрхэн хэмжих

ТОЙМ

Энэхүү Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академи хэмээх цуврал модулиудын эхний модуль нь хөгжлийн өргөн асуудлыг хамран, тохирох МХХТ-ийг Ази, Номхон далайн хөгжиж буй орнуудын хөгжлийн хурдцыг хурдасгахад бодитоор ашиглах арга замуудыг тусгасан юм.

Модулийн эхний бүлэг нь уншигчдад МХЗ-уудын өргөн хүрээний тойм болон энэхүү зорилтуудад хүрэхэд Ази, Номхон далайн бүс нутагт хэр ахиц дэвшил гарч буйг судлалаа. Энэ бүлэг нь мөн технологийн талаар хязгаарлагдмал мэдлэг бүхий уншигчдад МХХТ, үүнийг хөгжлийн хувьд стратегийн ач холбогдолтой болгож буй шинж чанаруудыг танилцуулсан.

Модулийн хоёрдугаар бүлэг нь МХХТ-ийг МХЗ-уудын салбар бүрээр авч үзсэн. Сонгогдсон кейс судалгаануудыг ашиглан МХХТ-ийн хэрэглээний олон янз байдлыг судлан үзэхийн зэрэгцээ, хөгжлийн гол салбаруудад МХХТ-ийг ашиглахад тулгарах давуу болон сул талуудыг тогтоосон.

Модулийн сүүлийн бүлэг нь МХХТ-ийг хөгжлийн зорилгод зориулан хэрэглэхэд тулгарч буй сорилтуудыг өргөн хүрээнд авч үзсэн. Үүний хүрээнд хөгжлийн төлөөх МХХТ-ийн төсөлд нь “хүмүүсийн төлөө, хүмүүсийн хэрэгжүүлсэн, хүмүүст хамаарах” төсөл байх хэрэгцээг дурдсан. Технологид төвлөрсөн байснаас хүмүүст төвлөрсөн байх нь амжилтад хүрэх гол хүчин зүйл болдог.

ХАВСРАЛТ

НЭМЭЛТ МАТЕРИАЛУУД

МХЗ болон МХХТ

ADB, ESCAP and UNDP. 2007. The Millennium Development Goals: Progress in Asia and the Pacific 2007. Bangkok: ADB, ESCAP and UNDP. <http://www.unescap.org/stat/mdg/MDG-Progress-Report2007.pdf>.

Asia-Pacific Development Information Programme. ICTD Case Studies. United Nations Development Programme. <http://www.apdip.net/resources/case>.

Curtain, Richard. 2004. Information and Communications Technologies and Development: Help or Hindrance? Canberra: AusAID. <http://www.developmentgateway.com.au/jahia/webdav/site/adg/shared/CurtainICT4DJan04.pdf>.

Dougherty, Michael. 2006. Exploring New Modalities: Experiences with Information and Communications Technology Interventions in the Asia-Pacific Region - A Review and Analysis of the Pan-Asia ICT R&D Grants Programme. Bangkok: UNDP-APDIP. <http://www.unapcict.org/ecohub/resources/exploring-new-modalities>.

UNDP. 2005. Regional Human Development Report – Promoting ICT for Human Development in Asia: Realising the Millennium Development Goals. New Delhi: UNDP, Elsevier. <http://www.apdip.net/elibrary#rhdr>.

UN Millennium Project. 2005. Investing in Development: A Practical Plan to Achieve the Millennium Development Goals. New York: UNDP. <http://www.unmillenniumproject.org/reports/fullreport.htm>.

United Nations. 2007. The Millennium Development Goals Report 2007. New York: United Nations. <http://www.un.org/millenniumgoals/pdf/mdg2007.pdf>.

Ядуурлыг бууруулах болон МХХТ

Harris, Roger. 2005. APDIP e-Note 6 – ICTs for Poverty Reduction: Necessary but insufficient. Bangkok: UNDP-APDIP. <http://www.apdip.net/apdipenote/6.pdf>.

Harris, Roger W. 2004. Information and Communication Technologies for Poverty Alleviation. Kuala Lumpur: UNDP-APDIP. <http://www.apdip.net/publications/iespprimers/eprimer-pov.pdf> and http://en.wikibooks.org/wiki/Information_and_Communication_Technologies_for_Poverty_Alleviation.

Kelles-Viitanen, Anita. 2003. The Role of ICT in Poverty Reduction. Finnish Ministry for Foreign Affairs. http://www.etla.fi/files/895_FES_03_1_role_of_ict.pdf.

OECD. 2005. Good Practice Paper on ICTs for Economic Growth and Poverty Reduction. Paris: OECD. <http://www.oecd.org/dataoecd/2/46/35284979.pdf>.

Telecentre.org. <http://www.telecentre.org>.

Боловсрол болон МХХТ

Farrell, Glen and Cedric Wachholz. 2003. Meta-survey on the Use of Technologies in Education in Asia and the Pacific. Bangkok: UNESCO. <http://www.unescobkk.org/index.php?id=1807>.

ICT in Education Unit. e-Library. UNESCO Bangkok. <http://www.unescobkk.org/index.php?id=799>.

InfoDev. 2005. Knowledge Maps: ICTs in Education. Washington D.C.: The International Bank for Reconstruction and Development / The World Bank. http://www.infodev.org/files/2907_file_Knowledge_Maps_ICTs_Education_infoDev.pdf.

Wadi D. Haddad and Alexandra Draxler, eds. 2002. Technologies for Education: Potentials, Parameters, and Prospects. Paris: UNESCO and Washington, D.C.: AED. <http://unesdoc.unesco.org/images/0011/001191/119129e.pdf>.

Хүйс болон МХХТ

Association for Progressive Communications Women's Networking Support Programme. Gender Evaluation Methodology for Internet and ICTs: A learning tool for change and empowerment. <http://www.apcwomen.org/gemkit/home.htm>.

Cummings, Sarah, Henk van Dam, and Minke Valk, eds. 2005. Gender and ICTs for Development: A Global Source Book. Oxford: Oxfam Publishing. <http://publications.oxfam.org.uk/oxfam/display.asp?ISBN=0855985658>.

Dighe, Anita and Usha Vyasulu Reddi. 2006. Women's Literacy and Information and Communication Technologies: Lessons that Experience has Taught Us. New Delhi: Commonwealth Educational Media Centre for Asia and Commonwealth of Learning. http://www.cemca.org/CEMCA_Womens_Literacy.pdf.

Thas, Angela M. Kuga, Chat Garcia Ramilo and Cheekay Cinco. 2007. Gender and ICT. Bangkok: UNDP-APDIP. <http://www.apdip.net/publications/iespprimers/eprimer-gender.pdf> and http://en.wikibooks.org/wiki/Gender_and_ICT.

Эрүүл мэнд болон МХХТ

Economic and Social Commission for Asia and the Pacific. undated. e-Health in Asia and the Pacific: Challenges and Opportunities. Bangkok: United Nations. <http://www.unescap.org/esid/hds/lastestadd/eHealthReport.pdf>.

Rasmussen, Stine Loft. 2007. APDIP e-Note 22 - e-Health Tools for the Asia-Pacific Region. Bangkok: UNDP-APDIP. <http://www.apdip.net/apdipenote/22.pdf>.

Ouma, Stella and M. E. Herselman. 2008. E-health in Rural Areas: Case of Developing Countries. In Proceedings of World Academy of Science, Engineering and Technology, Volume 30 July 2008, 560-566. <http://www.waset.org/pwaset/v30/v30-96.pdf>.

Байгалийн нөөцийн удирдлага болон МХХТ

ITU. 2008. ICTs for e-Environment: Guidelines for Developing Countries, with a Focus on Climate Change. Geneva: ITU. <http://www.itu.int/ITU-D/cyb/app/docs/itu-icts-for-e-environment.pdf>.

Wattegama, Chanuka. 2007. ICT for Disaster Management. Bangkok: UNDP and Incheon: UN-APCICT. <http://www.apdip.net/publications/iespprimers/eprimer-dm.pdf> and http://en.wikibooks.org/wiki/ICT_for_Disaster_Management.

Засаглал болон МХХТ

Bhatnagar, Subhash. 2006. Paving the Road towards Pro-poor e-Governance: Findings and Observations from Asia-Pacific Case Studies. Bangkok: UNDP. <http://www.apdip.net/projects/e-government/capblg/casestudies/Overview.pdf>.

Riley, Thomas B. 2003. E-Government vs. E-Governance: Examining the Differences in a Changing Public Sector Climate. International Tracking Survey Report '03, Number Four. London: Commonwealth Secretariat. http://www.rileyis.com/publications/research_papers/track-ing03/IntlTrackRptMay03no4.pdf.

Энх тайван болон МХХТ

Stauffacher, Daniel, William Drake, Paul Currion and Julia Steinberger. 2005. Information and Communication Technology for Peace: The Role of ICT in Preventing, Responding to and Recovering from Conflict. New York: United Nations ICT Task Force. <http://www.unicttaskforce.org/perl/documents.pl?id=1571>.

НЭР ТОМЪЁНЫ ТАЙЛБАР

Аналог	Өгөгдлийг нэг буюу түүнээс дээш тооны биет байдлаар, үргэлжилсэн хэлбэрээр нь хэмжих болон харуулах үйл явц. Жишээ нь цагийн зүүний байрлал нь цаг хугацааг аналог байдлаар заадаг.
Асинхрон	Цаг хугацааны хувьд нэг зэрэг бус, зохицуулалтгүй байх
Аудио-график	Дуу хоолой, мэдээлэл болон гарфик дүрслэлийг утасны шугамаар зэрэг дамжуулах компьютерт суурилсан технологи
Өргөн нэвтрүүлэг	Радио, телевизийн хөтөлбөрийг олон нийтэд зориулан нэвтрүүлэх үйл явц
Кабелийн телевиз	Уламжлалт нэвтрүүлэгт агаарын долгионоор дамжуулсан дохиог хэрэглэгчид антеннаар хүлээн авч үздэг байсантай харьцуулбал кабелийн телевиз нь телевизийн үйлчилгээг хэрэглэгчдэд зориулан радио давтамжийн дохиог шилэн болон коаксаль кабелиар дамжуулан хүргэх үйл явц юм. FM радио хөтөлбөр, өндөр хурдны Интернет, утас болон бусад телевизийн бус үйлчилгээг кабелиар дамжуулан хүргэж болно.
Хамтран суралцах	Нэг ижил төрлийн бүлгийнхний дунд мэдээлэл солилцох, хуваалцах, санал бодлоо илэрхийлэх замаар суралцах явц. Энэ тохиолдолд газар зүйн хувьд алслагдмал байгаа бүлгийнхийг холбохын тулд компьютерийг ашиглаж болно.
Нийтлэг үйлчилгээний байгууламжууд	Олон нийтэд олон тооны үйлчилгээг зэрэг санал болгодог нийтийн нэг байрлал дахь байгууламж.
Компютерт суурилсан суралцах	Компютерыг боловсролын үйл явцын гол бүрэлдэхүүн хэсэг болгох хэрэглээ. Энэ нь хичээлийн үеэр ангид компьютер ашиглахыг хамруулахын зэрэгцээ, илүү өргөн хүрээнд компьютерийн хичээл заах зорилгод ашиглах тодорхой бүтэц бүхий орчныг хэлнэ. Энэхүү үзэл баримтлал нь суралцах үйл явц нь туслах чанарын элемент болох тохиолдолд (жишээ нь тоглоом тоглох болон вебээр ороход) хэрэглэгдэнэ.
Конференц (асинхрон)	Өөр өөр газарт байгаа, өөр өөр оролцогч нар нэг цаг хугацаанд онлайн байх шаардлагагүй компьютерт суурилсан конференц.
Конференц (синхрон)	Өөр өөр газарт байгаа, өөр өөр оролцогч нар нэг цаг хугацаанд онлайн байх шаардлагатай компьютерт суурилсан конференц.
Компютерын файл дамжуулалт	Нэгээс болон үүнээс дээш тооны файлыг нэг байрлалаас нөгөө байрлалд шилжүүлэх үйл явц. Цахим байдлаар хадгалагдсан файлуудыг компьютерийн диск, хатуу диск, компакт диск зэрэг хадгалах хэрэгслийг ашиглан биетээр, эсвэл харилцаа холбооны аргуудыг ашиглан зайнаас дамжуулах байдлаар зөөвөрлөж болно. Интернетийн хувьд файл дамжуулах протокол (FTP) нь харьцангуй цөөн тооны файлыг нэг компьютерээс нөгөө компьютерт дамжуулах боломжийг олгодог.
Нэгдэн нийлэлт	Бүх текст, аудио, график, анимац, видео зэрэг бүх төрлийн мэдээллийг нэгтгэн, нийтлэг платформоор дамжуулан харилцаа холбооны технологийг ашиглан дамжуулах явц бөгөөд хэрэглэгч нь аль ч хослолыг сонгон хэрэглэх боломжтой байдаг.
Захидал харилцааны материал	Зайн сургалтын шуудангаар дамжуулан хийж байгаа тохиолдолд багшаас материал явуулах, сурагчид хүлээн авч даалгавраа эргүүлэн явуулах болон багш хүлээн авах сургалтын материал.

Компанийн нийгмийн хариуцлага	Байгууллагууд өөрийн хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид, ажиллагсад, хувьцаа эзэмшигчид, олон нийт болон оролцогч талуудад чиглэсэн үйл ажиллагааныхаа нөлөөлөл болон байгаль орчны чиглэлээр хариуцлага хүлээх үзэл баримтлал
Кибер кафе	Интернэт, и-мэйл зэрэг үйлчилгээг үзүүлдэг цэг
Тоон (дижитал)	Мэдээллийг эеоэг буюу эерэг бус гэсэн хоёр байдлаар буюу эерэгийг 1, эерэг бусыг 0 гэсэн тоогоог тэмдэглэх байдлаар үүсгэх, хадгалах, боловсруулах систем. Энэ тохиолдолд өгөгдөл нь 0 болон 1 гэсэн тоон утгаар илэрхийлэгдсэн байдлаар хадгалагдана.
Тоон хуваагдал	Нийгэм, хувь хүмүүсийн хооронд буй мэдлэгт суурилсан эдийн засагт оролцох эх үүсвэртэй болон үүсвэргүйн ялгаа хуваагдал.
Эдийн засаг дахь тоо хэмжээ	Үйлдвэрлэлийн хэмжээ ихсэхэд нэгж бүтээгдэхүүний үнэ буурах үзэгдэл.
Электрон самбар	Энгийн самбар мэт боловч компютертэй холбогдож болох тоног төхөөрөмж.
Электрон мэдээллийн самбар	Хэрэглэгчид нийтэд хамаарах мэдээллийг үлдээж, авч болох програм хангамж бүхий компютер.
Цахим худалдаа	(e-commerce) интернерээр дамжуулан бараа, үйлчилгээг худалдан авах, борлуулах арга зам.
Цахим сургалт	(e-learning) нь багш болон сурагч нь орон зай болон цаг хугацааны хувьд алс, тусгаар байдлаар суралцах үйл явц бөгөөд энэ завсарт буй хязгаарлалтыг онлайн технологийн тусламжаар нөхөх үйл явц.
И-мэйл	(e-mail) мэдээлэл үүсгэх, илгээх, хүлээн авах боломж бүхий хадгадлах, илгээх үйлдэл буюу арга зам
Факс	Цахим хэлбэрт байгаа баримтын хэлбэрийг алдагдуулахгүйгээр мөн ижил байдлаар хүлээн авахад зориулсан тоног төхөөрөмж, үйлчилгээ
Нэгдүгээр үеийн суралцагчид	Ямар нэг гэр бүл дэхь албан ёсны сургуулийн боловсролыг хүртэж буй анхны үе
Мэдээллийн тайлагдалт	Мэдээллийн хэрэгцээ шаардлагыг ойлгох, ямар ч форматаар (хэвлэмэл, онлайн, Интернэт гэх мэт) мэдээлэл хайх, үнэлэх, хэрэглэх арга замыг ойлгосон байдал буюу түвшин.
Интерактив байдал	Хүн болон компютерийн програм хоёрын хооронд харилцан үүсэх яриа болон хамтарсан үйлдэл.
Мултимедиа	Текст, график, видео, анимац болон дууг нэгдмэл байдлаар хэрэглэх компютерийн хэрэглээ. Энэхүү хэллэг нь текст, аудио, зураг, видео болон графикыг интерактив байдлаар дэмжихийг мөн хэлнэ. Эдгээр элементүүдийг компютерт хэрэглэхийн тулд аналог байдлаас тоон хэлбэрт хөрвүүлэх шаардлагатай.
Албан бус боловсрол	Хүүхдүүд болон насанд хүрэгсэд зэрэг тодорхой бүлэгт зориулсан албан ёсны сургуулиас гадуур явагдаж буй зохион байгуулалттай, системтэй боловсролын сонгон авсан үйл ажиллагаа
SMS	Богино мэдээний үйлчилгээ буюу гар утсаар богино текст мэдээл дамжуулах үйл явц (http://en.wiktionary.org/wiki/SMS)

SchoolNets	Сургуулиудын сүлжээ. SchoolNets нь сургуулиудыг Интернэтд холбох замаар сурагчид, багш нар болон сургуулиудын дунд холбоо тогтоож, нөөц эх үүсвэрээ хуваалцах, цахим сургалтыг дэмжих болон сүлжээнд холбогдон ажиллах боломж олгодог сүлжээ.
Синхрон радио	Синхрон гэдэг нь цаг хугацааны хувьд зохицсон буюу зэрэг гэсэн утгатай ба радиогын хувьд өөр өөр байрлалд байгаа ч гэсэн сонсогчид нь хүлээн авч сонсох боломжийг хэлнэ.
Теле-хичээл	Оуютнуудтай виртуал хичээл явуулах систем.
Теле-конференц	Хоёр болон түүнээс дээш тоны хүмүүс өөр өөр байрлал дээрээс яриа, видео болон өгөгдөл дамжуулах байдлаар явагдах интерактив харилцаа холбоо.
Теле-нягтрал	Хүн амын тодорхой нэгжид (ихэнхдээ 100 хүн тутамд) хамаарах суурин утасны шугамын тоо хэмжээ.

СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Энэхүү модуль нь тодорхой нэг хэтийн төлвийг харгалзан үзэж тодорхой зүйлд төвлөрөн бичигдсэн билээ. Сургагч багш нарт зориулсан зөвлөмжүүдийн зорилго нь энэхүү модулийг үндэсний болон бүс нутгийн сургалтын байгууллагууд, хувь хүмүүс өөр өөрийн онцлог нөхцөлд тохируулан хэрэглэхэд зохиогчийн гаргасан санааг бүрэн дамжуулах боломжийг хангах явдал билээ.

“Цуврал модулийн тухай” гэсэн бүлэг дээр дурдсанчлан энэхүү модуль нь олон төрлийн уншигч, суралцагч нарт, өөрчлөгдөж буй өөр өөр нөхцөл байдалд ч өөрийн гэсэн үр дүнгээ өгөхүйц байх зорилготой билээ. Модулийг мөн бүрнээр нь болон хэсэгчлэн, онлайн болон оффлайн байдлаар ч хэрэглэж болохуйцаар бүтээсэн. Кейс судалгаанууд нь бүс болгонд өөр өөр нөхцөл байдлыг харуулан өөрчлөгдөж болох тул орон нутгийн хэрэгцээнд тохируулан модулийг өөрчилж болно. Юуг, хэрхэн заах нь тухайн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай. Энэхүү модулийг ганцаарчлан, бүлгээр болон төрийн байгууллагын хэмжээнд ч судалж болно. Сургалтын үргэлжлэх хугацаа нь модулийн агуулгаас хэр хэмжээнд ашиглан, заахыг тодорхойлох юм.

Эдгээр “зөвлөмжүүд” нь сургагч нарт энэхүү модулийг хэрхэн үр дүнтэйгээр цааш заах талаар нь зарим нэгэн санаа, зөвлөмжийг өгч буй. Сургагч нар нь энд дурдсан байгаа сургалтын төлөвлөгөөг өөрчлөх, шинэчлэх бүрэн боломжтой.

Сургалтын хандлага, стратегийн талаарх цаашдын зааварчилгааг энэхүү Төрийн албан хаагчдад зориулсан МХХТ-ийн суурь мэдлэгийн академ хэмээх материалын дагалдах сургалтын гарын авлага дээр илүү тодорхой өгсөн болно. Энэхүү гарын авлагыг доорх хаягаар үзэж болно: <http://www.unapcict.org/academy>

Сургалтын үр дүнтэй аргачлалын талаарх ерөнхий зааварчилгаа

Энэхүү модуль нь бие даан суралцах болон танхимын сургалтын аль алинд нь зориулагдсан. Тиймээс модулийн бүлэг болгон нь суралцах зорилгуудыг тодорхойлон эхэлж, гол мэдээллийг тоймлох байдлаар төгссөн. Уншигчид эдгээр зорилго болон тоймыг ашиглан өөрсдөө энэхүү модулийн хүрээнд хэр хэмжээнд ахиц дэвшил гаргасан болохоо үнэлж болно. Бүлэг болгон нь мөн хэлэлцэх асуултууд, практик дасгалуудтай байгааг суралцагч болон сургагч нар ч ашиглаж болно.

Кейс судалгаа нь модулийн агуулгын томоохон хэсэг билээ. Эдгээр нь хэлэлцүүлэг болон дүн шинжилгээнд зориулагдсан ялангуяа энэхүү модуль дээр хөндсөн гол үзэл баримтлал, зарчмууд нь амьдрал дээрх төсөл, хөтөлбөрүүдэд хэрхэн хэрэгжиж буйг харуулсан. Уншигч нарт МХХТ-д суурилсан болон дэмжлэг бүхий хандлага, загварыг орон нутгийн нөхцөлд нийцүүлэхийн ач холбогдлыг ойлгуулахад уншигчдад тус болох юм.

Модуль нь насанд хүрэгсэдийн суралцах үйл явц, үүний зарчимд тулгуурлан бичигдсэн. Жишээ нь стресс болон хэт их мэдээллийн ачаалалгүй байх тохиолдолд насанд хүрэгсэд илүү сайн суралцдаг бөгөөд юуг суралцах нь чухал вэ гэдгийг өөрсдөө шийдэх боломжтой байдаг. Бие даан судлах асуултууд болон практик дасгалууд нь уншигчдад өөрийн туршлагыг харьцуулан жиших боломжийг олгоно. Үүний зорилго нь модулийн агуулгыг тэдний ажлын туршлагатай аль болох ойртуулах холбоосыг бий болгох явдал юм. Энэхүү модулийн уншигчид нь өөрсдөө мэдлэг бүхий эх үүсвэр болж болно гэдгийг харгалзан үзсэн юм. Модулийг өөр өөр нөхцөлд, өөр бүлгүүдэд зориулсан сургалтын материал байдлаар ашиглахад сургагч нар үүнийг анхааралдаа авах хэрэгтэй. Жишээ нь сургагч нар нь оролцогчдоос өөрийн туршлага дээрээ үндэслэн өөр жишээг гаргаж, модулийн агуулгыг баяжуулахыг хүсэмжилж болох юм.

Хичээлийн бүтэц

Оролцогч нар, боломжит цаг, орон нутгийн нөхцөл байдал зэргээс хамаараад модулийн агуулгыг өөр өөр цаг хугацааны бүтцэд тохируулан хүргэж болно. Өөр өөр боломжит хугацаанд бүлгүүдээс аль хэсгийг нь оруулах талаар доор дурдлаа. Сургагч нар нь өөрсдийн мэдлэг, тухайн улсын талаарх ойлголт зэрэг дээр үндэслэн сургалтын бүтцийг өөрчилж болно.

90 минутын сургалт

Ахлах тушаалын бодлого боловсруулагч нар: модулийн бүлэг 2-ийн талаар ерөнхий тойм байдлаар танилцуулан хөгжлийн үйл ажиллагаанд МХХТ-ийг хэрэглэх талаарх ойлголтыг бий болгох тэр дундаа кейс судалгаануудаас нэгийг авч судлах.

Төслийн удирдагч нарт: Бүлэг 3-ийн аль нэг хэсгийг хамрахын зэрэгцээ тухайн суралцагч нарт хамааралтай нэг жишээг тайлбарлах.

Хөтөлбөрийн ажилтнууд: хөгжлийн үйл ажиллагаанд МХХТ-ийг ашиглахад тулгардаг сорилтуудыг агуулсан бүлэг 4 болон Бүлэг 3 дээрх кейс судалгаануудын нэгийг дэлгэрэнгүй танилцуулах.

3 цагийн сургалт

Бодлого боловсруулагч нар: Бүлэг 2-ийн ерөнхий танилцуулга, нэг кейс судалгааны талаарх дэлгэрэнгүй тайлбар болон хагас цагийн хугацаанд парктик дасгал хийх.

Төслийн удирдагч нарт: Бүлэг 3 дээрх хамаарах хөгжлийн секторын талаарх ерөнхий танилцуулга, Бүлэг 4-ийн дэлгэрэнгүй танилцуулга болон төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх практик дасгал хийх.

Гурван цагийн сургалтыг 90 минутын хоёр хэсэгт хувааж болох бөгөөд үүнд хамаарах хэсгийн тойм, нэг кейс судалгаа болон бүлгийн практик дасгалтай хийж болно.

Бүтэн өдрийн сургалт (6 цаг)

Дөрвөн удаа 90 минутаар хуваан хийх ба 1-4 дүгээр хэсгүүдийг судлан, дээр дурдсан заах аргуудыг ашиглана.

Гурван өдрийн сургалт.

Хагас өдрийг модулийн бүлэг 2-ийг судлахад зарцуулна. Нэг өдөр хагасыг Бүлэг 3-ийг судлах зориулах бөгөөд хоёрдахь өдөр нь ойролцоо байгаа хөгжлийн төлөөх МХХТ-ийн төсөл дээр очиж ажиллаж болно.

Төсөл дээр ажилласнаар сурсан зүйлс, сургамжуудыг Бүлэг 4-ийн хэлэлцүүлэгт ашиглан гуравдахь өдөр нь гүйцэтгэнэ. Оролцогчид нь кейс судалгаа/төсөл дээр ажиллахтай холбоотой МХХТ-ийг ашиглахад тулгарах өөр өөр сорилтуудыг судлан, тэгсэнээр гурав хоногийн сургалтаас төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн зохистой, зөв хийхийн ач холбогдлын талаар чухал мэдээлэлтэй болно.

Тав хоногийн сургалт.

Тав хоногийн сургалт нь хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж буй хүмүүст хамгийн тохиромжтой. Модуль дахь гол зүйлсийг бүлэг 3, 4 дээрээс судлан, танхимын сургалттай хослуулан ойролцоох төсөл дээр очин кейс судалгаа хийж болно.

Эхний өдрийг бүлэг 2-ийг дэлгэрэнгүй судлахад зориулах ба хагас өдрийг МХЗ-уудын биелэлтийн талаар судлах, салбар хоорондын холбоосыг бий болгоход зориулж болно. Жишээ нь ядуурлыг бууруулах санаачилга нь эрүүл мэнд болон боловсролын асуудалтай хамаарна. Ийм төрлийн холбоосыг бий болгосноор эдгээр нь хөтөлбөрийн төлөвлөлт, бүтэц болон хэрэгжилтэд хэр нөлөөтэйг ойлгоно. Хоёрдахь хагас өдрийг өөр өөр МХХТ-ийг судлахад зориулж болох нь үүний хүрээнд нэгдэн нийлэлт, тоон хуваагдлын асуудлуудыг судлах боломжтой. Ойролцоо хэрэгжиж буй төсөл дээр очиж ажиллах замаар энэхүү өдрийн сургалтыг дуусгаж болно.

2 болон 3 дахь өдрүүдийг МХЗ-уудад хүрэхийн тулд МХХТ-ийг хэрхэн ашиглах талаар судлахад зориулах ба (жишээ нь бүлэг 3) гадуур ажиллахад хагас өдөр зарцуулна. Кейс судалгаануудыг ч мөн нарийвчлан судлана. Төсөл дээр ажилласны дараа дасгал ажил хийх ба үүний хүрээнд төсөл дээрээс ажигласан үйл ажиллагааны гол зарчмууд, төлөвлөлт, бүтцийн гол асуудлуудыг хамруулна.

4 болон 5 дахь өдөр нь дасгалаар үргэлжлэнэ. Бүлэг 4 дээр байгаа материалыг сургагч шууд заах байдлаар өглөөний хэсэг дээр танилцуулах ба дараа нь ганцаарчлан болон бүлгээр ажиллаж дасгал гүйцэтгэнэ. Тав дахь өдөр нь дасгалын үр дүнгээ нийтээр хэлэлцсэнээр өндөрлөнө.

Сургагч нар нь сургалтын танилцуулгын слайдуудыг <http://www.unapcict.org/academy> хаягаар хандаж татаж авах боломжтой.

Сургагч нар нь мөн бүлэг болгоныг хэлэлцүүлэг, ганцаарчилсан болон бүлгийн дасгал хийх байдлаар бүтцийг нь өөрчилж болно. Сургалтад нэг удаад 25-аас дээшгүй тооны оролцогч байх нь зохимжтой.

Сургагч нар нь энд жагсаалтад байгаа нэмэлт унших материалуудыг судлан, тухайн вебсайтаас эх материалыг нь авч судлах шаардлагатай. Мөн бусад хамаарах кейс судалгааг нэмэлтээр ашиглаж болно. Гэхдээ сургагч нар нь танилцуулгадаа эдгээрээс ашигласан материалын эх сурвалжийг заавал дурдах ёстой билээ.

ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

Уша Рани Вияасулу Редди нь Энэтхэгийн Хайдерабад хотын Захиргааны ажилтнуудын коллежийн Хүний хөгжлийн төвийн захирал, Боловсрол судлалын профессороор ажилладаг. 1998 оноос 2006 оны хооронд тэрээр Шинэ Дели хотод байдаг Азид зориулсан хамтын нөхөрлөлийн боловсролын мэдээллийн төвийн захирлаар ажилласан. Түүний ажил нь Ази дахь Хамтын нөхөрлөлийн бүх орнуудыг хамран, албан болон албан бус боловсролын салбарт МХХТ-ийг ашиглах техникийн туслалцааг үзүүлэхэд чиглэгдэж байжээ. 1998 оныг хүртэл тэрээр Хайдерабад хотын Османиа их сургуулийн аудио, видео судалгааны төвийн захирал, профессороор ажилласан. Тэрээр олон тооны эрдэм шинжилгээний, олон улсын судалгааны материалуудыг хэвлэн нийтлүүлжээ.

UN-APCICT- НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв

НҮБ-ын Хөгжлийн төлөөх МХХТ-ын Ази, Номхон далайн бүсийн төв нь (UN-APCICT) НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны (ESCAP) салбар юм. UN-APCICT-ийн зорилго нь хүний, институтын чадавхи бүрдүүлэх, улмаар нийгэм эдийн засгийн хөгжилд МХХТ-ыг ашиглах зорилгоор хорооны гишүүн улсуудын хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд оршдог ба дараах гурван гол багана дээр тулгуурладаг:

1. Сургалт. Бодлого боловсруулагч болон МХХТ-ын мэргэжилтнүүдийн МХХТ-ын мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх, МХХТ-ын сургагчид, институтуудын чадавхийг сайжруулах;
2. Судалгаа. МХХТ-ын хүний нөөцтэй холбоотой аналитик судалгааг явуулах;
3. Зөвлөгөө. Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн хорооны гишүүн болон холбогдох гишүүдэд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт зөвлөгөө өгөх.

UN-APCICT нь БНСУ-ын Инcheon хотод байрладаг.

<http://www.unapcict.org>

ESCAP- АНДБ-ийн Эдийн засаг, Нийгмийн Хамтын Ажиллагааны байгууллага

ESCAP бол НҮБ-ын бүс нутгийн хөгжлийн төв бөгөөд Ази, Номхон далайн бүсийн НҮБ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төв нь болж явдаг. Зорилго нь 53 гишүүн, 9 холбогдох гишүүдийн хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. Тус байгууллага нь глобал, олон улсын түвшний хөтөлбөрүүд болон асуудлуудын хоорондын стратегийг холбох гүүр болон ажилладаг. Энэ нь бүс нутаг дахь засгийн газруудад глобалчлагдаж буй дэлхийд бүс нутгийн давтагдашгүй нийгэм-эдийн засгийн сорилтуудтай тулгарахад өөрийн байр сууриа хадгалж үлдэх, бүс нутгийн хандлагаар тусламж үзүүлдэхэд оршино. Төв нь Тайландын Бангкок хотод байрладаг.

<http://www.unescap.org>

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН МХХТ-ИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙН АКАДЕМИ

<http://www.unapcict.org/academy>

Сургалт нь 8 модультай бөгөөд хөгжлийн төлөөх МХХТ-ын өргөн хүрээний сургалтын хөтөлбөр болж, гол зорилго нь бодлого боловсруулагчдыг чухал шаардлагатай мэдлэг, ур чадвараар хангаснаар үндэсний хөгжлийн зорилгуудад хүрэх, тоон хуваагдлыг арилгахын тулд МХХТ-ын боломжуудыг хөшүүрэг болгон ашиглах явдал юм.

Модуль 1- МХХТ-ийн хэрэглээ болон бодит хөгжлийн харилцан хамаарал

МХЗ-уудыг хангахын тулд МХХТ-г хэрэглэхэд бодлогоос хэрэгжүүлэлт хүртэл гол асуудлууд болон шийдвэрийн санаануудыг онцлон тэмдэглэсэн.

Модуль 2- Хөгжлийн бодлого, үйл явц, засаглалд зориулсан МХХТ

Хөгжлийн төлөөх МХХТ-ын бодлого боловсруулах, засаглал дээр төвлөрөн хөгжлийг дэмжих үндэсний бодлого, стратегиуд, үндсэн бүтцүүдийн талаар чухал мэдээлэл олгоно.

Модуль 3- Цахим засгийн хэрэглээнүүд

Цахим засгийн ойлголтууд, зарчмууд, хэрэглээний төрлүүдийг тайлбарладаг. Энэ нь мөн хэрхэн засгийн газрын систем бий болсон болон зохиомжийн асуудлуудыг тодорхойлдог.

Модуль 4- Төрийн албан хаагчдад МХХТ-ийн хөгжлийн чиг хандлагуудыг танилцуулах нь

МХХТ-ын одоогийн чиг хандлага, ирээдүйн чиглэлд гүнзгий ойлголт өгөх. Энэ мөн МХХТ-ын шийдвэр гаргахад гол техникийн болон бодлогын асуудлыг авч үздэг.

Модуль 5- Интернэтийн засаглал

Интернэтийн хэрэглээ, үйл ажиллагааг зохицуулах олон улсын бодлогууд болон процессуудыг одоогийн үргэлжилж буй хөгжлийг авч үздэг.

Модуль 6- Сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

Мэдээллийн аюулгүй байдлын асуудлууд, чиг хандлагууд, мэдээллийн аюулгүй байдлын стратеги боловсруулах процессуудыг авч үзнэ.

Модуль 7- МХХТ-ийн төслийн удирдлагын онол болон практик

Хөгжлийн төлөөх МХХТ-той холбоотой төслийн удирдлагын үзэл баримтлалуудыг тайлбарлах, түүн дотроо аргууд, үйл явцууд, нийтлэг хэрэглэгддэг төслийн удирдлагын зарчмуудыг авч үзнэ.

Модуль 8- Хөгжлийн төлөөх МХХТ-ийн санхүүжилтийн хувилбарууд

Хөгжлийн төлөөх МХХТ-д болон цахим засгийн төслүүдэд зориулсан санхүүжилтийн сонголтуудыг эрж хайх. Төр-хувийн хэвшлийн түншлэл нь хөгжиж буй орнуудын хамгийн хэрэгтэй санхүүжилт гэж онцлон тэмдэглэгддэг.

Эдгээр модулиуд нь Академийн хамтрагчдийн кейс судалгааны дагуу өөр өөр улс орны бодлого боловсруулагчдын шаардлагатай нийцэх, түүнтэй хамааралтай байх зорилгоор шинэчлэн сайжруулагдсан. Модулиуд нь тухайн улс орны хэл дээр орчуулагдана. Цаашлаад, эдгээр модулиуд нь бодлого боловсруулагчидтай тэдний хамааралтай байдлыг хангах зорилгоор тогтмол шинэчлэгдэж, шинэ модулиудыг 21-р зуунд зориулсан МХХТ-иудыг үндэслэн боловсруулна.

Виртуал Академи (AVA – <http://ava.unapcict.org>)

- Академид зориулсан онлайн зайн сургалтын орчин
- Бүх Академийн модулууд түүн дотроо виртуал лекцүүд, слайдууд болон жишээнүүдэд онлайнаар хандах боломжтой
- Суралцагчдыг өөрсдийн байгаа газраасаа суралцах боломжийг нээж өгсөн

Цахим хамтын ажиллагааны төв (e-Co Hub – <http://www.unapcict.org/ecohub>)

- Хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэг хуваалцах, нөөц материалуудын портал
- Модулаар нөөцүүдэд хялбар хандах боломжийг олгодог
- Хэрэглэгчид онлайн хэлэлцүүлэгт оролцож, e-Co Hub-ийн онлайн бүлгийн гишүүн болж, хөгжлийн төлөөх МХХТ-ын мэдлэгээ нэмэгдүүлэх, хуваалцах боломжтой.

AVA болон e-Co Hub-дахь үйлчилгээг авах сонирхолтой байвал доорхи хаягаар бүртгүүлнэ үү.
http://www.unapcict.org/join_form